

ГАРЧИГ

I. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2011 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ	3
II. ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ	19
III. ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА	37
1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ	37
1.1 Эдийн засгийн өсөлт	37
1.2 Инфляци, түүний өөрчлөлтийн шалтгаан	41
1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханишийн хэлбэлзэл, гадаад валютын урсгал	48
1.4 Гадаад худалдаа	58
2. ИНФЛЯЦИ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН 2011-2012 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ	62
2.1 Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд ашигласан таамаглал	62
2.2 Инфляцийн төсөөлөл	66
2.3 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл	67
2.4 Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тодорхой бус байдал	69
3. МӨНГӨНИЙ БОДЛОГО	70
3.1. Мөнгөний нийлүүлэлт	70
3.2. Зээлийн хүү	86
3.3. Мөнгөний зах	88
3.4. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн тойм /2010 оны эхний хагас жилээр/	91
3.5. Гадаад валютын улсын албан нөөцийн эрсдэлийн удирдлага	97
4. САНХҮҮГИЙН САЛБАР, БАНКНЫ ЗУУЧЛАЛЫН ТОЙМ	98
4.1. Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд	98
4.2. Хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц	100
4.3 Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа	103
4.4 Төлбөр тооцооны систем	104
4.5 Банкны эрх зүйн шинэчлэл	108
5. СТАТИСТИКИЙН ХАВСРАЛТУУД	109

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2010 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд
баримтлах үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт,
Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол
Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, дүнг улирал тутам Улсын Их Хуралд танилцуулж байхыг Монголбанк /Л.Пүрэвдорж/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН

ИХ ХУРЛЫН ДАРГА

Д.ДЭМБЭРЭЛ

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2011 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Төрийн мөнгөний бодлого нь макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангаж дунд болон урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэгдэнэ.

1 Мөнгөний бодлогын зорилтын хүрээнд:

- 1.1 Дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх бодлого баримтална.
- 1.2 Эдийн засгийг хямралд өртөмтгий эмзэг байдалд хүргэхгүй байх, хямралыг сөрөх чадавхийг бий болгох зорилгоор макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын эрүүл, зохистой байдлын шинжилгээг хийж, төрийн мөнгөний бодлогод тусган хэрэгжүүлнэ.
- 1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох зарчмыг баримтална. Монголбанк гадаад валютын дотоодын захад ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх чиглэлээр оролцоно.
- 1.4 Монголбанк санхүүгийн зах зээл дээр урт хугацаатай эх үүсвэр бий болгох арга хэмжээ авна. Үнэт цаасны зах зээлийг өргөтгөн банкны салбарт үүссэн мөнгөн хуримтлалыг эдийн засгийн хөгжилд үр ашигтай ашиглах асуудлыг Засгийн газар, Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран судлаж, холбогдох арга хэмжээ авна.

2 Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид өөрчлөн сайжруулах хүрээнд

- 2.1 Банкны санхүүгийн чадавхийг бэхжүүлж, салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.2 Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлнэ.
- 2.3 Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, өнөөгийн банкны нийтлэг үйлчилгээнээс гадна хөгжлийн болон хөрөнгө

оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг өргөжүүлэн, хөрөнгийн захын хөгжлийг дэмжинэ.

3 Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.

3.2 Монголбанк мөнгөний бодлого, арга хэрэгслийг олон нийтэд ил тод, нээлттэй байлган Төв банкны хариуцлагыг дээшлүүлнэ. Мөнгөний бодлогын зорилт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг тогтмол тайлбарлан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2011 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эдийн засгийн төлөв байдал

Гадаад зах зээлийн орчин эргэн сайжирч, Монголбанк, Засгийн газрын хямралыг даван туулах бодлого үр дүнгээ өгч, манай эдийн засаг 2007-2009 оны хямралаас аажмаар гарч 2010 оны эхний хагас жилд 5 хувиар өсөв. Энэ оны 8 дугаар сарын эцсийн байдлаар нийт мөнгө өмнөх оны мөн үетэй харьцуулахад 42.6 хувиар, хадгаламж 34.5 хувиар, харилцах дансдын үлдэгдэл 73.7 хувиар, зээл 16.7 хувиар, банкуудын гадаад цэвэр актив 62.9 хувиар тус тус өслөө. Инфляци оны эхэнд огцом өссөн боловч Монголбанк, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд өсөлт нь саарч 11.2 хувь болов.

Эдийн засгийн өсөлт 2010 онд 7.5 орчим хувь байх урьдчилсан гүйцэтгэл гарч байна. Энэхүү өсөлтөд аж үйлдвэрийн салбар зонхилж, харин хөдөө аж ахуй өсөлтийг сааруулж байна. 2010 оны өвлийн зудны уршгаар мал аж ахуйн үйлдвэрлэл багасч хөдөө аж ахуйн салбар 25.2 хувиар буурах тооцоо байна. Зудын нөлөөг хасч тооцоолбол эдийн засгийн өсөлт 14 орчим хувьд хүрч ихээхэн өндөр гарахаар байв.

Оюу толгой төслийн ойрын ирээдүйн төлөв, түүнийг дагасан бүтээн байгуулалтын ажил хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, эдийн засгийн бусад салбарын өсөлтийг ч түргэсгэж байна. Мөн түүнчлэн Таван толгойн нүүрсний ордыг ашиглахаар төлөвлөж байгаа нь уул уурхайн салбарт хийгдэх гадаадын шууд хөрөнгө оруулалтыг ойрын жилүүдэд нилээд өсгөнө. Ийнхүү уул уурхайн төслүүд хэрэгжихтэй холбоотойгоор манай улс руу чиглэх валютын дотогшлох урсгал төлбөрийн тэнцлийн хөрөнгийн дансыг өсгөж, төгрөгийн ханшид чангарах дарамт учруулж эхлээд байна. Аж ахуй эрхлэгчид, хэрэглэгчдийн идэвхи дээшилж, хөрөнгийн дотогшлох урсгал хурдан өсч банкны салбар сэргэхийн зэрэгцээ ханшийн хэт чангаралтыг саармагжуулах арга хэмжээ авснаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлж, зээлийн өсөлтийг хурдасгах нөхцлийг бүрдүүлж байна.

Дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ өндөр, гадаад эрэлт сайн байгаа учраас манай экспорт өсөх хандлагатай байна. Экспортын гол зах болох Хятад улсын ДНБ-ий өсөлт эрчимтэй байгаа нь ийм таамаг дэвшүүлэх гол үндэслэлийн нэг юм. Нөгөө талаар, манай улсын импортын өсөлт экспортоос илүү хурдацтай байхаар байна. Уул уурхай, дэд бүтцийн үйлдвэрлэлийн машин, тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэн импортын хэмжээг ихээр өсгөж байна. Мөн түүнчлэн төгрөгийн ханш чангарч буй нь импортын өсөлтийг тэтгэхийн зэрэгцээ

өрхийн орлогын өсөлтийг даган импорт мөн өсч байна. Үүний улмаас урсгал тэнцлийн алдагдал 2010, 2011 онуудад ихээхэн өсч энэхүү алдагдлыг гадаадын шууд хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр байна.

2011 онд эдийн засгийн өсөлтийн хурд бага зэрэг саарах төлөвтэй байгаа нь улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагатай холбоотой байна. 2011 оноос уул уурхайн салбарын гэнэтийн ашгийн татварыг зогсоох нь төсвийн орлогыг ДНБ-ий 2 хувьтай тэнцэх хэмжээгээр багасгана гэж тооцоолж буй, мөн донор орнуудын төсвийн санхүүжилт буурахаар хүлээгдэж байгаа нь төсвийн орлогыг бууруулж байна.

Харин дунд хугацаанд эдийн засгийн өсөлт түргэсч цаашид тогтмолжихоор байна. Энэ боломжийг хэр зөв ашиглах вэ гэдэг нь эдийн засгийн өсөлтийг макро эдийн засгийн зохистой, зөв бодлогоор дэмжиж чадах эсэхээс хамаарах болно. Тиймээс эдгээр таатай боломжийг эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах, хүн амын орлогыг бодитой нэмэгдүүлэх, нийгмийн амьжиргааг дээшлүүлэхэд ухаалагаар ашиглах, үүнд нийцтэй макро эдийн засгийн зохистой, зөв бодлого хэрэгжүүлэх шаардлага бидний өмнө тулгарч байна.

Эдийн засгийн ойрын ирээдүйн төлөв байдалтай уялдуулан мөнгөний бодлогын үндсэн чиглэлд дараах зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

1. Мөнгөний бодлогын хүрээнд

1.1 Дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх бодлого баримтална.

Нийгмийн амьжиргааг дээшлүүлэх, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, дотоод эрэлтийн багтаамжийг нэмэх боломжийг илүү сайн бүрдүүлэх зорилгоор эдийн засгийн дунд хугацааны тогтвортой өсөлтийг бодлогын зорилт болгон дэвшүүлж байна. Эдийн засгийн өсөлт хэлбэлзэл ихтэй байвал нийгмийн амьжиргааны түвшин тууштай дээшлэх нөхцөл бүрдээгүй. Тиймээс Монголбанк мөнгөний бодлогоор эдийн засгийн мөчлөгийн хэлбэлзлийн далайцыг бууруулж дунд хугацаанд тогтвортой, харьцангуй өндөр өсөлтийг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ. Ирэх 2011 онд олборлох үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын өсөлтийг дагаад эдийн засгийн хүчин чадал нэмэгдэнэ. Энэ өсөлтийг хангах хэмжээнд мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилго тавьж байна. Гэвч сонгуулийн угтвар болгон төсвийн

халамжийн болон бусад зардлыг ихээр өсгөн алдагдлыг ихэсгэвэл ийм бодлого хэрэгжүүлэх боломж Монголбанкинд олдохгүй гэдгийг онцлон тэмдэглэе.

Тогтвортой, нам инфляци нь дунд хугацааны эдийн засгийн үргэлжилсэн, өндөр өсөлтийн нэн чухал нөхцөл юм. 140 гаруй орныг хамарсан харьцуулсан судалгаа хөгжиж буй оронд жилийн 10 хувиас бага инфляци нь эдийн засгийн өсөлтийг боогдуулдаггүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байдаг. Бидний дэвшүүлж байгаа инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх зорилт үүнтэй нийцнэ. Ийм инфляци нь эдийн засгийн өсөлтөд онцын сөрөг нөлөөгүйгээр мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангах, нийгмийн амьжиргааг дээшлүүлэх, төгрөгт итгэх итгэлийг хадгалах, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Гэвч инфляци 10 орчим хувьд байсаар байх нь зээлийн эх үүсвэрийн зардлыг хямдруулан хүүг бууруулахад гол саад тогтор болсоор байх сөрөг үр дагавартай байхыг мартаж болохгүй билээ.

Эдийн засгийн өндөр өсөлт, хувийн секторын идэвхжилтэй зэрэгцэн хөрөнгө оруулалтаас илүүтэйгээр хэрэглээг дэмжсэн байдлаар төсвийн зардал ихээхэн нэмэгдвэл инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлж, улмаар эдийн засгийн тогтвортой өсөлтөнд сөргөөр нөлөөлөх аюултай. Нөгөөтэйгүүр хувийн сектор огцом идэвхжиж зээл хэт их хурдтайгаар өсөх, үл хөдлөх хөрөнгийн үнэ хөөрөгдөх зэргээр эдийн засгийн өсөлтийг тогтворгүйжүүлэх, мөчлөгт байдлыг нэмэгдүүлэх эрсдэл ч байсаар байна. Монголбанк эдгээр хүчин зүйлийн өөрчлөлт, хандлагыг анхааралтай ажиглан эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих бодлогодоо тусгаж байх болно.

Манай улсын эдийн засгийн бүтэц, зах зээлийн онцлогтой холбоотойгоор хүнсний гол нэрийн барааны хангамжийн хомсдол, түлш шатахууны гадаад зах зээлийн үнээс шалтгаалан нийлүүлэлтийн шинжтэй инфляци үүсдэг тул нийлүүлэлт, хангамжийг нь тогтворжуулахад ихээхэн анхаарах хэрэгтэй. Мөнгөний бодлогоор ийм төрлийн инфляцид нөлөөлөх боломж хязгаарлагдмал, харин үүний уршгаар үүссэн нийгмийн амьжиргааны доройтлыг халамжийн бодлогоор шийдвэрлэх нь мөнгөний гаралтай инфляцийг бий болгодог тул мөнгөний бодлогыг чангаруулж хувийн секторын өсөлтийг сааруулахаас өөр аргагүйд хүрдэгийг бид мэдэх билээ. Эдийн засгийн хүлээгдэж буй өндөр өсөлт нь зам тээвэр, харилцаа холбооны дэд бүтцийн илүү үр ашигтай, сааталгүй ажиллагааг шаардаж байна. Эдийн засгийн өсөлтийг дунд хугацаанд өндөр, тогтвортой түвшинд, инфляцийг нэг оронтой тоонд байлгахын тулд зам, тээвэр, харилцаа холбоо, шалган нэвтрүүлэх дэд бүтцийн хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зориуд зохион байгуулах нь нэн чухал болж байна.

1.2 Эдийн засгийг хямралд өртөмтгий эмзэг байдалд хүргэхгүй байх, хямралыг сөрөх чадавхийг бий болгох зорилгоор макро эдийн засгийн болон санхүүгийн салбарын эрүүл, зохистой байдлын шинжилгээг хийж, төрийн мөнгөний бодлогод тусган хэрэгжүүлнэ.

Сүүлийн жилүүдэд дэлхийн нийтийг хамарсан санхүү, эдийн засгийн хямралаас дэлхий нийтээр авч буй гол сургамж нь банк, санхүүгийн байгууллагуудад тавигдаж байсан микро-зохистой байдлын шалгуурууд нь гадаад зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийг сөрөх хангалттай хөрөнгө, төлбөрийн чадварыг бий болгож чадахгүй, харин ч санхүүгийн зах зээлд хуримтлагдаж, тогтворгүй байдал үүсгэсэн болж байна. Ихэнх Төв банк санхүүгийн системийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, хямралыг сөрөх чадавхийг нэмэгдүүлэхэд чиглэсэн макро-зохистой байдлын шинжилгээг хөгжүүлж эхлээд байна. Макро-зохистой байдлын шинжилгээ нь санхүүгийн зах зээл, түүний хэрэгсэл болон түүнд оролцогчдын талаарх тоон мэдээлэл, эдийн засаг, санхүүгийн ерөнхий төлөвийг илэрхийлэх макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг ашиглан стресс тест, нөлөөллийн шинжилгээг хийн санхүүгийн системийн эрүүл, тогтвортой байдлыг тодорхойлоход чиглэж байна.

Монголбанк 2011 оноос макро-зохистой байдлын шинжилгээг хийж эхлэн банкны салбарын эрүүл, тогтвортой байдалд үнэлгээ өгч, үр дүнг бодлогын шийдвэр гаргалтад ашигладаг болох зорилтыг тавьж байна. Энэ зорилтын хүрээнд макро эдийн засгийн суурь нөхцөл байдлыг илэрхийлэгч гол үзүүлэлтүүд болох эдийн засгийн өсөлт, гадаад өр, төлбөрийн тэнцлийн байдал, инфляци, төгрөгийн ханш, хүү, төсвийн алдагдал, түүний санхүүжилтийн эх үүсвэр, зээлийн болон хөрөнгийн үнийн шинжилгээг микро зохистой байдлын шинжилгээтэй хамтад нь цогцоор нь хийж, эрсдэлийг байнга тодорхойлж, үр дүнг төрийн мөнгөний бодлогод тусгадаг тогтолцоог бий болгохыг Монголбанк зорьж байна. Гэхдээ энэ нь нэг жилийн дотор нэвтрүүлж хэвшүүлэх хялбар ажил бишийн дээр макро-зохистой бодлого нь эдийн засгийн асуудлуудыг бүхэлд нь хамарсан өргөн хүрээтэй тул Монголбанкнаас гадна холбогдох бусад байгууллага ч ийм бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх нь нэн чухал байна.

1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж уян хатан тогтох зарчмыг баримтална. Монголбанк гадаад валютын дотоодын захад ханшийн огцом өөрчлөлтийг зөөлрүүлэх чиглэлээр оролцоно.

Энэ зарчмыг баримталснаар гадаад зах зээлийн гэнэтийн өөрчлөлтийн дотоодын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, экспортын болон дотоодын үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дэмжих замаар зөвхөн 2011 оны төдийгүй урт хугацааны эдийн засгийн өсөлтөд эерэгээр нөлөөлнө.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш, түүний өөрчлөлтийн хандлага нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэхгүй үед дараах сөрөг үр дагавар, эрсдэлүүд үүснэ. Үүнд:

- зах зээлд тогтворгүй байдлыг үүсгэж төгрөгт итгэх итгэлийг сулруулах;
- гадаад тэнцлийн тогтвортой байдлыг алдагдуулж, ханшийн хямралд нэрвэгдэх эрсдэлийг бий болгох;
- банк, санхүүгийн систем тогтворгүйжих, улмаар банкны системийн хямралыг өдөөх;
- үндэсний үйлдвэрлэлийн ашигт ажиллагаа буурч, өрсөлдөх чадвараа алдах;
- нийгмийн салбар дахь хүндрэл даамжирч, ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх;
- эдийн засгийн тогтвортой өсөлтөд сөргөөр нөлөөлөх зэрэг болно.

Дэлхийн улс орнуудын сүүлийн 30 гаруй жилийн хандлагаас харахад эдийн засгийн урт хугацааны өсөлтийг хангахад валютын уян хатан ханшийн дэглэм онцгой ач холбогдолтой байна. Энэ чиглэлээр хийгдсэн судалгааны үр дүн нь¹ (i) гадаад зах зээлийн огцом өөрчлөлт (шок)-ийн үндэсний эдийн засагт учруулах сөрөг нөлөөлөл нь уян хатан, зохицуулалттай хөвөгч ханшийн дэглэмтэй орнуудад ханшийг тогтмол түвшинд, тодорхой хязгаарт барьдаг орнуудтай харьцуулахад 1.5 дахин бага, (ii) нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт нь жилд дунджаар 0.85 нэгж хувиар өндөр байсан байна.

Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан албан ханш энэ оны эхнээс 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 143.75 төгрөг буюу 9.9 хувиар чангарлаа. Энэ нь манай улсын гадаад худалдааны нөхцөл сайжирч, гадаад тэнцэл тогтворжсонтой холбоотой. Төлбөрийн тэнцэл энэ оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 17.6 хувиар сайжирсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт 5.3 дахин нэмэгдсэнээр хөрөнгө санхүүгийн данс 466 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 3.4 дахин өссөн, 8 дугаар сарын байдлаар гадаад худалдааны алдагдал 7.9 хувиар буурсан, нийт валютын цэвэр орох урсгал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 дахин, үүнээс ам.долларын цэвэр орох урсгал 9 дахин нэмэгдсэн зэрэг макро эдийн засаг, зах зээлийн суурь нөхцөл, хүчин зүйлстэй холбоотой байв.

Манай улсын инфляцийн өнөөгийн түвшнийг гадаад худалдааны гол түнш орнуудынхтай харьцуулахад харьцангуй өндөр байна. Төгрөгийн нэрлэсэн ханш, ялангуяа сүүлийн нэг сарын дотор эрс хурдтай чангарч байна. Цаашид уул уурхайн томоохон төслүүд хэрэгжиж эхэлснээр гадаад валютын орох урсгал үлэмж нэмэгдсэнээр төгрөгийн бодит ханш “тэнцвэрт

¹ Kanda Naknoi, Real exchange rate fluctuations, endogenous tradability, and exchange rate regime, 2006

түвшнээсээ” хэт чангарахад² хүргэж болзошгүй байна. Эдийн засгийн зөвхөн нэг сектороос хамааран төгрөгийн бодит ханш ийнхүү хэт чангарах нь нэг талаас үр ашиггүй импортыг нэмэгдүүлж, төлбөрийн тэнцлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх, нөгөө талаас бусад секторын өрсөлдөх чадварыг бууруулах, цаашид эдийн засаг зөвхөн нэг сектороос хараат болох сөрөг үр дагаварт хүргэх эрсдэлтэй.

Иймд Монголбанк нь төгрөгийн нэрлэсэн ханшийн богино хугацааны хэлбэлзлийг зөөлрүүлэхээс гадна бодит ханшийн хурдацтай өөрчлөлтийг саармагжуулах чиглэлээр хүчин чармайлт тавин ажиллана. Нөгөө талаас, төгрөгийн ханш цаашид чангарах явц “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуулийн хэрэгжилтээс ихээхэн хамаарах болно. Уг хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газрын мэдлийн орлогоос давж хуримтлагдах орлогыг гадаад валютаар шууд төвлөрүүлэх журам тогтоон мөрдүүлэх нь төгрөг чангарах дарамтыг бууруулахад багагүй ач холбогдолтой байх билээ.

Монголбанк төгрөгийн ханш цаашид чангарахын хэрээр манай эдийн засгийн бүтцэд гарах сөрөг үр дагаврыг арилгах, зөөлрүүлэх иж бүрэн бодлого, төлөвлөгөөг цаг алдалгүй боловсруулан хэрэгжүүлж эхлэх саналыг Улсын их хурал, Засгийн газарт тавьж байна.

1.4 Монголбанк санхүүгийн зах зээл дээр урт хугацаатай эх үүсвэр бий болгох арга хэмжээ авна. Үнэт цаасны зах зээлийг өргөтгөн банкны салбарт үүссэн мөнгөн хуримтлалыг эдийн засгийн хөгжилд үр ашигтай ашиглах асуудлыг Засгийн газар, Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран судлаж холбогдох арга хэмжээ авна.

Зээлийн хүү өндөр, хугацаа богино, хэмжээ бага байгаа тул хөрөнгө оруулагчид дотоодын зээлээр бизнесээ далайцтай эхлэх, өргөтгөх боломж хомс байна. Банкны зээлийн дундаж хүү сүүлийн 10 жилд алгуур буурч ирлээ. Эдийн засаг тогтворжин макро эрсдэл багассан, зээл эргэн төлөгдөхөд учрах бэрхшээл хөнгөрсөн, банкуудын үйл ажиллагааны үр ашиг сайжирсан зэрэг олон хүчин зүйл үүнд нөлөөлсөн. Гэвч зээл эргэн төлөгдөх эрх зүйн эрсдэл өндөр хэвээр, инфляци тогтворгүй, хөрөнгийн захын хөгжил хоцрогдож байгаа зэрэг нь хадгаламжийн хүү цаашид буурахгүй, эрсдэлийн марж өндөр байх бодит шалтгаан болж байна.

Зээлийн хүү бууруулах нь эдийн засгийн хөгжлийн нэг чухал зорилт болоод байна. Олон улсын туршлагаас үзэхэд хүү бууруулах арга хэмжээг зах зээлийн зарчимд нийцүүлэлгүй,

² Монголбанкны судалгаагаар 2010 оны эхний хагас жилийн байдлаар төгрөгийн бодит үйлчилж буй ханш тэнцвэрт түвшиндээ байгаа буюу 1.74%-иар илүү үнэлэгдсэн байна (Эх сурвалж: Төгрөгийн бодит үйлчилж буй ханшийн тэнцвэрт түвшний загварчлал, Монголбанк 2010.).

ялангуяа, захиргааны аргаар хэрэгжүүлсний улмаас үүссэн хор уршиг нь өгсөн үр өгөөжөөсөө их байжээ. Зээл, хадгаламжийн хүүг эрсдэлийн түвшинтэй нь нийцтэй байдлаар бууруулах, санхүүгийн зуучлалын үр ашгийг нэмэгдүүлэхийг Монголбанк чухал зорилт болгон дэвшүүлэн ажиллаж байна. Монголбанк, Засгийн газар хамтран дунд хугацаанд зээлийн хүүг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж байна. Уг төлөвлөгөөний хүрээнд санхүүгийн зах зээлийг тогтворжуулах, банкны үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, эрсдэлийг тархаан хөрөнгийн зах руу шилжүүлэх зэрэг зорилт тавьж байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн энэхүү төсөлд тусгасан инфляцийг бууруулах, макро эдийн засгийн зохистой байдлыг хангах, банкны чадавхийг дээшлүүлэх, үйл ажиллагааг нь ил тод болгох зорилтууд ч санхүүгийн зуучлалыг өргөтгөх, үнэ өртгийг нь бууруулахад нэгэн адил чиглэгдэж байна. Мөн “Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай” хууль хэрэгжиж эхэлсэн нь банкны зээлийн эрх зүйн эрсдэлийг бууруулах зарим боломжийг бий болголоо.

Үүнээс гадна банкны үйлчилгээний шимтгэл, хураамжийн зохистой байдалд үзлэг хийх, зээлдэгч гэрээний нөхцлийг ойлгоогүйн улмаас өндөр үнэ төлөхөөс сэргийлэх, алслагдмал нутагт банкны үйлчилгээний өрсөлдөөнийг нэмэгдүүлэх зэргээр зээлийг үнэтэй болгож буй зохисгүй байдлыг арилгуулах ажлыг зохион байгуулна.

Банкуудын эх үүсвэрийн хугацаа богино тул зээлийн хугацааг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байна. Энэ дарамтыг багасгахын тулд хөрөнгийн захыг хөгжүүлэн зээлийг үнэт цаасжуулах хэрэгтэй байна. “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай” хууль 2011 оноос хэрэгжиж эхэлснээр эх үүсвэрийн хугацааг уртасгах зарим боломж гарч буй боловч энэ нь хөрөнгийн захын хөгжлөөс хамаарч байна. Хөрөнгийн зах хөгжвөл өндөр өгөөж эрэлхийлсэн, эрсдэлээ удирдах чадвартай хөрөнгө оруулагчид (хадгаламж эзэмшигчид)-ыг үнэт цаасны зах руу татаж, өрсөлдөөнийг бий болгон хадгаламжийн хүү цаашид буурна.

2010 оны 8 дугаар сарын байдлаар банкуудын хөрвөх чадвар сайтай хөрөнгө нийт активын 37.5 хувьд, Төв банкны үнэт цаасны хэмжээ 654 тэрбум төгрөгт тус тус хүрээд байна. Гадаадаас орж ирсэн санхүүгийн хөрөнгийн хэмжээ нэг жилийн дотор 8.4 дахин нэмэгджээ. Үүний зэрэгцээ нийгмийн даатгалын байгууллага, даатгалын компаниуд мөнгөн хөрөнгийнхөө дийлэнхийг банкны хадгаламжинд байршуулж байгаа нь хөрөнгийн захын тохиромжтой хэрэгсэл дутмаг байгааг илэрхийлж байна.

Банкуудын активын 60 хувь нь зээл байгаа нь системийн татан төвлөрүүлсэн хөрөнгийн 68 хувьтай тэнцэж байна. Банкны бизнесийн олон улсын жишигт үүнийг хэвийн, зохистой

түвшингээс дээгүүр байна гэж үздэг. Зээлийг зохистой түвшнээс хэтрүүлэн олгох нь банкуудад эрсдэл хуримтлагдах үндэс болж, аж ахуйн нэгжүүд, өрхүүдийг өртүүлэн, өрийн дарамтыг ихэсгэж, хөрөнгийн үнэ өсөхөд хүргэж санхүүгийн хямралын хөрс суурийг бэлтгэдэг. Тийм учраас банкны активын бүтцэд чанарын өөрчлөлт авчрах эрсдэл багатай активын олон хэлбэрийг бий болгох, тухайлбал, Засгийн газрын үнэт цаас, өндөр зэрэглэлтэй компаниудын өрийн бичгийг нийтэд нээлттэй арилжаалдаг болмоор байна. Хөрөнгийн захын хоцрогдлын улмаас Засгийн газар төсвийн богино хугацаатай орлого, зарлагын зөрүүг Монголбанкнаас зээлж мөнгө хэвлэн нөхөж, дунд хугацаатай эх үүсвэрийг гадаад захаас хайхыг урьдал болгож байгаа нь манай санхүүгийн зах зээлийн өнөөгийн бодит байдалтай төдийлэн нийцэхгүй байна.

Өнөөдөр банкны салбарт үүссэн хуримтлал төв банкны үнэт цаасанд захаас татагдан үхмэл хэлбэрт орж байгааг анхааран хөрөнгийн захыг хөгжүүлэх ажлыг эрчимжүүлэх хойшлуулашгүй хэрэгцээ бий болоод байна. Энэ шаардлагад нийцүүлэн Монголбанк төв банкны үнэт цаасыг нийтэд арилжаалах боломжийг судлаж, хугацааг нь уртасгах арга хэмжээ авахаар төлөвлөж байна. Энэ арга хэмжээ нь хөрөнгийн захын хөгжилд түлхэц өгөх зорилготой юм. Төсвийн богино, дунд хугацааны эх үүсвэрийн дутагдлыг дотоодын хөрөнгийн захаас санхүүжүүлэх бүх боломжийг ашиглан үнэт цаасны захын хөгжлийг тэргүүлэн удирдаж, манай санхүүгийн тогтолцоог өргөтгөхөд идэвхтэй оролцох цаг нэгэнт болоод байна.

2. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, цаашид өөрчлөн сайжруулах хүрээнд

2.1 Банкны санхүүгийн чадавхийг бэхжүүлж, салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

Монгол улсын санхүүгийн системд банкны салбарын эзлэх байр суурь 95 хувьд хүрсэн нь бодит эдийн засгийн өсөлт, хөгжил банкны салбараас ихээхэн хамаарч буйг нотолж байна. Сүүлийн жилүүдэд дэлхийн санхүү, эдийн засгийн хямралд манай улсын эдийн засаг, санхүүгийн салбар, ялангуяа банкны салбар ихээхэн өртөж, чанаргүй зээл нэмэгдсэнээс банкууд 450 гаруй тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгийнхөө бараг тал хувийг алдаад байна.

Чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 2009 оны 11 дүгээр сард 20.7 хувьд хүрсэн бөгөөд түүнээс хойш буурч 14.3 хувь болсон хэдий ч энэ нь өндөр үзүүлэлт хэвээр байгаа юм. Үүний уршгаар цөөнгүй банк өөрийн хөрөнгийн шаардлагыг хангахгүй байгаа. Банкны салбарт

харилцах, хадгаламж нэмэгдэн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэл эрс өсч буй хэдий ч өөрийн хөрөнгө хүрэлцээгүйн улмаас зээл гаргаж чадахгүйд хүрч, энэ нь зээл олголтыг нэмэгдүүлэн зээлийн хүү бууруулахад ноцтой саад болж байна. Мөн дэлхий дахин санхүү, эдийн засгийн хямралаас сургамж авч, банкны өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах гол нөхцөл гэж үзэн Базелийн стандартаар банкны өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлэн эдийн засгийн өсөлтийн үед банкны санхүүгийн чадавхийг бэхжүүлж байх нэгдсэн ойлголтод хүрч, хэрэгжүүлэх арга хэмжээг авч эхлээд байна. Дотоодын болон дэлхий дахины туршлагаас сургамж авч, банкуудын өөрийн хөрөнгийн шаардлагыг бүрэн хангуулах, цаашид нэмэгдүүлэх нь тулгамдсан зорилт болж байна.

2.2 Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлнэ.

УИХ-аас шинэчлэн баталсан Банкны тухай хуулиар банкны үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, ялангуяа банкны өмчлөгч, удирдлагыг олон нийт, харилцагчдад нээлттэй, ил тод мэдээлж байхаар өөрчилсөн билээ. Банкууд өөрийн цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр хуулийн холбогдох заалтын дагуу мэдээллээ нээлттэй, ил тод мэдээлж эхлээд байгаа боловч зарим банк энэ асуудалд хойрго хандсаар байна. Иймд хуулийн холбогдох шаардлагыг хангуулж, банкнаас олон нийтэд хүргэх мэдээллийг нэмэгдүүлэн ил тод байдлыг хангуулах нь банкны харилцагчид болон зах зээлд оролцогчдын банкинд тавих хяналтыг сайжруулж, улмаар зах зээлийн сахилга батыг дээшлүүлэхэд ихээхэн ач холбогдолтой.

Банкны тухай хуулийн өөр томоохон өөрчлөлт бол зохистой засаглалын зарчмыг нэвтрүүлэх, банкны удирдлагад хараат бус гишүүн байлгахаар хуульчилж өгсөн билээ. Монголбанкнаас Банкны тухай шинэ хуульд нийцүүлэн “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”, “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”, “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ыг шинэчлэн баталсан. “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д өөрийн хөрөнгийн тооцоог оновчтой болгох, үйл ажиллагааны эрсдэлийг тооцдог болох, хөрвөх чадварын эрсдэлийн хяналтыг сайжруулах талаар заалтуудыг шинээр оруулсан. “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д холбогдох этгээдэд Банкны тухай хуулийн хязгаарлалтаас хэтрүүлэн зээл олгосон тохиолдолд зөрчлийн хэмжээгээр эрсдэлийн сан байгуулах, зээлийн

анхны гэрээний нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд хэвийн бус ангилалд ангилах, олон банкинд зээлтэй этгээдийн аль нэг зээл чанаргүйд ангилагдсан тохиолдолд бусад зээлийг төстэй байдлаар ангилах, Банкны тухай хуулийн хязгаарлалтаас зайлсхийх зорилгоор банкууд хуйвалдан олгосон зээлийг хэвийн бус ангилалд ангилах, тодорхой хугацаанд зээл болон хүүгийн төлбөр хэвийн хийгдсэн зээлийг ангилал дээшлүүлэх, банкууд нэг төсөлд хамтран зээл олгосон тохиолдолд зээлийн хяналтыг нэг банк нь дангаараа хариуцаж болох, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу эрсдэлийн сан байгуулахыг зөвшөөрөх зэрэг заалтуудыг шинээр орууллаа. Эдгээр хууль, эрх зүйн заалтуудыг бүрэн биелүүлэх шаардлагыг банкуудад тавьж, хяналт шалгалтыг чангатган хэрэгжилтийг нь хангах ажлыг Төв банк зохион байгуулна.

Мөн Банкны тухай хуульд нийцүүлэн нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчинг боловсронгуй болгох, санхүүгийн нэгдэл бүхий банкуудад холбогдох байгууллагуудтай хамтран нэгдсэн шалгалт хийх ажлыг үргэлжлүүлнэ.

2.3 Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, өнөөгийн банкны нийтлэг үйлчилгээнээс гадна хөгжлийн болон хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг өргөжүүлэн, хөрөнгийн захын хөгжлийг дэмжинэ.

Зээлийн барьцаа хөрөнгийг хурдан шуурхай худалдан борлуулж өр төлбөр барагдуулах нь санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, зээлдэгчдийн санхүүгийн хариуцлагыг өндөржүүлэх, зээлийн эрсдэл багасч зээлийн хүү бууруулах маш чухал хүчин зүйл гэдэг нь олон улсын нийтлэг туршлагаас харагдаж байна. Жишээ нь, Солонгост барьцаа хөрөнгийн асуудал 10 сарын дотор шийдвэрлэгддэг бол Монголд хоёр, гурван жил дамжиж байна. Барьцаа хөрөнгийг худалдан борлуулах шийдвэрийг шүүхээр гаргуулахад хугацаа алдаж, хадгалах, хамгаалахад зардал ихсэх, хөрөнгө үнэгүйдэж зээлийн өр төлбөрийг бүрэн барагдуулах боломжгүй болох байдал үүсгэж байна. Иймд зээлийн барьцаанд тавигдсан үл хөдлөх хөрөнгийг худалдан борлуулах явцыг түргэсгэх, үл хөдлөх хөрөнгөөс бусад хөрөнгийг шүүхийн бус журмаар худалдан борлуулж өр төлбөр барагдуулах чиглэлээр Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлтүүд оруулах шаардлагатай байна. Мөн зээлийн барьцаа хөрөнгийн бүртгэлийг сайжруулснаар санхүүгийн үйлчилгээний хүртээмж нэмэгдэх ба зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний найдвартай байдал сайжирснаар барьцаат санхүүгийн активын үнэ цэнийг илүү бодитой тооцох боломжтой болох юм. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зээл олголт нэмэгдэж, зээлийн хүү бууран, эдийн засгийн өсөлт нэмэгдэх боломжтой.

Дотоодын банкууд манайд эхлээд буй уул уурхайн томоохон төслүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтээр хангах чадваргүй байгаа учир үндэсний компаниуд гадаадын банкуудаас төслийн санхүүжилтыг авч байна. Банкны тухай хууль банкны уламжлалт үйлчилгээг голчлон зохицуулж байгаа учир хөрөнгө оруулалтын болон хөгжлийн банкны үйлчилгээ явуулах эрх зүйн боломж бүрдээгүй байна. Иймд банкны эдгээр үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна. Ингэснээр эдийн засагт нэн шаардлагатай стратегийн болон дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх эх үүсвэрийг дотоодоос дайчлах, гадны эх үүсвэрүүдийг үндэсний банкаар дамжуулах, түүнчлэн эдийн засагт явж буй гадны хөрөнгө оруулалт, зээллэгийг татварын орчинд оруулах, гадаадын эх үүсвэр бүхий мөнгөний урсгалыг хяналтандаа байлгах боломж бүрдэх юм.

Банкны салбарын тогтвортой байдлыг хангах, харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалахын тулд хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх нь ихээхэн ач холбогдолтой. Манай улс 2008 онд банкны салбар хямралд орсонтой холбоотойгоор харилцах, хадгаламжийг төрөөс батлан даасан. Энэ нь зах зээлд оролцогчдод буруу сэдэл төрүүлж, төсөвт алдагдал учруулж болзошгүй байдлыг үүсгэж байгаа тул хадгаламжийн баталгааг хадгаламжийн даатгалаар солих шаардлага тулгарч байна. Холбогдох байгууллагуудаас хадгаламжийн даатгалын хуулийн төслийг боловсруулсан боловч хадгаламжийн даатгалын тогтолцоог нарийн, сайн боловсруулахгүй бол сөрөг нөлөө ихтэй байдаг нь олон улсын туршлагаас харагддаг. Иймд дээрх хуулийн төслийг шинэчлэх шаардлагатай байна. Үүнд банкнаас бусад санхүүгийн байгууллагыг хадгаламжийн даатгалд хамруулах эсэх, хадгаламжийн даатгалын шимтгэлийг банкны санхүүгийн чадвараас хамааруулан тогтоох, даатгагдах хадгаламжийн хэмжээнд дээд хязгаар тавих, нэг хадгаламж эзэмшигчийн олон банкин дахь хадгаламжийг нэгтгэж тооцдог байх, хувийн хэвшлийн банкинд тавих хяналтыг нэмэгдүүлэх, банкны ил тод байдлыг сайжруулах зэрэг асуудлыг шийдэх юм.

3. Төв банкны бусад үйл ажиллагааны хүрээнд

3.1 Монгол Улсын төлбөр тооцооны системийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллана.

Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд дараах ажлуудыг хийнэ. Үүнд:

- “Монгол улсын төлбөр тооцооны систем, цахим төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгөний тухай хууль”-ийн төсөлд холбогдох газруудаас (Хууль зүйн яам, ТТҮЗ-ийн гишүүд гэх мэт) санал авч тусган, УИХ-д өргөн барих;
- Гэнэтийн осол, гамшиг болон бусад давагдашгүй хүчин зүйлсээс шалтгаалан банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” системийн хэвийн ажиллагаанд саатал үүсвэл ажиллагааг нь нөөц төв дээр шилжүүлэн, нийт оролцогчидтой холбогдон ажиллах нөхцөл бүрдүүлэх;
- Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцоог улам боловсронгуй, түргэн шуурхай гүйцэтгэх үүднээс банкуудтай хамтран банк хоорондын бага дүнтэй гүйлгээг онлайн горимд үе шаттайгаар шилжүүлэх;
- Бэлэн бус төлбөр тооцоонд картын хэрэглээг дэмжин банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээг өргөтгөн хамрах гүйлгээний нэр төрлийг (банк хоорондын шилжүүлэг хийх, сүүлийн гүйлгээг харах гэх мэт) нэмэгдүүлэх.

“Монгол улсын төлбөр тооцооны систем, цахим төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгөний тухай хууль”-ийн төслийг УИХ-д оруулан батлуулснаар төлбөрийн системийн оператор, оролцогч, цахим төлбөрийн хэрэгсэл гаргагчдын эрх, үүрэг тодорхой болж, тэдгээрт үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих үүрэг хуульчлагдана.

Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, санхүүгийн тогтвортой байдлыг хангах дэд бүтэц болсон төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангахын тулд банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем, банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны систем, банк хоорондын төлбөрийн картын сүлжээний өдөр тутмын үйл ажиллагааг системийн оролцогчидтой байгуулсан гэрээний үндсэн дээр батлагдсан журмын дагуу явуулж, төлбөр тооцооны систем, түүний оролцогчдын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

Тасралтгүй найдвартай байдлыг хангахын тулд гэнэтийн осол, давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр Монголбанкны төв дэх систем ажиллах боломжгүй болсон нөхцөлд ашиглах “Зайн нөөц төв”-ийг байгуулан Монголбанкны үйл ажиллагааг шилжүүлэх нөхцлийг бүрдүүлээд байна. Цаашид системийн энэ нөөц төвийг нийт оролцогчидтой холбох орчныг бүрдүүлэхээр банкуудтай хамтран ажиллаж байна.

Монголбанкинд банк хоорондын бага дүнтэй гүйлгээг дамжуулж, боловсруулах програм хангамжийг онлайн горимоор ажиллах хүчин чадлыг бий болгосон. Цаашид банкуудын ийм

програм хангамжийг онлайн горимд шилжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах зорилт тавигдаж байна.

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-гээр АТМ, ПОС, ПОБ төхөөрөмжөөр бэлэн мөнгө авалт, бэлэн мөнгө авалтын буцаалт, бэлэн мөнгө авалтын хэсэгчилсэн буцаалт, худалдан авалт, худалдан авалтын буцаалт, үлдэгдэл шалгах гэсэн зургаан төрлийн гүйлгээ хийж байна. Энэхүү нэгдсэн сүлжээний үйл ажиллагааг өргөжүүлэх, төлбөрийн картын ашиглалтыг нэмэгдүүлэн төлбөрийн картаар банк хооронд шилжүүлэг хийх, сүүлийн гүйлгээний жагсаалт харах зэрэг нэр төрлийг нэмэгдүүлэх шинээр нэвтрүүлэхээр ажиллаж байна.

3.2 Монголбанк мөнгөний бодлого, арга хэрэгслүүдийг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах замаар Төв банкны хариуцлагыг дээшлүүлнэ. Мөнгөний бодлогын зорилт, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хүлээгдэж буй үр дүнг тогтмол тайлбарлан таниулж иргэд, олон нийтийн зүгээс түүнд итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Монголбанк 2010 оны 5 дугаар сараас эхлэн “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”-ыг шинэчлэн баталж, мөрдөж байна. Энэ журмын дагуу мөнгөний бодлого, Төв банкны үйл ажиллагааны тухай тогтмол давтамжтайгаар олон нийтэд мэдээлж байна. Монголбанк сар болгон хэвлэлийн бага хурал хийж бодлогоо олон нийтэд хүргэдэг болсноор санхүүгийн захын тодорхойгүй байдал багасч, улмаар эрсдэлийг бууруулан, инфляци, ханшийн хүлээлтийг удирдах боломжийг бүрдүүлж байна. Мөнгөний бодлогод өөрчлөлт эс оруулсан ч яагаад өөрчлөөгүй гэдгээ тайлбарлах нь зах зээлд ялгаагүй чухал дохио болж байна.

Цаашид Монголбанкнаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний эерэг төдийгүй сөрөг нөлөөг олон нийтэд тайлбарлаж, мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлэхийг зорино.

Монголбанк олон нийттэй харилцах харилцааг дэлхийн төв банкуудын жишигт ойртуулахын тулд ОУВС-гийн “Ил тод байдлын зарчмууд”-ыг дунд хугацаанд хэрэгжүүлэх зорилт тавьж ажиллах болно.

Хүснэгт 1. МӨНГӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТААМАГЛАЛ:

2010 оны 3 дугаар улирлаас 2011 оны 4 дүгээр улирал

(өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр)

Мөнгөний тойм	2008-4	2009-4	2010-1	2010-2	2010-3	2010-4	2011-4
	Гүйц	Гүйц	Гүйц	Гүйц	Төл	Төл	Төл
M2 мөнгө	2270	2880	2975	3524	3741	4083	5446
Банкнаас гадуурх мөнгө	329	285	294	349	359	392	522
Харилцах, хадгаламж	1941	2595	2680	3175	3382	3691	4917
Гадаад цэвэр актив	677	1533	1442	1801	2065	2164	2945
Гадаад цэвэр нөөц	747	1694	1535	1894	2158	2257	2938
Төв банкны	808	1652	1514	1683	1947	2046	2727
Арилжааны банкны	-60	41	21	211	211	211	211
Бусад цэвэр зүйл	-70	-160	-93	-93	-93	-93	-93
Дотоод цэвэр актив	1593	1347	1532	1722	1676	1918	2495
Дотоодын цэвэр зээл	2113	1938	2093	2284	2237	2479	3056
ЗГ-ын цэвэр зээл	-522	-717	-629	-599	-704	-614	-601
ББ-аас авах авлага	2636	2655	2722	2883	2940	3093	3657
Бусад цэвэр зүйл	-520	-591	-561	-561	-561	-561	-561

Төв банк

Нөөц мөнгө	633	733	678	839	748	833	1026
Гадаад цэвэр актив	805	1539	1409	1580	1947	2046	2727
Дотоод цэвэр актив	-172	-806	-731	-741	-1199	-1213	-1700
ЗГ-ын цэвэр зээл	-211	-265	-257	-296	-525	-402	-247
Банкинд олгосон зээл	243	198	171	158	153	153	153
Хасах нь: ТБҮЦ	120	393	493	557	644	781	1423
Бусад цэвэр зүйл	-84	-346	-152	-47	-183	-183	-183

Меморандум үзүүлэлтүүд:

M2 мөнгөний жилийн өөрчлөлт (%)	-5.5	26.9	26.4	44.5	40.9	41.8	33.2
Нөөц мөнгөний жилийн өөрчлөлт (%)	18.4	15.8	15.4	11.9	13.5	13.7	23.2
Зээлийн жилийн өөрчлөлт (%)	28.2	0.7	1.9	12.6	11.8	16.5	18.4
M2 мөнгөний үржүүлэгч (нэгжээр)	3.6	3.9	4.4	4.2	5.0	4.9	5.3
Мөнгөний хурдны өөрчлөлт (нэгжээр)	0.88	-0.52				-0.43	-0.32
Бодит ДНБ-ий жилийн өсөлт (%)	8.9	-1.6	7.6	3.4	6.4	7.5	8.2
Гадаад валютын цэвэр албан нөөц /сая ам.доллар/	637.2	1145	1107	1230	1432	1574	2154
Жилийн инфляци (%)	23.3	3.4	7.8	12.6	13.0	15.0	9.0

ТӨРӨӨС МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ТАЛААР 2010 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

(2010 оны эхний 8 сарын байдлаар)


НЭГ. МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

1.1 2010 онд хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг найман хувиас хэтрүүлэхгүй түвшинд байлгаж, цаашид тогтворжуулах, эдийн засгийн мөчлөгийн сөрөг нөлөөг бууруулж, эдийн засгийн өсөлтийг сэргээх бодлого баримтална.

Үндэсний Статистикийн Хорооны мэдээгээр улсын хэмжээнд тооцсон ХҮИ 2010 оны 8 дугаар сард өмнөх сараас 0.7 хувиар өсч, оны эхнээс 9.0 хувиар, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 11.2 хувиар тус тус өсч гарав. Харин Улаанбаатар хотын хэмжээнд ХҮИ 2010 оны 8 дугаар сард өмнөх сараас 1.5 хувиар буурч, оны эхнээс 13.2 хувиар, өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар тус тус өслөө (Зураг 1). Өнгөрөгч сард хүнсний бараа, түүн дотроо махны үнэ өмнөх сараас 8.3 хувиар буурсан ч хувцас, цахилгаан, түлш, боловсролын үйлчилгээний үнэ 10.5-20.4 хувиар өссөн нь инфляцийг нэмэгдүүлэв.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2010 оны 8 дугаар сарын байдлаар хүнсний барааны үнэ 14.1 хувиар өссөн нь жилийн инфляцийн 53.1 хувийг; хувцас, бөс барааны үнэ 10.6 хувиар өссөн нь жилийн инфляцийн 12 хувийг; орон сууц, ус цахилгааны үнэ 11 хувиар өссөн нь жилийн инфляцийн 13.5; харилцаа холбооны үнэ 16.9 хувиар өссөн нь жилийн инфляцийн 6.3 хувийг тус тус бий болгожээ (Зураг 2б). Махны үнийн өсөлт инфляцийн 42.3 хувь, оны эхнээс тооцсон инфляцийн 6.8 хувийг бүрдүүлсэн байна (Зураг 2а).

Зураг 1. Жилийн инфляци




Эх үүсвэр: YCX

Зураг 2а. Оны эхнээс тооцсон инфляцийн задаргаа



Зураг 2б. Инфляцийн задаргаа³



Эх сурвалж: УСХ

Эхний 2 улиралд махны үнэ бусад зудтай жилүүдтэй харьцуулахад илүү хэмжээгээр өссөн⁴ нь нийт малын 13.0 хувь хорогдсон, махны нөөцийг өмнөх жилүүдээс 30 гаруй хувиар бага бэлтгэсэн зэргээс шалтгаалав. Үүнээс шалтгаалж инфляци 2010 оны эхний хагаст нийлүүлэлтийн хүчин зүйлс болон төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний үнийн өсөлтөөс голлон шалтгаалж хурдтай нэмэгдэж байгааг тайлбарласан албан бичгийг Монголбанкнаас УИХ болон Засгийн газарт холбогдох танилцуулга, тооцооллын хамт хүргүүлсэн. Засгийн газраас хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтолцоог боловсронгуй болгох, энэ чиглэлээр хувийн хэвшилтэй хамтран ажиллаж, арга хэмжээ авсны үр дүнд 6 дугаар сараас махны үнэ буурч эхэлсэн. Засгийн газраас хүнсний гол нэрийн барааны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, нийлүүлэлтийн тогтолцоог үр ашигтай болгох, хангамжийг сайжруулах талаар хөтөлбөр боловсруулан ажиллаж байгаа нь ийнхүү үр дүнгээ өгч байгаа тул махны үнэ цаашид үргэлжлэн буурах боломжтой байна.

Хэрэв махны үнийн өсөлтийг хасвал 2010 оны 8 дугаар сарын байдлаарх жилийн инфляци Улаанбаатар хотын хэмжээнд 7.5 хувьтай байна.

³ Оны эхнээс тооцсон инфляци.

⁴ Үүнийг 2000, 2003 зэрэг зудтай жилүүдийн статистикийг ашиглан харьцуулав.

*Хүснэгт 1. Инфляци, мөнгөний нийлүүлэлтийн үндсэн үзүүлэлт
(хугацааны эцэст, өөрөөр заагаагүй бол тэрбум төгрөгөөр)*

Үзүүлэлт	VIII.2008	VIII.2009	VIII.2010	$\frac{VIII.2010}{VIII.2009}$
Инфляци, жилийн өөрчлөлт				
УБ хотын	33.7	-0.9	11.1	
Улсын	34.2	0.6	11.2	
Мөнгөний нийлүүлэлт, тэрбум төгрөг	2576.8	2563.9	3657.04	42.6%
M1 мөнгө	642.2	597.14	932.03	56.1%
Бараг мөнгө	1934.6	1966.8	2725.3	38.6%
Нөөц мөнгө	529.0	695.0	738.6	6.3%
Зээлийн хүү, жилийн				
Төгрөгийн зээлийн нэрлэсэн хүү	21.8%	23.7%	20.4%	
Валютын зээлийн нэрлэсэн хүү	14.4%	17.6%	14.0%	

Эх үүсвэр: УСХ, Монголбанкны сарын статистикийн мэдээлэл

Засгийн газар энэ оны 2 дугаар сараас Хүний хөгжил сангаас иргэн бүрт бэлэн мөнгө олгох ажлыг эхлүүлэх шийдвэр гаргаж, эхний ээлжинд өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон бага насны хүүхдүүдэд 70.0 мянган төгрөгийг бэлнээр олгосон нь инфляцийн өсөлтийг өдөөсөн өөр нэгэн хүчин зүйл болов. Энэ арга хэмжээ цагаан сартай давхцан иргэдийн хэрэглээг өсгөн нийлүүлтийн дутагдалтай байсан орчинд үнийн өсөлтийг улам хурдасгаж үнэ өсөх хүлээлт бий болгосон. Монголбанк 2010 оны 5 дугаар сард инфляцийн хүлээлтийг бууруулах зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлэн 11 хувьд хүргэсэн. Мөн 2010 оны 4 дүгээр сард бодлогын хүүний нөлөөлөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ТБҮЦ-ны дуудлага худалдааны зарчимд өөрчлөлт оруулсан билээ.

Монголбанкны энэхүү бодлого нь зөвхөн эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамтыг сөрөх алхам байсан бөгөөд цаана нь эдийн засгийн өсөлтийг сэргээх орон зайг нөөц мөнгөний болон ТБҮЦ-ны хэмжээгээр дамжуулан үлдээж байв. Ялангуяа бизнесийн үйл ажиллагаа идэвхждэг 2-р улиралд нөөц мөнгөний жилийн өсөлтийг 39 хувьд хүргэн нэмэгдүүлж байсны үр дүнд M2 мөнгөний нийлүүлэлт 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 3.6 их наяд төгрөгт хүрч 42.6 хувиар өслөө.

Зээлийн өрийн үлдэгдэл 3.0 их наяд төгрөгт хүрч 16 хувиар өссөнөөр зээлийн тасалдал бүрэн ариллаа. Ийнхүү мөнгөний нийлүүлэлт болон зээлийн хэмжээ түүхэнд байгаагүй хамгийн өндөр түвшинд хүрээд байна. Эдийн засгийн өсөлт хамгийн сүүлд гарсан статистик мэдээний хугацаа буюу 2010 оны 2 дугаар улирлын байдлаар 5 хувьд хүрч өслөө.

1.2 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш макро эдийн засгийн суурь нөхцлөөр тодорхойлогдон, уян хатан тогтоож байх зарчмыг баримтална. Дэлхийн санхүүгийн зах

зээлийн болон гадаад худалдааны нөхцлийн огцом өөрчлөлтийг төгрөгийн гадаад валюттай харьцах уян хатан хани, мөнгөний бодлогын арга хэрэгслээр дамжуулан зохицуулж, гадаад валютын албан нөөцийг хамгаална.

2010 оны эхний 8 сарын байдлаар Монгол Улсын гадаад худалдааны нөхцлийн индекс өнгөрсөн оны мөн үеэс 17 хувиар сайжирч, барааны гадаад худалдааны алдагдал 7.9 хувиар буурч, валютын төлбөртэй экспортын хэмжээ импортоос 4.1 нэгж хувиар илүү хурдацтай өссөн, гадаадын шууд хөрөнгө оруулалт эхний хагас жилийн байдлаар өмнөх оны мөн үеэс 5.3 дахин нэмэгдсэн зэрэг нь төгрөгийн ханшийг алгуур чангаруулах чиглэлд үйлчилж байна.


Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс



Эх сурвалж: Монголбанк


Дотоодын захад валютын цэвэр урсгал ийнхүү өссөнөөр Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах албан ханш 2010 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар оны эхнээс 7.6 хувиар буюу 113 төгрөгөөр чангарч, 1329.86 төгрөгт хүрэв.

Зураг 4 Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөн



Эх сурвалж: Монголбанк


Зураг 5 Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдрийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг огцом хэлбэлзүүлэхгүйгээр уян хатан чангаруулах, огцом хэлбэлзэх нөхцөл үүссэн тохиолдолд хэлбэлзлийн хурдцыг сааруулах, захын тогтвортой байдлыг хангах, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх бодлогыг тус тус баримтлав. Төгрөгийн ханшийг ийнхүү уян хатан чангаруулах бодлого баримталсан нь нэг талаас инфляцийн хүлээлт болон суурь инфляцийг өсгөхгүй байх, нөгөө

Гадаад валютын дотогшлох цэвэр урсгал 2010 оны 4 дүгээр сараас эхлэн 650 сая ам.доллараар нэмэгдсэнтэй⁵ уялдан төгрөгийн ам.доллартай харьцах ханш огцом чангарах нөхцөл үүссэн. Иймд Монголбанкнаас захад оролцогчдын хүлээлтийг



ТОГТВОРЖУУЛАН ОГЦОМ ХЭЛБЭЛЗЛИЙГ

зөөлрүүлэх зорилгоор тайлант хугацаанд банк хоорондын захаас 237.6 сая ам.долларыг худалдан авсан. Ийнхүү банк хоорондын зах дээрх илүүдэл ам.долларыг татсанаар валютын захын эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлж, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэн, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлсэн болно.

Гадаад валютын албан нөөц 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 1,608.65 сая ам.долларт хүрсэн нь оны эхнээс 21.1 хувиар буюу 280.1 сая ам.доллараар, өнгөрсөн оны мөн үеэс 1.7 дахин буюу 646.0 сая ам.доллараар тус тус нэмэгджээ. Тайлант хугацаанд албан нөөц нэмэгдэхэд Монголбанкны гадаад валютын дуудлага худалдаагаар худалдан авсан 237.6 сая ам.доллар, АНУ-ын тусламжийн 10.0 сая ам.доллар, “Оюу-Толгой” төслийн 50.0 сая ам.долларын урьдчилгаа орлого (зээл), банкуудын дансны өөрчлөлтийн 187.9 сая ам.доллар зэрэг голлох урсгалууд эерэгээр, Засгийн газрын “Алтны санхүүжилтын бонд”-ын 75.0 сая ам.долларын эргэн төлөлт сөргөөр нөлөөлсөн байна.

Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль хүчингүй болох хүртэлх хугацаанд Монголбанк нь дотоодын зах зээлээс худалдан авах алтны үнийн хөнгөлөлтийг хэвээр хадгалах бодлогыг баримтлан алт худалдан авч байна. 2010 оны эхний 7 сарын байдлаар Монголбанк 968.5 кг алт худалдан авсан нь өмнөх оны мөн үеэс 1.7 тонн буюу 64 хувиар буурсан үзүүлэлт юм. Тайлант хугацаанд Монголбанкинд худалдан авсан алтны хэмжээ нь тухайн хугацаанд олборлосон алтны 28 хувийг, Бороо гоулд ХХК-ийн олборлосон алтыг хассаны 80 хувийг тус тус эзэлж байна.

⁵ Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.1 дахин өссөн.

1.3 Гадаад валютын дотоод дахь зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлж, төгрөгийн ханши уян хатан тогтох нөхцлийг сайжруулна.

Энэхүү зорилтын хүрээнд эрх зүйн орчныг сайжруулах, банк хоорондын захыг идэвхижүүлэх, захын нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, зах зээлд оролцогчдын мэдлэг чадварыг сайжруулах чиглэлээр дараах ажлыг гүйцэтгэлээ:

(i). Гадаад валютын банк хоорондын захын арилжаанд цахим системийг нэвтрүүлэх

Монголбанк нь банк хоорондын валютын арилжааг идэвхижүүлэх, хөгжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор банк хоорондын валютын арилжааг Блүмберг системээр дамжуулан хийх боломжийг судалж, тус байгууллагатай “санамж бичиг”-ийг 2008 онд байгуулан, Блүмберг системд Монголын банк хоорондын валютын арилжааны цахим цонх “MGFX”-ийг 2009 онд үүсгэсэн билээ.

Уг цонхыг ашиглах тухай “Хамтран ажиллах гэрээ”-г Блүмберг системийг ашигладаг есөн банктай байгуулж, MGFX цахим цонхыг ашиглах сургалтуудыг зохион байгуулснаар уг цахим цонхыг банк хоорондын арилжаанд 2010 оны 2 дугаар сарын 3-ны өдрөөс ашиглаж эхэлсэн. 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар уг цонхыг ашиглан Монголбанкинд ХХБ, ХААН банкууд давхардсан тоогоор нийт 1.27 тэрбум ам.долларын хадгаламжийг байршуулаад байгаа бөгөөд энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 610.9 сая ам.доллараар өссөн үзүүлэлт юм. MGFX цахим цонхыг ашиглан арилжааны банкууд өөр хоорондоо 126.4 сая ам.долларын валютын арилжаа хийсэн байна.

(ii). “Валютын арилжааны мэргэжилтнүүдийн гуравдугаар зөвлөлгөөн”-ийг зохион байгуулж, түүгээр хани, үнийн эрсдэлээс сэргийлэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг нэвтрүүлэх асуудлыг хэлэлцүүлж, гарсан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

Монголбанк 2010 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр валютын арилжааны мэргэжилтнүүдийн ээлжит гуравдугаар зөвлөлгөөнийг зохион байгуулсан. Зөвлөлгөөнөөр зах зээлд оролцогчид дараах асуудлыг хэлэлцсэн:

Төгрөгийн спот захыг хөгжүүлэхэд банк хоорондын захын гүйцэтгэх үүрэг ба арилжааны MGFX цахим цонхны хэрэглээ;

Ханшийн эрсдэлээс сэргийлэх санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийг нэвтрүүлэхэд тулгарч буй бэрхшээлүүд, тэдгээрийг шийдвэрлэх арга замууд;

“Валютын тухай” шинэ хуулийн төсөлд валютын зах зээлийн зохицуулалтыг тусгасан байдал.

Тус зөвлөлгөөнөөр хямралын дараах эдийн засгийн өсөлтийг дэмжих, гадаад валютын зах зээлийг хөгжүүлэх, түүний үр ашгийг сайжруулах чиглэлээр 2010 онд Монголбанк, банкууд, төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдийн зүгээс авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээнүүдийг тохиролцсон.

Зөвлөлгөөнөөр хэлэлцсэн нэгдүгээр асуудлын үр дүнд банкууд MGFХ цахим системээр дамжуулан ханшийн мэдээлэл болон банк хоорондын арилжааг тогтмол хийж байгаа бол хоёрдугаар асуудлын хүрээнд Монголбанк санхүүгийн үүсмэл хэрэгслийг (своп, форвард хэлцэл) банк хоорондын захад нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байна. Мөн Сангийн яам дотоодын зах зээлд Засгийн газрын үнэт цаасыг тогтмол арилжаалах үйл ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр санхүүгийн үүсмэл хэрэгслүүд бий болж, аж ахуйн нэгжүүд ханшийн эрсдэлээс хамгаалах бүтээгдэхүүнийг ашиглаж эхлэх боломж бүрдэх юм.


(iii). Валютын тухай хуулийн төслийг УИХ-д хүргүүлэх

“Валютын тухай” хуулийг шинэчлэн найруулж буйтай холбогдуулан хуулийн төсөлд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, арилжааны банкуудын саналыг авч тусган 2010 оны сүүлийн хагаст багтаан УИХ-д хүргүүлэхээр ажиллаж байна.

1.4 Банкны салбарт үүссэн зээлийн тасалдлыг зогсоож, банкны салбараас зээл олгох, зээл авах идэвхийг сэргээх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Эдийн засагт зээлийн тасалдал 2009 оны 5 дугаар сард дээд цэгт хүрч харин 2009 оны 6 дугаар сараас эхлэн аажмаар сэргэж байна. Зээлийн өрийн үлдэгдлийн жилийн өсөлтийн хувь 2010 оны 8 дугаар сарын байдлаар 16.7 хувь болж нэмэгдлээ. Зээлийн нэрлэсэн хүү 2009 оны 3 дугаар улирлаас буурах хандлагатай байсан бол 2008 оны 4 дүгээр улирлаас хойш өсч байсан зээлийн бодит хүүгийн түвшин инфляцийн нөлөөгөөр 2010 оны 1 дүгээр улирлаас эхлэн буурч байна. Алт, зэс, ноолуурын үнэ харьцангуй өндөр, Оюу толгойн гэрээ хүчин төгөлдөр болсноор экспортын орлого, улмаар санхүүгийн хөрөнгө оруулалт, банкуудын гадаад цэвэр актив нэмэгдэж зээл олголт идэвхжих нөхцөл бүрдэж байна.


Зураг 7. Зээл олголт



Эх үүсвэр: Монголбанк

Зээл олголтыг идэвхжүүлэх үүднээс Монголбанк ТБҮЦ-ны хэмжээг бууруулж, ирүүлсэн саналын 80.3 хувийг хангаж ажиллав. Ялангуяа 1 дүгээр улиралд банкуудын ирүүлсэн саналын 50-80 хувийг хангах бодлого баритлав (Зураг 8). 2010 он гарсаар банкууд 7 хоногийн хугацаатай ТБҮЦ-нд дунджаар 363.6 тэрбум төгрөг байршуулах санал ирүүлж байснаас Монголбанк дунджаар 292 тэрбум төгрөгийн үнэт цаас арилжаалж байв.

Зураг 8. ТБҮЦ-ны арилжааны саналын хангалт



Эх үүсвэр: Монголбанк

Харин 12 долоо хоногийн хугацаатай ТБҮЦ-нд дунджаар 77.1 тэрбум төгрөг байршуулах санал ирүүлж байснаас Монголбанк 40.6 тэрбум төгрөгийн үнэт цаасны буюу саналын 52.7 хувийг ханган ажилласан байна.

Хөгжлийн бодлогын хамтын ажиллагааны хэлэлцээрийн үр дүнд ХБНГУ-ын Засгийн газраас Монгол улсад хэрэгжүүлэх “Санхүүгийн салбарыг хөхүүлэн дэмжих-Ипотекийн барьцаат зээлийн системийг дэмжих” төслийн хүрээнд 4.8 сая еврогийн хөнгөлөлттэй зээл, 0.5 сая еврогийн буцалтгүй тусламжийг Монголбанкаар дамжуулан МИК-д олгохоор тохиролцон тайлант онд Германы Сэргээн Босголт Хөгжлийн банк, Монгол улсын Засгийн газар зээлийн гэрээнд гарын үсэг зурав.

Төрийн албан хаагчдад олгох орон сууцны урт хугацаат зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор УИХ-ын 2009 оны 77 дугаар тогтоол, Засгийн газрын 2009 оны 321, 372 дугаар тогтоолууд, Сангийн сайдын 2010 оны 50 дугаар тушаалыг тус тус үндэслэн 30.0 тэрбум төгрөгийн ЗГҮЦ-ыг арилжаалахаар нэг талаас Сангийн яам, нөгөө талаас Монголбанк харилцан тохиролцож гэрээ байгуулав. 2010 оны 7 дугаар сарын байдлаар энэхүү гэрээний хүрээнд нийт 30.0 тэрбум төгрөгийн Засгийн газрын 7.8 хувийн хөвөгч хүүтэй үнэт цаасыг худалдаж авсан. Энэ ажлын хүрээнд төрийн албан хаагчдад зээл олгохоор шийдвэрлэсэн. Нийт 1409 төрийн албан хаагчдад 51.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэснээс 926 иргэнтэй зээлийн гэрээ байгуулаад байна. Зээл олгохоор шийдвэрлэсэн төрийн албан хаагчдаас 915 нь банкны зээлийн барьцаанд байгаа орон сууцнаас сонгожээ.

Ажлын байр нэмэгдүүлэх төслийн зээл. Азийн хөгжлийн банкны "Ажлын байр нэмэгдүүлэх 1290-МОН төсөл" амжилттай хэрэгжиж дууссан бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгч, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2000 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 157 дугаар тушаалаар батлагдсан “Азийн хөгжлийн банкны Ажлын байр нэмэгдүүлэх төслийн хүрээнд эргэн төлөгдөх эх үүсвэрээс зээл олгох журам”-ын дагуу төслийн эх үүсвэрээс банкуудад зээл олгон ажиллаж байна. Сүүлийн 1 жилийн хугацаанд уг төслийн хүрээнд Голомт, Эрэл, Хас, Улаанбаатар банкуудад зээл олгов. Монголбанк ажлын байр нэмэгдүүлэх төслийн эргэлтийн сангийн эх үүсвэрээс 2010 оны эхний 8 сард нийт 421.3 сая төгрөгийн зээлийг төсөлд оролцогч банкуудад дамжуулан олгож, 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 1.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх ХБНГУ-ын Сэргээн босголт, хөгжлийн банкны эх үүсвэрээр хэрэгжүүлж буй төслийн зээл. Монгол Улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу экспортын чиглэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх,

санхүүгийн секторыг дэмжих зорилго бүхий хоёр хөтөлбөр амжилттай хэрэгжиж байна. Монгол Улс 1 дүгээр хөтөлбөрийн хүрээнд анх 10.0 сая марк буюу 5.1 сая евро, 2 дугаар хөтөлбөрийн хүрээнд 3.6 сая евро, нийт 8.7 сая еврогийн зээлийг авсан. Уг хөтөлбөрийн зээлд Капитрон, Хадгаламж /Монгол Шуудан/, Худалдаа хөгжлийн банкууд оролцлоо.

Төслийн үндсэн эх үүсвэрийг бүрэн ашиглаж дууссан бөгөөд банкуудаас эргэн төлөгдсөн зээлийн эх үүсвэрээр төслийн зориулалтын дагуу дахин зээл олгож ирэв. 2010 оны эхний 9 сарын байдлаар төсөлд оролцогч банкуудад нийт 413.2 мянган еврогийн зээлийг олгож, энэхүү эх үүсвэрийг банкууд 3 жижиг дунд үйлдвэрт дамжуулан олгож, тэдгээрийн үйл ажиллагааг дэмжсэн байна. Банкуудын төслийн зээлийн өрийн үлдэгдэл 2010 оны 9 дүгээр сарын байдлаар 3.7 сая еврод хүрээд байна.

ХОЁР. САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ЦААШИД ӨӨРЧЛӨН САЙЖРУУЛАХ ХҮРЭЭНД:

2.1 Банкны өөрийн хөрөнгийн хүндрэлийг арилгах, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг бэхжүүлэх, санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг Засгийн газартай хамтран олон улсын санхүүгийн байгууллагын дэмжлэгтэйгээр боловсруулж, хэрэгжүүлнэ.

Банкны салбарт Банкны тухай хуулийг нэг мөр хэрэгжүүлэх, дэлхийн санхүүгийн хямралаас шалтгаалан гарч ирсэн банкны салбарын дутагдалтай талыг арилгах үүднээс “Банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөр”-ийг Дэлхийн банк болон бусад Олон улсын санхүүгийн байгууллагуудын дэмжлэгтэйгээр боловсруулан Засгийн газараас холбогдох санал авсан.

Энэхүү хөтөлбөрийг ижил нөхцөл байдалтай банкуудад ижил арга хэмжээ хэрэгжүүлэх зарчмыг баримтлан боловсруулсан бөгөөд хөтөлбөр хэрэгжүүлэх урьдчилсан нөхцөл буюу банкуудын санхүү төлбөрийн чадварын бодит байдлыг Дэлхийн банкны санхүүжилт, туслалцаатайгаар олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагуудаар банкны салбарт активын хэмжээгээр том болон дунд хэмжээний нийт 10 банкинд 2010 оны 2 дугаар улирал гэхэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэж дуусгасан. Энэхүү хөндлөнгийн үнэлгээ нь Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын холбогдох стандартуудад нийцүүлэн хийгдсэн бөгөөд Монголбанкнаас банкуудад хийж байгаа хяналт шалгалтын үр дүнтэй ижил болон ойролцоо дүнтэй гарсан.

Дээрх хөндлөнгийн үнэлгээ болон Монголбанкны банкуудад хийсэн хяналт шалгалтын дүнд үндэслэн банкуудын өнөөгийн бодит нөхцөл байдлыг тодорхойлон цаашид ойрын ирээдүйд банкуудад гарч болзошгүй санхүүгийн хүндрэлийг тооцоолсны үндсэн дээр “Банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газраас гарч болзошгүй зардлын дээд хэмжээг тогтоож, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн Засгийн газар болон нэр бүхий гишүүдэд энэхүү тооцооллыг хөтөлбөрийн хамт Улсын Их Хуралд өргөн бариулахаар хүргүүлээд байна.

2.2 Иргэд, бизнес эрхлэгчид болон хөрөнгө оруулагчдаас банкны салбарт итгэх итгэлийг нэмэгдүүлэх, банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг тууштай хамгаалах зорилгоор банкны хяналт шалгалтын нэгдсэн тогтолцоог холбогдох байгууллагуудтай хамтран нэвтрүүлнэ.

Банкны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 43 дугаар зүйлд заасны дагуу Монголбанкнаас “Нэгдсэн хяналт шалгалтын журам”-ын төслийг Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооны саналыг авч, боловсруулж байна. Энэхүү журмаар банкны нэгдлийн хяналт шалгалтын тогтолцоог бүрдүүлэхэд Олон улсын тэргүүний туршлагыг судалж үзэх шаардлага үүсч байгаа тул холбогдох техник туслалцааг авахаар Азийн хөгжлийн банк болон Дэлхийн банкинд хүсэлт тавьсан болно. Энэхүү журмыг 2010 оны 3 дугаар улиралд эцэслэн баталж, 2010 оны 4 дүгээр улирлаас санхүүгийн томоохон нэгдлүүдэд Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яамтай хамтарсан шалгалт хийхээр төлөвлөөд байна.

2.3 Эрсдэлд суурилсан банкны зохистой харьцааны үзүүлэлтийг хангуулан, санхүүгийн сахилга батыг чангатгаж, банкны санхүүгийн тайлан болон өмчлөлийн байдлыг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.

Монголбанкнаас гаргасан банкны зохистой харьцааны үзүүлэлтийг эрсдэлд суурилсан байдлаар тооцох, банк зээл, түүнтэй адилтгах актив хөрөнгөө тухайн хөрөнгийн бодит байдалд нийцүүлэн ангилах журмуудын дутагдалтай талыг засан сайжруулах, олон улсын стандартад ойртуулах, Банкны тухай шинэчлэн батлагдсан хуулийн дагуу зарим нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах чиглэлээр Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 460 тоот тушаалаар “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот тушаалаар “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-уудыг шинэчлэн батлаад байна.

Ингэхдээ банкуудад Банкны тухай шинэчлэн батлагдсан хуулийн дагуу болон бусад өөрчлөлтүүдэд дасан зохицох тодорхой хугацаа өгөх, энэхүү хугацаанд банк хүндрэлтэй асуудлаа бие даан шийдвэрлэх бололцоогоор хангаж өгсөн.

“Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих журам”-ын дагуу банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тооцоонд үйл ажиллагааны эрсдэлийг шинээр нэвтрүүлж, зах зээлийн эрсдэлийн тооцооллыг хийх шаардлагыг илүү өндөрсгөсөн болно. Ашиг, сонирхлын хувьд нэгдмэл банк, санхүүгийн байгууллагууд өөрийн хөрөнгийн дутагдалтай банкинд хөрөнгө байршуулж, зохиомлоор өөрийн хөрөнгийг өсгөх тохиолдол гаргаж байсныг хаахын тулд санхүүгийн байгууллагад хөрөнгө оруулсан банкны өөрийн хөрөнгөөс тэрхүү дүнг хасч өөрийн хөрөнгийн хүрэлцээг тооцож байх заалтыг журамд оруулав”.

“Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-д зохистой харьцааг хангуулах арга хэмжээ, дотоод аргачлалтай холбоотой заалтуудыг тусгаж, Банкны тухай хуулийн 17.3-т заасан хязгаарлалт буюу банк өөрийн холбогдох этгээдэд хязгаарлалт хэтрүүлэн зээл олгосон тохиолдолд хэтэрсэн дүнгээр 100 хувь сан байгуулах заалтыг орууллаа.

Улсын Их Хурлын хаврын чуулганаар батлагдсан Банкны тухай хуулийн 5 дугаар бүлгийн 38 дугаар зүйлд заасны дагуу банк нь өөрийн санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөл, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, тэдгээрийн ажлын тайлан, хувь нийлүүлэгчид, өмчийн бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл, үйл ажиллагааны тухай олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх ёстой. Энэхүү заалтыг хэрхэн биелүүлж байгаад Монголбанкнаас хяналт тавьж, Банкны тухай хуульд заасны дагуу холбогдох ага хэмжээ аван ажиллаж байна.

Үүнээс гадна банкны зохистой засаглалд тавих шаардлагыг өндөрсгөж, санхүүгийн тайлагнал, өмчлөлийг ил тод болгох, банкны удирдлагын санхүү, бизнесийн сахилга батыг сайжруулах зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 311 тоот тушаалаар “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ыг батлан хэрэгжилтэнд хяналт тавьж эхлээд байна. Уг журам нь банкны удирдлагын чадавхийг үнэлэх тогтолцоог бүрдүүлсэн бөгөөд банкны удирдлагын санхүү, бизнесийн сахилга батыг сайжруулахад чиглэгдсэн болно.

Мөн Банкны тухай хуульд заасны дагуу “Банкны хараат бус гүшүүнийг нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх журам”-ыг Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр буюу 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 434/113/167 тоот Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлаад байна.

2.4 Банкны системд бүтцийн өөрчлөлт хийж, эрсдэл даах чадвартай, удирдлагын сайн засаглалын зарчимд тулгуурласан, санхүүгийн зуучлалыг үр өгөөжтэй явуулахуйц банкны тогтолцоог бий болгох дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газартай хамтран боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

“Банкны салбарыг чадавхжуулж, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд дунд хугацаанд төрөөс гаргасан хадгаламжийн баталгаанаас хязгаарлагдмал хадгаламжийн даатгалд шилжүүлэн хэвийн нөхцөл байдалд оруулах, Засгийн газрын дансдыг банкуудад байршуулах ажлыг журамлах, Банкны давхар өмчлөлийг (Cross ownership) арилгах, банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг өсгөх, зээлийн мэдээллийн санг өргөжүүлэн хөгжүүлэх, Иргэний хуульд зарим өөрчлөлт оруулах зэрэг ажлуудыг тусгаад байна.

Эдгээр ажлын хүрээнд эдийн засаг, санхүүгийн хямралын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болох Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулиас хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоонд шат дараатайгаар шилжүүлэх, энэхүү хуулийг буруугаар ашиглах нөхцлийг багасгах үүднээс банк хооронд байршуулсан болон гадаадын банк санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн хөрөнгө, хадгаламжид төлж байгаа баталгаанд хамрагдах хүүний хэмжээнд дээд хязгаар тогтоох, банкинд зээлтэй этгээдийн хадгаламж, харилцахыг баталгаанаас гаргах өөрчлөлтүүдийг оруулан Засгийн газартай хамтран Улсын Их Хуралд өргөн барьлаа.

Мөн зээлийг барагдуулах, барьцаа хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааг түргэтгэх үүднээс Дэлхийн банкнаас хийсэн судалгааг цаашид үргэлжлүүлэн, хүндрэл учруулж байгаа асуудлуудыг шийдвэрлэх буюу холбогдох хууль тогтоомжид цогц байдлаар нэмэлт, өөрчлөлт оруулах ажлыг төрийн бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран хийхэд туслалцаа авах саналаа Олон улсын санхүүгийн байгууллагуудад хүргүүлээд байна.

2.5 Засгийн газар, Монголбанк хамтарч арилжааны банкны зээлийн хүүг дэс дараатай бууруулах, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд ач холбогдол өгч, энэ чиглэлд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж болон хөдөө аж ахуй, хүнсний бүтээгдэхүүний импортыг орлох жижиг, дунд үйлдвэрлэлийг зээлийн бодлогоор дэмжинэ.

Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж жилийн хүү 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар өмнөх оноос 1.9 нэгж хувиар буурч, зээлийн жигнэсэн дундаж хүү эхний улиралд буурч 20 хувьд хүрсэн бол 8 дугаар сарын эцэс гэхэд 19.4 хувьтай байна. Зээлийн хүүг бууруулахад банкны салбарын чанаргүй зээл саад тотгор учруулж байгаа бөгөөд үүнийг банкны салбарын бүтцийн өөрчлөлтийн хүрээнд шийдвэрлэх талаар Монголбанкнаас иж бүрэн төлөвлөгөөг боловсруулаад байна. Оны эхэнд чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 17.4 хувь байсан бол 8 дугаар сарын эцэст 13.6 хувь болж буурлаа. Үүний зэрэгцээ нийлүүлэлтийн талын хүчин зүйлс болон төрийн зохицуулалтай бараа, үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалан инфляци хурдацтай нэмэгдсэн нь зээлийн хүүний бууралтад сөргөөр нөлөөлсөн байна.

Зураг 9 Зээлийн нэрлэсэн хүү



Эх үүсвэр: Монголбанк

Монголбанк зээлийн хүүг бууруулах эдийн засаг, хууль эрх зүйн таатай орчин бүрдүүлэх төлөвлөгөө боловсруулж, Засгийн газартай хамтран хэрэгжүүлэх саналыг дэвшүүлээд байна. Тус төлөвлөгөөнд дотоодын зах зээл дээр зээлийн хүүнд нөлөөлж буй хүчин зүйлс, санхүүгийн орчны эрсдэлийг бууруулах, тодорхой бус байдлыг арилгахад шаардлагатай арга хэмжээг тусгаад байна. Дээрх ажлын хүрээнд Засгийн газар (ҮХШХ болон Сангийн яам) болон банкуудын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Мөн зээл, хадгаламжийн хүүний талаарх түүвэр судалгааг 2010 оноос эхлэн улирал тутам явуулж, судалгааны үр дүнг шийдвэр гаргалтанд ашиглаж байна.

ГУРАВ. ТӨВ БАНКНЫ БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД

3.1 Монголбанкны үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор мөнгөний бодлогын зорилт, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний хүлээгдэж байгаа үр дүнгийн талаар тогтмол

тайлбарлан таниулж, мөнгөний бодлогын зорилтоо хангаж, олон нийтийн мөнгөний бодлогод итгэх итгэлийг нэмэгдүүлнэ.

Дээрх зорилтын хүрээнд 2010 оны 8 дугаар сарын байдлаар дараах ажлууд хийгдээд байна. Үүнд:

- Монголбанкн дээр Олон нийттэй харилцах хэлтэс зохион байгуулагдав. Үүний сацуу Монголбанкны “Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах” журам шинээр батлагдан хэрэгжиж эхлэв. Ингэснээр Монголбанкны үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх нөхцөл бүрдэв.
- Дээрх журмын дагуу Монголбанк сар бүр зохиогдох Хэвлэлийн хурлын товыг хэвлэл мэдээллийхэн болон банкуудад урьдчилан мэдэгдсэн бөгөөд эхний хурлаа 2010 оны 6 дугаар сард зохион байгуулав. Ингэснээр Монголбанкны Захирлуудын Зөвлөлийн хурлаас гарсан бодлогын шийдвэрүүдийг олон нийтэд, санхүүгийн захад тогтмол давтамжтайгаар хүргэх тогтолцоо бүрдэв.
- Монголбанк өөрийн цахим хуудсаа хэрэглэгчдэд ээлтэй болгон шинэчлэх ажлыг эхлүүлэв. Энэ ажлын хүрээнд бодлогын шийдвэрүүд, цаг үеийн мэдээллийг шуурхай байршуулдаг болсон төдийгүй “Судалгааны ажил” булангаа сэргээж мөнгө, ханшийн бодлого, банк санхүүгийн салбарын талаарх судалгаа шинжилгээний ажлуудыг байршуулж эхлэв. Монголбанкнаас хийж гүйцэтгэж буй судалгаа шинжилгээний ажлын хэлэлцүүлгийг их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудын дунд зохион байгуулахаар ажиллаж байна.
- Хэвлэл мэдээллийнхний сонирхсон сэдвээр тухай бүр ярилцлага өгөх, холбогдох тайлбар, мэдээлэл хийж ажиллав. Тухайлбал, банкны системийг чадавхжуулах, өөрийн хөрөнгөөр дэмжих хөтөлбөрийг сонин хэвлэлээр сурталчлах ажлыг зохион байгуулсан төдийгүй МҮОНТ-тэй хамтран “Эдийн засаг” теле сэтгүүлд оролцох, бага насны хүүхдүүдэд инфляцийг тайлбарласан хүүхэлдэйн киног нэвтрүүлэх, мөнгөний бодлогын асуудлаар “Нээлттэй хэлэлцүүлэг” зохион байгуулав. Сургуулийн бага, дунд насны хүүхдүүдийн эдийн засаг, мөнгө, үнийн тогтвортой байдлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд Монголбанкн дээр хүүхдүүдэд зориулсан өдөрлөг зохион байгуулахаар бэлтгэж байна.
- Монголбанкны 2009 оны жилийн тайланг олон нийтэд танилцуулах ажлын хүрээнд сэтгүүлчидтэй “Зангиагүй уулзалт” зохион байгуулав. Үүний сацуу Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл дээр банкуудын саналыг авах, тус баримтыг эдийн засгийн сэтгүүлчдэд танилцуулахаар бэлтгэж байна.

- Монгол улсад макро эдийн засгийн суурь судалгаа, шинжилгээг хөгжүүлэх, урамшуулах ажлын хүрээнд Монголбанк эдийн засаг, банк санхүүгийн салбарын оюутнуудын дунд “Парламентын мэтгэлцээн”, “Монголбанкны нэрэмжит шилдэг илтгэлийн тэмцээн” зэрэг арга хэмжээг төлөвлөж байна.

3.2 Монгол Улсын төлбөр тооцооны системийн тасралтгүй, найдвартай байдлыг хангаж, мэдээллийн технологид суурилсан бэлэн бус төлбөрийн хэрэгсэл (мобайл, интернет, карт гэх мэт)-ээр хийх төлбөр тооцооны эрх зүйн орчныг бүрдүүлэх эхлэлтийг тавьж, картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулдаг клирингийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

“Монгол Улсын төлбөр тооцооны систем, цахим төлбөрийн хэрэгсэл, цахим мөнгөний тухай хууль”-ийн төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авах. Төлбөрийн бодлого, зохицуулалтын албанаас Монгол Улсын төлбөрийн систем, цахим хөрөнгийн шилжүүлэг, цахим төлбөрийн хэрэгслийг зохицуулах, түүнд хяналт тавих, санхүүгийн байгууллагууд болон бусад үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, тэдгээрийн хэрэглэгч, оролцогчдын эрх, үүргийг тодорхойлсон “Монгол Улсын төлбөрийн систем, цахим хөрөнгийн шилжүүлгийн тухай хууль”-ийн төслийн анхны хувилбарыг дараах бүтэцтэйгээр боловсруулсан.

Үүнд:

- Дотоод шилжүүлэг;
- Гадаад шилжүүлэг;
- Цахим төлбөрийн хэрэгслийг гаргах, ашиглах;
- Төлбөрийн системийг байгуулах, ажиллуулах;
- Төлбөрийн системийн хяналт;
- Цахим төлбөрийн хэрэгслийг гаргах, ашиглах, цахим төлбөрийн шилжүүлэг хийхтэй холбоотой шүүхийн бус маргаан шийдвэрлэх горим.

Монгол Улсад анх удаа боловсруулагдаж буй уг хуулийн төсөлд төлбөрийн системийн болон хуулийн мэргэжилтний туслалцаа, зөвлөгөө, саналыг авч тусгах зорилгоор холбогдох хэлтэс, ажилтнуудад хүргүүлсэн.

Төлбөрийн картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулах клирингийн үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд: Монголбанк нь ХААН банк, Худалдаа хөгжлийн банктай хамтран “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ” бий болгох тухай

”Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2010 оны 5 дугаар сарын 15-ны өдөр байгуулан, нэг сарын хугацаанд “Банк хоорондын картын төлбөр тооцооны нэгдсэн сүлжээ (клиринг)”-г нэвтрүүлэх туршилтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд туршилтын хугацаанд төлбөрийн картаар банк хоорондын 691.4 сая төгрөгийн 11.7 мянган ширхэг гүйлгээний нийт 30 өдрийн үр дүнгийн тооцооллыг “Банксүлжээ систем”-рүү дамжуулж, Монголбанкн дахь харилцах дансанд зөрүүгүйгээр хаалаа.

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-ний нээлтийг 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдөр албан ёсоор хийж, III улирлын төлөвлөгөөт ажлыг II улиралд багтаан төлбөрийн картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулах клирингийн үйлчилгээг амжилттай нэвтрүүлсэн.

3.3 Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл авах үйл ажиллагааг эхлүүлж, хуулийн байгууллагатай хамтын ажиллагаагаа сайжруулна.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажлын хүрээнд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан 2010 оны 3 дугаар сарын 7-ны өдөр ХЗДХЯ-нд хүргүүлсэн бөгөөд энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулан ажиллахаар төлөвлөж байна. Банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл авах үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор “Харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх журам”-ын төслийг боловсруулан Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн нь СЗХ-ны даргын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 253 дугаартай тогтоолоор батлагдсан. Уг журмыг мэдээлэх үүрэгтэй этгээдэд тайлбарлан таниулах зорилгоор даатгал, ББСБ, хадгаламж зээлийн хоршоо, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагын ажилтан нарт 2010 оны 2 дугаар сард нэг өдрийн сургалтыг зохион байгууллаа. Түүнчлэн, банк бус санхүүгийн байгууллагуудаас санал авах, газар дээр нь очиж үйл ажиллагааны онцлогтой нь танилцах, гарч болох эрсдэл, бэрхшээлийг тодорхойлох замаар банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зориулсан сэжигтэй болон бэлэн мөнгөний гүйлгээг мэдээлэх маягтын загварыг боловсруулж Санхүүгийн зохицуулах хороонд батлуулахаар хүргүүлсэн. Дээрх маягт батлагдсанаар мэдээлэл авах үйл ажиллагаа эхэлнэ. Мөн, банк бус санхүүгийн байгууллагуудад мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, журмын хэрэгжилт хэрхэн явагдаж байгаад хяналт шалгалт хийх журмын төслийг боловсруулж дууссан бөгөөд Монголбанкны Захирлуудын зөвлөлд хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.

Хуулийн байгууллагатай хамтын ажиллагаагаа сайжруулах ажлын хүрээнд ЦЕГ, УЕПГ, УМБГ-тай хамтын ажиллагааг эхлүүлэхээр ажиллаж байна. Түүнчлэн, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхтэй холбогдуулж Тагнуулын ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн газар, Авилгатай тэмцэх газартай мэдээллийн технологийн чиглэлээр хамтын ажиллагаагаа улам өргөжүүллээ. Улсын Ерөнхий Прокурор, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хамтарсан тушаалаар “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор банкнаас эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх журам” батлагдсан.

III. ТӨСЛИЙН ТООЦОО СУДАЛГАА

1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

1.1 Эдийн засгийн өсөлт

ДНБ-ий бодит өсөлт 2005-2008 онуудад дунджаар 8.7 хувь, 2009 онд -1.6 хувь байлаа. Бүтээгдэхүүний цэвэр татвар, худалдаа, боловсруулах, барилгын салбарын нэмэгдсэн өртөг буурсан учраас эдийн засгийн өсөлт буурчээ.

Хүснэгт 1.1 ДНБ салбараар, 2005 оны зэрэгцүүлэх үнээр (тэрбум төгрөгөөр)

	2005	2006	2007	2008	2009*	Хувийн	2010 *		
							I улирал	II улирал	I хагас жил
ДНБ	2,779.6	3,017.4	3,325.9	3,622.7	3,564.3	100	663.4	987.2	1,650.6
Өсөлт, %	7.3	8.6	10.2	8.9	-1.6		7.5	-0.5	5.0
Хөдөө аж ахуй	608.3	654.1	757.5	801.2	813.5	22.8	28.2	219.8	248.0
Өсөлт, %	10.7	7.5	15.8	5.8	1.5		-35.8	-30.7	-30.7
Уул уурхай	608.2	646.3	665.0	645.9	669.8	18.8	148.7	174.4	323.0
Өсөлт, %	10.6	6.3	2.9	-2.9	3.7		13.1	5.0	8.6
Боловсруулах	102.0	115.6	149.1	154.7	137.5	3.9	28.6	38.6	67.2
Өсөлт, %	-19.5	13.4	29	3.8	-11.1		23.9	32.0	28.5
Цахилгаан, эрчим хүч	80.0	83.6	89.9	98.2	101.9	2.9	32.8	22.7	55.5
Өсөлт, %	0.5	4.5	7.5	9.2	3.8		10.1	12.6	11.1
Барилга	58.8	61.8	67.1	58.4	29.9	0.8	0.9	5.1	6.0
Өсөлт, %	15.6	5.1	8.5	-13.0	-48.8		-72.2	-26.0	-40.3
Худалдаа	227.0	261.8	279.4	324.7	238.4	6.7	57.2	84.0	141.2
Өсөлт, %	2.5	15.3	6.7	16.2	-26.6		19.1	112.1	61.1
Тээвэр, холбоо	309.1	346.4	438.6	528.6	592.3	16.6	144.3	169.1	313.4
Өсөлт, %	22.5	12.1	26.6	20.5	12.1		21.5	28.3	25.1
Бусад үйлчилгээ	474.4	464.4	469.9	518.7	580.6	16.3	129.8	131.6	261.4
Өсөлт, %	4.7	-2.1	1.2	10.4	11.9		-12.9	-11.8	-12.4
Бүтээгдэхүүний цэвэр татвар	311.7	383.4	409.5	480.2	400.4	11.2	92.9	142.0	234.9
Өсөлт, %	1.2	23	6.8	17.2	-16.6		32.9	7.9	40.4

*Урьдчилсан гүйцэтгэл

** 2009 оны байдлаар

Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбар 2009 оны байдлаар (ДНБ-ий 22.8%) өмнөх оныхтой харьцуулснаар 1.5 хувь, уул уурхай, олборлох үйлдвэрлэл (ДНБ-ий 18.8%) 3.7 хувь, тээвэр холбоо (16.6%) 12.1 хувь, цахилгаан эрчим хүч (ДНБ-ий 2.9%) 3.8 хувиар тус тус өссөн байна. Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын нөлөөгөөр манай улсын эдийн засгийн үйл ажиллагааны гол салбарын өсөлт 2009 онд буурсан билээ. Тухайлбал, боловсруулах үйлдвэрлэл (ДНБ-ий 3.9 хувь) 11.1 хувь, бөөний болон жижиглэн худалдаа, гэр

ахуйн барааны засвар үйлчилгээ (ДНБ-ий 6.9 хувь) 26.6 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар (ДНБ-ий 11.2 хувь) 16.6 хувиар буурчээ.

Эдийн засгийн өсөлт 2010 оны эхний хагас жилийн байдлаар 5.0 хувьд хүрэв. Тус өсөлтөнд бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засварлах бараа, үйлчилгээний салбар 61.1 хувь, тээвэр холбоо 25.1 хувь, уул уурхай 8.6 хувь, боловсруулах үйлдвэрлэлийн салбар 28.5 хувь, бүтээгдэхүүний цэвэр татвар 40.4 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Харин 2010 оны эхний хагас жилийн байдлаар 9.7 сая толгой мал хорогдож, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 30.7 хувиар буурсан байна.

Шигтгээ 1. Инфляци ба эдийн засгийн өсөлтийн хамаарал

Хөгжсөн болон хөгжиж буй орнуудын алинд ч макро эдийн засгийн бодлогын гол зорилго нь эдийн засгийн өндөр өсөлтийг доогуур инфляцийн түвшинтэй хослуулан барих явдал юм. Ер нь инфляци болон эдийн засгийн өсөлт (цаашид өсөлт гэх) –ийн хоорондын харилцан хамаарлын талаар олон тооны ойлголт, хэлэлцүүлгүүд байдаг.

Онолын ойлголт


А.В.Филиппс 1958 онд ажилгүйдэл инфляцийн хамаарлыг судлан инфляци өндөр байхад ажилгүйдэл бага, инфляци бага байхад ажилгүйдэл өндөр байдгийг олж тогтоожээ. Өөрөөр хэлбэл инфляци, ажилгүйдэл нь урвуу хамааралтай байдаг гэж үзжээ. Түүнчлэн ажилгүйдлийн түвшин эдийн засгийн өсөлттэй мөн адил урвуу хамааралтай байдгийг Оукен тогтоожээ. Энэ нь ажилгүйдэл өсч байхад өсөлт удааширч байдаг гэсэн үг юм.

Инфляци нь потенциалас давсан эрэлт (халалт) үүсэхэд бий болно. Гэхдээ инерци, хүлээлт, эрэлтийн гэсэн хэсгүүдтэй учир эдгээр хэсгүүдийг зөв тооцоолох, ялангуяа эрэлт өссөнөөс эсвэл нийлүүлэлт буурснаас илүүдэл эрэлт бий болж байна уу гэдгийг ялгаж авч үзэх нь чухал.

Эмпирик судалгаанууд – Инфляци ямар түвшинд байвал зохистой вэ?

Зарим эмпирик судалгаагаар (Хүснэгт 1) өндөр инфляци эдийн засгийн өсөлттэй сөрөг хамааралтайг харуулсан байдаг. Инфляцийн

Зураг 1.1. Инфляци ба өсөлтийн хамаарал



түвшин өндөр орнуудад эдийн засгийн өсөлт ерөнхийдөө доогуур байдаг. Иймээс тэд инфляци бол хохиролтой зүйл гэж үздэг. Тухайлбал, Robert J.Barro “Инфляци ба өсөлт” (1995) ажилдаа 100 орны 1960-90 оны тоон өгөдлийг ашиглан регрессийн шинжилгээ хийж, инфляци өсөлт сөрөг хамааралтай (Зураг1), инфляцийн жилийн дундаж өсөлт нь 10 нэгж хувиар нэмэгдэхэд нэг хүнд ноогдох ДНБ жилд 0.2-0.3 нэгж хувиар буурч байгааг харуулжээ.

Мөн зарим судалгаагаар инфляци тодорхой түвшингээс доогуур байхад өсөлтөнд нөлөөгүй бөгөөд дээгүүр үед өсөлтөнд сөрөг нөлөөтэй байдгийг харуулсан байдаг. Тухайлбал M.S.Khan ба A.S.Senhadjji нар “Өсөлт ба инфляцийн хоорондын харилцан холбоо” (2001) ажилдаа 140 орны 1960-98 оны тоон өгөгдөл дээр судалгаа хийж уг “босго түвшин” нь хөгжсөн орнуудад доогуур буюу 1-3 хувь байхад, хөгжиж буй орнуудад 11-12 хувь байна гэж үзжээ. Харин зарим судлаачид инфляци нь урт хугацаанд өсөлтөд ямар ч нөлөөгүй бөгөөд богино хугацаанд сөрөг нөлөө үзүүлдэг гэж үздэг. Хүснэгт 1-д энэ чиглэлээр хийгдсэн зарим судалгааны ажлуудын үр дүнг харуулж байна.


Хүснэгт 1. Зарим эмпирик судалгааны тойм

№	Зохиогч	Судалгаа	Өгөгдөл	Аргачлал	Үр дүн
1	Michael Sarel (1995)	Инфляцийн өсөлтөнд үзүүлэх шугаман бус нөлөө	1970-1990, 87 улс	Регрессийн шинжилгээ	Инфляци 8%-иас бага үед өсөлтөнд ямар ч нөлөөгүй бөгөөд үл ялиг эерэг нөлөөтэй харин 8%-иас хэтрэхэд маш хүчтэй сөрөг хамааралтай байна.
2	Robert J. Barro (1995)	Инфляци ба эдийн засгийн өсөлт	1960-1990, 100 улс	Регрессийн шинжилгээ	Инфляцийн өсөлт жилд дунджаар 10 нэгжээр нэмэгдэхэд нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлт 0.2-0.3 нэгжээр, хөрөнгө оруулалт ба ДНБ-ий харьцаа 0.4-0.6 нэгжээр буурна.
3	A.Ghosh ба S.Phillips (1998)	Инфляци эдийн засгийн өсөлтөнд сөргөөр нөлөөлөх нь	1960-1996, 145 улс	Панел регрессийн шинжилгээ	Инфляци 2.5%-иас бага үед өсөлтөнд эерэг нөлөөтэй бөгөөд үүнээс их үед хүчтэй сөрөг нөлөөтэй.
4	J.R.Faria ба F.G.Carneiro (2001)	Өндөр инфляци өсөлтөнд нөлөөлөх үү?	1980-1995, Бразил	Бүтцийн вектор авто регрессийн шинжилгээ	Урт хугацаанд өсөлтөнд инфляци ямар ч нөлөө үй, богино хугацаанд сөрөг нөлөөтэй.
5	M.S.Khan ба A.S.Senhadjji (2001)	Өсөлт ба инфляцийн хоорондын харилцан холбоо	1960-1998, 140 улс	Инфляцийн лог-загвар	Хэрвээ инфляци “босго түвшин”-ээсээ бага байвал өсөлтөнд нөлөөгүй, их байвал хүчтэй сөрөг нөлөөтэй. Уг “босго түвшин” нь хөгжсөн орнуудад 1-3 хувь байхад хөгжиж буй орнуудад 11-12 хувь байна.

Бусад орнууд дахь өсөлт ба инфляцийн хамаарал

Монголын уул уурхайн салбар сүүлийн жилүүдэд эрчтэй хөгжиж улс орны эдийн засагт тэргүүлэх салбарын байр сууриа улам бэхжүүлсээр ирлээ. Ийм байдлаар хөгжсөн орнуудын

Зураг 1.2. Инфляци ба өсөлтийн хамаарал




туршлагыг судлах үүднээс сүүлийн 40 жилийн хугацаанд олборлох үйлдвэрлэлээс үүдэлтэй эдийн засгийн өндөр өсөлттэй байсан бусад орнуудад (Бахрайн, Бразил, Чил, Индонези, Иран, Казахстан, Мексик, Нигер, Катар, Саудын Араб, Уганда, Венесуэл, Зимбабве г.м) инфляци болон өсөлтийн хамаарлыг скаттер диаграмм (Зураг 2) байгуулж харъя.

Зураг 2 -оос харахад эдийн засгийн өсөлт инфляцийн хооронд урвуу хамаарал байна.

Өсөлт буурч 5 хувиас доошлоход инфляцийн түвшин эрс нэмэгдэж байгаа бөгөөд өсөлт нэмэгдэхийн хирээр инфляци буурч тогтвортой түвшинд очиж байна. Мөн инфляци ойролцоогоор 10 хувь дотор байхад өндөр өсөлттэй байна гэж болно.

Монголын эдийн засгийн өсөлт ба инфляци

Монголын инфляци, эдийн засгийн өсөлтийн динамик (Зураг 3)-аас харахад ямар нэгэн илэрхий хамаарал ажиглагдахгүй байна. 2001-2010 оны 2-р улирал хүртэлх хугацаанд эдийн засаг дунджаар жилийн 6.9 хувиар өссөн байхад инфляци 9.2 хувиар өссөн байна.



Зураг 3. Инфляци ба ДНБ -ий жилийн өсөлт

Гэсэн хэдий ч эдийн засгийн өсөлт өндөр гарах бүрт инфляцийн түвшин нэг оронтой тоонд, доогуур түвшинд байсан нь ажиглагдаж байна. Харин эдийн засгийн өсөлт доогуур түвшинд очиход

инфляцийн түвшин өсөөгүй (2005 оны 1-3 улирлаас бусад үед) бөгөөд 2008 оны эхнээс 2009 оны 3 –р улиралд (дэлхийн эдийн засгийн хямралын үе) өсөлт сөрөг түвшинд очиход инфляци маш их хэмжээгээр өссөн байна. 2010 оны эхнээс инфляци өсч, өсөлт буурчээ.

Хүснэгт 2. Корреляцын матриц

Хув сагчид	ДНБ-ий жилийн өсөлт	Инфляцийн жилийн өсөлт
ДНБ-ий жилийн өсөлт	1.000	0.089
Инфляцийн жилийн өсөлт	0.089	1.000

Өсөлт, болон инфляцийн динамикийн хамаарлыг харуулахын тулд юуны түрүүнд тоон өгөгдлийн тогтворжилтыг шалгах хэрэгтэй бөгөөд ADF тестээр шалгаж үзэхэд өсөлт болон инфляци харгалзан 1 (-3.89) ба 5 (-3.21) хувийн ач холбогдлын түвшинтэйгээр тогтвортой цуваа болох нь харагдлаа. Үүний дараа өсөлт ба инфляцийн хоорондын хамаарлыг корреляцийн матриц (Хүснэгт 2) –ыг харахад хоорондоо сул боловч эерэг хамааралтай байна.

1.2 Инфляци, түүний өөрчлөлтийн шалтгаан

Үндэсний статистикийн хорооны мэдээгээр 2010 оны 8 дугаар сард хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ улсын хэмжээнд оны эхнээс 9.0 хувь, өмнөх оны мөн үеэс 11.2 хувиар өсчээ. Улаанбаатар хотын хэмжээнд оны эхнээс 13.2 хувь, өмнөх оны мөн үеэс 11.1 хувиар өссөн байна.

Улаанбаатар хотын 2010 оны эхний 8 сарын байдлаарх хэрэглээний үнийн өөрчлөлтийг бүлгээр нь авч үзвэл хүнсний бараа, ундаа, усны бүлгийн бараа, үйлчилгээний үнэ 21.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 11.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээнийх 17.0, Боловсролын үйлчилгээнийх 20.4 хувь, Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 11.7 хувиар тус тус нэмэгджээ.


Хүснэгт 1.2 Хэрэглээний барааны үнийн индекс

	Хувийн жин	2010-VIII 2009-VIII	2010-VIII 2009-XII
Хүнсний бараа, ундаа, ус	41.1	114.1	121.5
Согтууруулах ундаа, тамхи	2.3	102.6	102.1
Хувцас, бөс бараа, гутал	12.4	110.5	105.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	13.4	111.0	110.4
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	4.3	102.1	102.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	1.6	105.6	101.8
Тээвэр	8.7	102.7	101.3
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.1	116.9	117.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.3	98.5	100.0
Боловсролын үйлчилгээ	4.2	120.4	120.4
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлч.	1.7	112.9	111.7
Бусад бараа үйлчилгээ	3.0	105.6	102.2
Ерөнхий индекс	100.0	111.1	113.2

Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо (Улаанбаатар хотын индекс)

Хэрэглээний үнийн индекс нь махны үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай байдаг. Тухайлбал, 2010 оны 1-5 дугаар саруудад хонины махны үнэ 14.2-22.9 хувь, үхрийн махных 8.0-22.1 хувиар тус тус нэмэгдсэн нь тухайн саруудын инфляцийг 1.9-4.2 хувиар өсөхөд нөлөөлжээ. Харин махны үнэ 2010 оны 6, 7 дугаар сард хямдархад хэрэглээний үнийн индекс буурсан. Хэдийгээр махны үнэ улирлын шинж чанартайгаар өвөл, хаврын үед өсдөг боловч өнгөрсөн өвлийн хувьд махны үнэ өмнөх жилүүдээс харьцангуй илүүтэйгээр нэмэгдсэн. Үүнд зудын улмаас их хэмжээгээр мал хорогдож махны нийлүүлэлт багассан нь нөлөөлжээ. Манай иргэдийн хэрэглээний уламжлал өөрчлөгдөх үед махны үнээс хамаарах нь бага болно. Энэ оны эцсээр Хэрэглээний үнийн сагсыг шинэчлэн тооцоолох үед өөрчлөлт гарсан эсэх нь тодорхой болох юм.


Зураг 1.3 Улаанбаатар хотын инфляци болон махны үнийн өөрчлөлт



Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо (Улаанбаатар хотын индекс)

Инфляцийн хүлээлт, эрэлтийн хүчин зүйлсийг илүү бодитой илэрхийлэх, нийлүүлэлтийн огцом цочролоос ялгаж шинжлэх үүднээс улирлын хэлбэлзэл ихтэй мах, сүү, хүнсний ногоо эсвэл түр зуурын нөлөөлөлд автан хэт их хэлбэлздэг бараа, бүтээгдэхүүнийг хэрэглээний сагснаас хасч “суурь инфляци”-ийг тооцдог. Суурь инфляци 2010 оны 8 дугаар сарын байдлаар оны эхнээс 6.9 хувь, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар тус тус өссөн байна. Үүнд хэрэглээний сагсны бүх бүлгүүдийн үнийн тогтвортой өсөлт жигд байдлаар нөлөөлсөн бөгөөд тэр дундаас хүнсний бараа, ундаа, ус, боловсролын үйчилгээ болон орон сууц, ус цахилгаан, түлшний үнийн өсөлт нь харьцангуй өндөр нөлөөг үзүүлэв. Суурь инфляцийн 2010 оны эхний 7 сарын хандлага харьцангуй тогтвортой байсан боловч 8 дугаар сард гурилын үнэ болон боловсролын төлбөр нэмэгдсэн нь суурь инфляци 3.5 хувиар өсөхөд голлон нөлөөлөв.

Зураг 1.4 Улаанбаатар хотын инфляци, суурь инфляци, сараар




Эх үүсвэр: Статистикийн сарын бюллетень, Үндэсний статистикийн хороо (Улаанбаатар хотын индекс)

Хүснэгт 1.3 Хэрэглээний зарим бараа, бүтээгдэхүүний үнийн улирлын өөрчлөлт

Огноо	Улирлын инфляци	Барааны нэрс (Хэрэглээний сагсанд эзлэх хувийн жин), үнийн өсөлтийн хувь	Тайлбар
2009 III улирал	2.4 хувь	Хүнсний бараа, ундаа, ус (42.2): -9.5 хувь Тээвэр (8.7) : 7.2 хувь Боловсролын үйлчилгээ (5.4): 9.0 хувь	Мах, махан бүтээгдэхүүн дэд бүлгийн үнэ 22.9 хувиар буурав. Автобензиний үнэ 40.1-45.3 хувь, дизелийн түлшний үнэ 17.9 хувиар өсөв. Улсын их, дээд сургуулийн жилийн төлбөр 7.9 хувь, хувийн их, дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 10.3 хувиар өсөв.
2010 I улирал	8.7 хувь	Хүнсний бараа, ундаа, ус (42.2): 17.5 хувь Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ (4.1): 17.0 хувь	Махны үнэ 32.9-52.0 хувиар өсөв. Суурин утаснаас суурин утас руу залгасан 1 минутын ярианы тариф 37.5 хувь, Улаанбаатараас Дорнод руу ярих 3 минутын ярианы тариф 25.0 хувиар тус тус нэмэгдэв.
2010 II улирал	6.9 хувь	Хүнсний бараа, ундаа, ус (42.2): 13.8 хувь Орон сууц, ус, цахилгаан, түлш (13.4): 4.1 хувь	Махны үнэ 37.8-44.9 хувиар өсөв. Халаалтын бус улиралд орон сууцны халуун усны төлбөр 50.0 хувь, орон сууцны цахилгааны үнэ 17.2 хувиар тус тус өсөв.
2010 III улирал (8 дугаар сарын байдлаар)	-2.5 хувь	Хүнсний бараа, ундаа, ус (42.2): -9.2 хувь Орон сууц, ус, цахилгаан, түлш (13.4): 6.5 хувь Боловсролын үйлчилгээ (4.15): 20.4 хувь	Мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 25.0 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүнийх 8.8 хувиар буурав. Орон сууцны цэвэр усны үнэ 38.5 хувь, орон сууцны бохир усны үнэ 48.6 хувиар өсөв. Улсын их, дээд сургуулийн жилийн төлбөр 20.2 хувь, хувийн их, дээд сургуулийн жилийн сургалтын төлбөр 20.5 хувиар өсөв.

Энэ оны эхний 8 сард инфляци 13.2 хувиар өссөний 69.9 хувийг хүнсний бараа, ундаа, ус, 9.3 хувийг орон сууц, ус, цахилгаан, түлш, 8.4 хувийг боловсролын үйлчилгээ, 5.2 хувийг хувцас, бөс бараа, гутал, 7.1 хувийг бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт тус тус бүрдүүлжээ.


Зураг 1.5 Инфляцийн үнийн өөрчлөлтийн бүтэц, эхнийн 8 сарын байдлаар



Шигтгээ 2. Цалин, бүтээмж, инфляци

Нэрлэсэн цалин 2009 онд 9.6 хувь, хөдөлмөрийн дундаж бүтээмж 1.9 хувиар тус тус өсч, инфляци жилийн 1.7 хувь байлаа. Дээрх үзүүлэлтүүд өмнөх онуудын дунджаас нэлээд бага байгаа нь дэлхийн эдийн засгийн хямрал Монголын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэнтэй холбоотой.

Зураг 1. Цалин, бүтээмжийн өсөлт болон инфляци



Бодит цалингийн өсөлт нь хөдөлмөрийн ахиу бүтээмжийн өсөлтөөс шалтгаалж байвал инфляцийн дарамт үүсгэхгүй, урт хугацаанд макро эдийн засгийн тогтвортой байдалтай

нийцнэ гэж үздэг. Зураг 1-ээс харахад цалин бүтээмжээс өндөр өсөлттэй байгаа боловч үүн дээр үндэслэн дүгнэлт гаргах нь дутагдалтай. Учир нь хөдөлмөрийн ахиу бүтээмжийн тоон мэдээлэл байхгүйгээс түүнийг хөдөлмөрийн дундаж бүтээгдхүүнээр төлөөлүүлэв.

Цалин, үнэ, бүтээмжийн хамаарлыг дэлгэрэнгүй тайлбарлах үүднээс төгс өрсөлдөөнт зах зээлд ашгийг хамгийн их байлгах цалин нь хөдөлмөрийн бүтээгдхүүнээр тодорхойлогдоно гэж үзвэл цалингийн өсөлт дараах функцээр илэрхийлэгдэнэ.⁶

$$\hat{w} = \hat{p} + \hat{a} \quad \text{буюу} \quad \hat{w} - \hat{p} = \hat{a} \quad (1)$$

Энд w , p , a нь цалин, үнэ, бүтээмж бөгөөд малгайгаар өөрчлөлтийг илэрхийлэв. Дээрх тэгшитгэл нь цалин, хөдөлмөрийн бүтээмж тэнцүү өсөлттэй үед инфляцийн дарамтыг бий болгохгүй гэдгийг харуулж байна. Гэхдээ дээрх тэгшитгэл нь төгс өрсөлдөөнт зах зээлд биелэх бөгөөд төгс бус өрсөлдөөнт зах зээлд цалингийн өсөлт нь үнийн өсөлтийг бий болгохгүй байж болно. Тухайлбал, цалингийн өсөлт нь ашгийн бууралтад шингэвэл инфляцийн дарамтыг үүсгэхгүй байж болно.

Манай орны хувьд цалингийн өсөлт, бүтээмж, инфляцийн хамаарлыг панел өгөгдлийн экономерик аргаар үнэллээ. Үнэлгээнд 2004 оноос 2009 оны хоорондох ДНБ-ий салбаруудын дундаж цалин, хөдөлмөрийн дундаж бүтээмжийн жилийн өсөлт болон ХҮИ-ээр илэрхийлэгдсэн жилийн инфляцийн өгөгдлийг ашиглав. Хамаарлыг үнэлэхэд дараах үр дүн гарлаа.


$$\hat{w}_{i,t} = 0.05 + 1.9 \hat{p}_t + 0.1 \hat{a}_{i,t} \quad (2)$$

Үнэлгээний үр дүн бүтээмжийн өсөлт өөрчлөгдөөгүй үед инфляци нэг нэгж хувиар нэмэгдэхэд цалингийн өсөлт 1.9 нэгж хувиар нэмэгддэг, харин инфляци өөрчлөгдөөгүй үед бүтээмжийн өсөлт нэг нэгж хувиар нэмэгдэхэд цалингийн өсөлт 0.1 нэгж хувиар өсдөг гэдгийг харуулж байна. Манай орны хувьд бүтээмжийн цалинд үзүүлэх нөлөө бага, статистикийн хувьд ач холбогдолгүй байгаа нь үнэлгээний хугацааны түүвэр богино, ахиу бүтээмжийг дундаж бүтээмжээр төлөөлүүлснээс шалтгаалсан байж болно. Түүнчлэн, инфляцийн цалинд үзүүлж буй нөлөөлөл өндөр, статистикийн хувьд ач холбогдолтой гарч байгаа боловч цалингийн өсөлт, үнийн өсөлт нь нэг зүгт, нэг шалтгаанаас үүдэлтэй байж болохыг үгүйсгэхгүй юм. Манай орны хувьд уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт ихээр

⁶ Энд эдийн засгийг Кобб-Дугласын тогтмол өргөжилтийн үр өгөөжтэй үйлдвэрлэлийн функцтэй гэвэл төгс өрсөлдөөнт зах зээлд цалин гэж тодорхойлогдох бөгөөд логарифм шугамчлал хийснээр цалингийн өсөлт дээрх тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ. Энд Y , L нь өргөжилтийн тогтмол үр өгөөж, бүтээгдхүүн, хөдөлмөр болно.

хийгдэж байгаа нь тухайн салбарын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлж, улмаар тус салбарт цалингийн өсөлтийг бий болгож, хөдөлмөр чөлөөтэй шилжих боломжтой тул бусад салбарын цалинг мөн өсөхөд хүргэж байх талтай. Нөгөө талаас, уул уурхайн салбарын өсөлт нь эдийн засгийн халалтаас үүдэлтэй инфляцийг хөөрөгдсөн байж болох тул инфляцийн бодит цалинд үзүүлэх нөлөө дээрх үнэлэгдсэн утгаас бага байх магадлалтай.

Зураг 2. Цалин, дундаж бүтээмжийн өсөлт (салбараар, 2004-2009)



Зураг 2-оос харахад бодит цалин бүтээмжээс өндөр өсөлттэй байх хандлагатай байна. Энэхүү хандлага нь зөвхөн манай орны хувьд ч биш ер нь хөгжиж буй орны хувьд нийтлэг ажиглагддаг. Энэ нь хөгжиж буй орны худалдааны нөхцлийн өөрчлөлт, төрийн албан хаагчдын цалингийн өсөлт, хурдацтай хотжилт, сүүдрийн эдийн засгаас албан ёсны эдийн засаг руу шилжих шилжилт, экспортлодог⁷ барааны салбарын

бүтээмжийн хурдацтай өсөлт зэргээс шалтгаалдаг.

Иймд цалин, үнэ болоод бүтээмжийн хоорондын хамаарлыг илүү нарийн тайлбарлах үүднээс экспортлодог, экспортлодоггүй салбаруудаар үзүүлэлтүүдийг авч үзье. Экспортлодог салбар нээлттэй өрсөлдөөнд байдгаас тус салбарын бүтээмж экспортлодоггүй салбарын бүтээмжээс өндөр өсөлттэй байдаг. Экспортлоддог салбарын өндөр бүтээмж нь тухайн салбарын цалинг өсгөх төдийгүй хөдөлмөр чөлөөтэй шилждэг тул нийт эдийн засаг дахь цалинг өсгөдөг. Энэ нь илүү өндөр цалин төлөхийн тулд экспортлодоггүй салбарын эзэд өөрийнхөө бүтээгдхүүний үнийг өсгөхөд хүргэж улмаар эдийн засаг дахь нийт үнийн түвшинг өсгөдөг.

Инфляцийг экспортлодог $\hat{p}^T$, экспортлодоггүй $\hat{p}^{NT}$ бараагаар салгавал:

$$\hat{p} = \alpha \hat{p}^T + (1 - \alpha) \hat{p}^{NT} \quad (3)$$

Энд α нь экспортлодог барааны ХҮИ-ийн багцад эзлэх хувийн жин. Эдийн засагт салбаруудын цалинг адил тогтдог гэж үзвэл экспортлодог, экспортлодоггүй барааны инфляцийн зөрүү нь дээрх хоёр салбарын бүтээмжийн зөрүүгээр тодорхойлогдоно⁸.

⁷ T нь “Tradable” буюу “экспортлогддог”, NT нь “non-tradable” буюу “экспортлогддоггүй”.

⁸ Дээрх салбаруудын үйлдвэрлэлийн функц дэх хөдөлмөрийн оролцоо адил гэж таамаглав.

$$\hat{p}^{NT} - \hat{p}^T = \hat{a}^T - \hat{a}^{NT} \quad (4)$$

Эдийн засаг улам нээлттэй болж, тээврийн зардал буурч байгаагаас улс орнуудын хувьд экспортлодог барааны үнэ адил тогтох хандлага ажиглагдаж байна. Иймд нээлттэй эдийн засагт экспортлодог барааны үнэ нь дэлхийн үнэ $\hat{p}^{T*}$ болон ханшийн өөрчлөлт $\hat{e}$ -өөр илэрхийлэгдэнэ гэж үзвэл ХҮИ-ээр илэрхийлэгдсэн инфляци нь дараах тэгшитгэлээр илэрхийлэгднэ.

$$\hat{p} = (\hat{p}^{T*} + \hat{e}) + (1 - \alpha)(\hat{a}^T - \hat{a}^{NT}) \quad (5)$$


Дээрх тэгшитгэл нь инфляцийг “импортлосон” болон салбар хоорондын бүтээмжийн хандлагаар тодорхойлогдож буй “бүтцийн” инфляциар салган харуулж байна. Дээрх тэгшитгэл нь экспортлодог, экспортлодоггүй салбарын бүтээмжийн өсөлтийн зөрүү өндөр байснаар эдийн засаг дахь нийт цалинг өсгөж, энэ нь улмаар экспортлодоггүй барааны үнийн өсөлтөөр дамжуулан инфляцийг нэмэгдүүлдгийг харуулж байна.

Манай орны хувьд экспортлодог бараа ХҮИ-ийн багцын 23%-ийг эзэлж байгаа нь салбар хоорондын бүтээмжийн өсөлтийн зөрүүний инфляцид үзүүлэх нөлөөг өндөр байлгах талтай. Сүүлийн 7 жилд экспортлодог, экспортлодоггүй салбарын бүтээмжийн дундаж өсөлт тус бүр 5%, 3% байсан нь дээрх жилүүдийн 10.3%-ийн дундаж инфляцийн 1.7 % нь бүтцийн инфляци байх боломжтойг харуулж байна⁹. Гэхдээ хөдөлмөрийн ахиу бүтээмжийг дундаж бүтээмжээр төлөөлүүлсэн тул дээрх үр дүн нь бодит байдлаас зөрүүтэй байх магадлалтай.

Түүнчлэн бүтээмжийн төлөөлөх чадвар муу, түүвэр хангалттай урт биш байгаа нь цалин, инфляци, бүтээмжийн хоорондох хамаарлыг үнэлэхэд бэрхшээл учруулж байна. Иймд 2000 оны 1 дүгээр улирлаас 2010 оны 2 дугаар улирал хүртэлх нэрлэсэн цалингийн өсөлт, инфляцийн өгөгдлийг ашиглан дээрх үзүүлэлтүүдийн аль нь нөгөөгийнхөө шалтгаан болж байгааг “Cross correlation test”-ээр шалгахад тестийн үр дүн нь цалингийн өсөлт хоёр улирлын дараах үнийн өсөлтийн шалтгаан болж байгааг харуулсан. Энэхүү үр дүнг энгийнээр харуулах үүднээс цалингийн улирлын өсөлтийг хоёр улирлын хоцрогдолтойгоор инфляцитай харьцуулж Зураг 3-т үзүүллээ.

⁹ Дундажлахдаа геометр дунжийг ашиглав. ДНБ-ийг экспортлогддог болон экспортлогддоггүй салбараар салгахдаа ХАА-н салбарыг аль ч ангилалд оруулаагүй болно.

Зураг 3. Дундаж цалингийн улирлын өсөлт болон улирлын инфляци¹⁰




Эцэст нь дүгнэж хэлэхэд манай орны хувьд нэрлэсэн цалингийн өсөлт инфляци нэмэгдэх шалтгаан мөн. Түүнчлэн уул уурхайн салбарт хөрөнгө оруулалт ихээр хийгдэж байгаа нь тус салбарын бүтээмж, цалингийн өсөлтийг нэмэгдүүлж, хөдөлмөр чөлөөтэй шилждэгээс бусад салбарын цалинг мөн өсгөж, экспортлодоггүй салбарын цалингийн өсөлт нь тус салбарын бүтээгдхүүний үнийг өсгөхөд хүргэж улмаар бүтцийн шинж чанартай инфляцийг бий болгох боломжтой.

1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн хэлбэлзэл, гадаад валютын урсгал


Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сүүлийн 17 сарын турш харьцангуй тогтвортой байв. Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан албан ханшийн нэг өдөрт ногдох хэлбэлзэл 0.06 хувь, үүнээс дундаж хэлбэлзэл чангарахдаа 0.17 хувь, сулрахдаа 0.19 хувь өөрчлөгдөж байлаа.

Зураг 1.6 Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хөдөлгөөн



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.7 Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдрийн өөрчлөлт




Эх сурвалж: Монголбанк

¹⁰ Эдгээр өгөгдлүүдийн улирлын хэлбэлзлийг засварласан болно.


Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан албан ханш 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар оны эхнээс 143.75 төгрөгөөр буюу 9.9 хувиар чангарав. Энэ нь манай улсын гадаад худалдааны нөхцөл сайжирч, гадаад тэнцэл тогтворжсонтой холбоотой. Төлбөрийн тэнцэл энэ оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 17.6 хувиар сайжирсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт 5.3 дахин нэмэгдсэнээр хөрөнгө санхүүгийн данс 466 сая ам.долларын ашигтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 3.4 дахин өссөн, оны эхний 7 сарын байдлаар гадаад худалдааны алдагдал 20 гаруй хувиар буурсан, оны эхний 8 сарын байдлаар нийт валютын цэвэр орох урсгал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5 дахин, үүнээс ам.долларын цэвэр орох урсгал 9 дахин нэмэгдсэн зэрэг макро эдийн засаг, зах зээлийн суурь нөхцөл, хүчин зүйлстэй холбоотой байв.

Төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар оны эхнээс 5.2 хувиар, бодит үйлчилж буй ханш 22.5 хувиар тус тус чангарчээ. Төгрөгийн бодит үйлчилж буй ханш дотооддоо нэрлэсэн ханш, инфляциас, гадаадад худалдааны түнш орнуудын инфляциас хамаарах боловч энэ удаад манай инфляци нөлөө ихтэй байлаа.

Зураг 1.8 Төгрөгийн нэрлэсэн (NEER) болон бодит үйлчилж буй ханш (REER)




Зураг 1.9 Төгрөгийн ханшийн хэлбэлзэл



Гадаад валютын урсгал


Энэ оны 8 дугаар сарын эцсийн байдлаар гадаад валютын нийт орох урсгал өнгөрсөн оны мөн үеэс 1.8 дахин, гарах урсгал 1.6 дахин, цэвэр орох урсгал 3.4 дахин нэмэгджээ. Үүнээс, ам.долларын цэвэр орох урсгал 6.5 дахин, юанийнх 2.8 дахин өссөн байна. Нийт валютын

Зураг 1.11 Гадаад валютын цэвэр урсгал



Эх сурвалж: Монголбанк

Зураг 1.10 Гадаад валютын орох урсгалын бүтэц



Эх сурвалж: Монголбанк

цэвэр орох урсгал оны эхнээс 665.3 сая ам.доллартай тэнцэх хэмжээнд хүрсэн байна.

Гадаад валютын орох урсгалын бүтцэд экспортын орлого 2010 оны 8 дугаар сарын байдлаар 53 хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалт 15 хувь, гадаадаас авсан зээл, бэлэн мөнгө харилцах 18 хувь, урсгал шилжүүлэг 6 хувь, үйлчилгээ 3 хувь, зээлийн төлбөр, бэлэн мөнгө харилцах 3 хувийг тус тус эзэлж байна. Харин гарах урсгалын 60 хувийг импортын төлбөр, 14 хувийг гадаадад байршуулсан бэлэн мөнгө харилцах болон гадаадад олгосон зээл, 9 хувийг гадаадад байршуулсан бэлэн мөнгө харилцахын төлбөр болон гадаадад олгосон зээлийн төлбөр, 7 хувийг үйлчилгээ, 4 хувийг орлого, 2 хувийг урсгал шилжүүлэг тус тус бүрдүүлж байна. Цаашид гадаад худалдаа, санхүүгийн үйл ажиллагаа идэвхжихтэй уялдан гадаад валютын урсгалын хэмжээ нэмэгдэх хандлагатай байна.

Шигтгээ 3. Төгрөгийн тогтвортой байдалд валютын ханшийн хэлбэлзлийн үзүүлэх нөлөө болон түүний асимметр шинж

Валютын нэрлэсэн ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх, бодит үйлчилж буй ханшийн тэнцвэрт түвшинээсээ гажих гажуудлыг бууруулах замаар макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангах эрүүл, зохистой макро бодлогын хувилбар болно. Онолын хувьд валютын ханшийн хэлбэлзэл нь дараах хоёр сувгаар дамжин эдийн засагт нөлөөлдөг. Үүнд: (i) бодит үйлчилж буй ханшаар дамжин цэвэр экспортод нөлөөлж, улмаар бодит эдийн засагт нөлөөлдөг. (ii) нэрлэсэн ханшийн өөрчлөлтөөр шууд, шууд бус байдлаар дотоодын бараа,


үйлчилгээний үнийн түвшин буюу инфляцид нөлөөлж, улмаар бодит үйлчилж буй ханшийг хэлбэлзүүлэх, зарим тохиолдолд тэнцвэрт түвшнээс нь гажуудуулдаг байна.

Бодит үйлчилж буй ханш нь худалдааны түнш орнуудын болон дотоод үнийн түвшинүүдийн харьцаа, тухайн орнуудын валюттай харьцах төгрөгийн нэрлэсэн ханшийн өөрчлөлтөөс хамаарна. Иймд бодит ханш чангарах нь дотоодын бараа, үйлчилгээний үнийг бусад орнуудтай харьцуулахад харьцангуй үнэтэй болгож манай экспортын барааны гадаад эрэлт буурч, эсрэгээр импортын бараа, бүтээгдэхүүний дотоод эрэлт өсдөг. Үр дүнд нь экспортын бараа, бүтээгдэхүүний биет хэмжээ буурч, импортын бараа, бүтээгдэхүүний биет хэмжээ өснө. Бусад орнуудын туршлагаас харахад бодит үйлчилж буй ханшийн хэлбэлзэл нь богино хугацаанд экспорт, импортын бараа, бүтээгдэхүүний өртөгт нөлөөлж, харин дунд, урт хугацаанд тоо, хэмжээнд нь нөлөөлдөг буюу богино хугацаанд гадаад худалдааны тэнцлийг сайжруулдаг ч урт хугацаанд муутгадаг.

Зураг 1а. Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн индекс (улирлаар)



Зураг 1б. Эдийн засгийн өсөлт (уул уурхайн болон уул уурхайн бус салбараар, жилээр)




Эх сурвалж: УСХ, Судлаачийн тооцоо

Манай орны худалдааны нөхцөл нь экспорт, импортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлтөөс хамаарал өндөртэй бөгөөд үнийн хэлбэлзэл нь худалдааны нөхцлийг савлуулах, улмаар бодит үйлчилж буй ханшийг хэлбэлзэхэд хүргэдэг (Зураг 1). Эдийн засаг уул, уурхайн салбар дээр суурилдаг, тухайн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнээс хараат байх нь эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх, бодит үйлчилж буй ханш хэлбэлзүүлэх, улмаар үндэсний үйлдвэрлэлийн өрсөлдөх чадвар бууруулж, эдийн засгийн бүтцийг өөрчлөх сөрөг үр дагавартай байдаг. Дээрх байдал нь эдийн засгийг “Голланд өвчин” үрүү хөтөлдөг бөгөөд энэ нь “Зардлын нөлөө”, “Нөөц шилжилтийн нөлөө” гэсэн 2 сувгаар эдийн засагт илэрдэг. Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний экспорт нэмэгдснээр түүнийг дагасан хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэж, улмаар эдийн засагт төсвийн зарцуулалт их хэмжээгээр нэмэгдэх нь дотоод эрэлтийг нэмэгдүүлдэг. Энэ үзэгдлийг

“Зардлын нөлөө” гэж нэрлэдэг бөгөөд энэ нөлөө нь дотоодын худалдаалагддаггүй барааны үнэ нь худалдаалагддаг барааны үнээс илүү хурдацтай өсөхөд хүргэж, улмаар бодит үйлчилж буй ханшийг чангаруулдаг. Бодит үйлчилж буй ханш чангарснаар тухайн улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар буурч, худалдаалагддаггүй салбараас капитал болон хөдөлмөр худалдаалдаг салбар уруу шилждэг бөгөөд энэ үзэгдлийг “Нөөц шилжилтийн нөлөө” гэж нэрлэдэг. Дээрх 2 нөлөөг Зураг 2-т харуулав.

Зураг 2: Голланд өвчин



Х.С.= Худалдаалагддаг Салбар
Хг.С. = Худалдаалагддаггүй Салбар
НССБ=Нийгмийн сайн сайхан байдал
ТХ= Төсвийн Хязгаарлалт


Уул уурхайн салбараас бий болсон орлогын өндөр өсөлт нь худалдаалагддаггүй салбарын эрэлтийг нэмэгдүүлж (C цэгээс C*), тус салбарын үнийн түвшин өсгөдөг. Энэ нь худалдаалагддаг болон худалдаалагддаггүй салбарын харьцангуй үнээр илэрхийлэгдэх валютын бодит үйлчилж буй ханшийг чангаруулдаг (Зардлын нөлөө). Дээрх харьцангуй үнийн өсөлт нь худалдаалагддаггүй салбарын цалингийн хэсэг хугацааны өсөлтийн шалтгаан болж, улмаар цалингийн зөрүүг даган хөдөлмөр тус салбар уруу шилжсэнээр худалдаалагддаг салбарын нийлүүлэлт буурч, эсрэгээр худалдаалагддаггүй салбарын нийлүүлэлтийг нэмэгдүүдэг (Нөөц шилжилтийн нөлөө). Үүнийг “Нөөцийн шилжилтийн нөлөө” гэх бөгөөд

энэ нөлөө нь дээр дурьдсан зардлын нөлөөтэй хавсран худалдаалагддаг салбарын үйлдвэрлэлийг A^* түвшин үрүү бууруулж, харин худалдаалагддаггүй салбарын үйлдвэрлэл C^{**} цэг хүртэл өсгөдөг. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэлийн боломжийн муруй дээрх цэгийн шилжилт явагдах буюу B цэгээс B^* цэгийн хооронд шилжилт хийгдэх юм. Мөн харьцангуй үнийн өөрчлөлтөөс болж төсвийн хязгаарлалтын шулууны налалт өөрчлөгдөх ба уул, уурхайн салбарын орлогын нөлөөгөөр улсын төсөв зарцуулалт өссөнөөр шилжилт хийгдэнэ. Улмаар худалдаалагддаг салбарын эрэлт орлогын болон орлуулалтын нөлөөгөөр дамжин A^{**} түвшин болж өснө. Эцэст нь уул уурхайн салбарын орлогын өсөлт нь A^* цэгээс A^{**} цэг хүртэлх хэмжээний гадаад худалдааны алдаглыг санхүүжүүлэх сөрөг дагавар ажиглагдаж байна.


Иймд бодлого боловсруулагчид бодит ханшийн чангаралтын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахын тулд нэрлэсэн ханшийн богино хугацааны хэлбэлзэл болон дунд, урт хугацааны макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдтэй нийцтэй байх бодит ханшийн тэнцвэрт түвшин сонирхдог. Түүнчлэн валютын ханшийн тэнцвэрт түвшинг тодорхойлогч хүчин зүйлсийг илрүүлэх болон бодит үйлчилж буй валютын ханшийн тэнцвэрт түвшинээсээ зөрж буй шалтгааныг тодруулах нь чухал ач холбогдолтой юм.

Бодит үйлчилж буй ханш нь макро эдийн засгийн суурь үзүүлэлтүүдээс хамаарч тодорхойлогдох ёстой ба тэнцвэрээсээ илүү эсвэл дутуу үнэлэгдэх нь эдийн засагт сөргөөр нөлөөлдөг гэж эдийн засагчид үздэг. Өөрөөр хэлбэл, валютын ханш тэнцвэрт түвшинээсээ илүү буюу хэт үнэлэгдэх нь урсгал тэнцлийн алдагдлыг тогтворгүй болгож, эдийн засагт гадаад өр болон валютын ханшийн довтолгоонд өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх зэрэг сөрөг үр дагавартай байдаг. Ерөнхийдөө үндэсний валютын ханш хэт үнэлэгдэх нь эдийн засгийн өсөлт бага байхад нөлөөлдөг. Нөгөө талаар мөнгөний бодлогын хэлбэр дэх валютын ханшийн үүргийг зохистой тодорхойлж, нэрлэсэн ханшинд бодлогын түвшинд нөлөөлөх тохиолдолд валютын ханшийн гажилтыг бууруулах чиглэлд нийцтэй байх зарчмыг баримтлах нь эдийн засгийн харилцан уялдаа хадгалагдахад туйлаас чухал байдаг. Бодит үйлчилж буй валютын ханшийн гажилтыг богино болон урт хугацааны гэж ангилдаг бөгөөд богино хугацаанд спекулятив буюу ашиг хонжооны сонирголоос шалтгаалан тэнцвэрээс гаждаг бол урт хугацаанд эдийн засгийн суурь үзүүлэлтүүдийн мөчлөг болон ашиг хонжооны сонирголоос шалтгаалан тэнцвэрт түвшинээс гажидаг гэж үздэг (Зураг 3а, б).

Зураг 3а. Бодит үйлчилж буй ханшийн богино хугацааны гажуудал



Зураг 3б. Бодит үйлчилж буй ханшийн урт хугацааны гажуудал




Эх сурвалж: Монголбанкны тооцоо

Манай орны хувьд төгрөгийн бодит үйлчилж буй ханш 1999-2009 оны хооронд тэнцвэрт түвшнээсээ дутуу үнэлэгдэж ирсэн дундаж хувь 4.5, илүү үнэлэгдэж ирсэн дундаж хувь 5.1 байгаа бөгөөд 1999-2009 оны хооронд бүх зөрүүний дундаж хувь нэмэх 1.1 хувь байгаа нь цаг хугацааны туршид төгрөгийн бодит ханш ерөнхийдөө хэт үнэлэгдэж байжээ.¹¹ Энэ нь төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн нөлөө гэхээсээ илүүтэй өндөр хэлбэлзэлтэй инфляциас шалтгаалсан байна. Өөрөөр хэлбэл, бодит үйлчилж буй ханшийн тэнцвэрт түвшинг хадгалахын тулд үнийн өсөлт болон нэрлэсэн валютын ханшийн өндөр хэлбэлзлээс зайлсхийх шаардлагатайг харуулж байна. Тухайлбал, манай оронд төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханшийн хэлбэлзэл нь дотоодын үнийн түвшин болон бодит үйлчилж буй ханшинд үзүүлэх нөлөө нь хөгжиж буй орнуудтай харьцуулахад хүчтэй байдаг (Зураг 4-т харуулав). Доорх зургаас ажиглахад 2005-2007 хүртэлх нэрлэсэн ханш харьцангуй тогтмол байсан бөгөөд бодит ханшийн чангаралт нь голчлон үнийн өсөлтөөр тайлбарлагдахаар байна. Харин 2008 оны хувьд нийлүүлэлтийн хүчин зүйлээр өдөөгдсөн өндөр инфляциас шалтгаалан бодит үйлчилж буй ханш огцом чангарсан бол 2008 оны сүүлээс 2009 оны эхний улирлын хооронд дэлхийн эдийн засгийн хямралын нөлөөгөөр үндэсний валютын ханш огцом суларсан учир бодит үйлчилж буй ханш огцом суларчээ.

¹¹ Д.Ган-Очир, Т.Оюунбаатар, (2009), “Төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханшийн тэнцвэрт түвшний судалгаа”

Зураг 4. Төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн болон бодит ханш (улирлаар)




Эх сурвалж: Монголбанкны тооцоо

2009 оны сүүлийн хагасаас төгрөгийн гадаад валюттай харьцах ханш тогтворжиж, үнийн өсөлт саарснаар бодит үйлчилж буй ханшийн хэлбэлзэл буурч байсан бол 2010 оны эхнээс хүнс (махны үнийн өсөлт) болон төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнийн өсөлтөөс шалтгаалж инфляци хурдацтай өссөн, мөн уул, уурхайн томоохон төслүүд болон улирлын нөлөөгөөр төгрөгийн ханш чангарч байгаа зэргээс үүдэн бодит үйлчилж буй ханш эргээд чангарч буй дүр зураг ажиглагдаж байна.


Нөгөө талаас, манай орны хувьд төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханшийн өөрчлөлт нь богино хугацаанд дотоодын үнийн түвшинд өндөр нөлөөтэй бөгөөд уг нөлөө нь асимметр шинжтэй байдаг нь судалгаагаар нотлогдсон¹².

12 Д.Ган-Очир, (2009), "Төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш ба инфляцийн хоорондох харилцан хамаарал" болон Б.Даваадалай, П.Авралт-Од (2010) нарын "Валютын ханшийн инфляцид эзлэх асимметр нөлөөг шалгах нь" зэрэг судлагааны ажлаас дэлгэрэнгүйг харах боломжтой.

Зураг 5a. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн ХҮИ-д үзүүлэх симметр нөлөө (сараар)



Зураг 5b. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн ХҮИ-д үзүүлэх асимметр нөлөө (сараар)



Эх сурвалж: Судлаачийн тооцоо


Хэрэв төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн чангаралт болон сулралтын ХҮИ-д үзүүлэх нөлөөг симметр гэж үзвэл, төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн 1 хувийн өөрчлөлт (чангаралт/сулралт)-ийн ХҮИ-д эхний улиралдаа бараг нөлөөгүй бол 6 сарын дараагаас нөлөө нь нэмэгдэж 9-12 сарын дараа хамгийн өндөр түвшиндээ хүрдэг байна. 2010 оны эхний улирал хүртэл түүврийн үнэлгээнээс үзэхэд манай эдийн засагт төгрөгийн ам.доллартай харьцах ханш 6, 12, 18 сарын хугацаанд 10 хувиар өөрчлөгдөх тохиолдолд тус хугацаанд ХҮИ харгалзан дунджаар 3.1, 4.1, 4.3 хувиар өөрчлөгддөг байна (Зураг 5a).

Гэвч манай оронд үнийн асимметр өөрчлөлт 2008 онд маш тод ажиглагдсан бөгөөд дэлхийн зах зээл дээрх түүхий нефтийн үнийн огцом өсөлт болон ОХУ-ын гаалийн татварын нэмэгдэлээс шалтгаалан дотоодын шатахууны үнэ 400-500 төгрөгөөр, өргөн хэрэглээний барааны үнэ өндөр хувиар өссөн бол түүхий нефтийн үнэ буцаж буурахад дотоодын шатахууны үнэ анх өссөнөөсөө хамаагүй бага хэмжээгээр буюу 100-200 төгрөгөөр буурч, харин өргөн хэрэглээний барааны үнэ огт буулгүй хэвээр үлдэж байсан. Иймд төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн чангаралт болон сулралтын ХҮИ-д үзүүлэх нөлөөг асимметр байдлаар авч үзвэл, төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1 хувиар сулрахад ХҮИ дунджаар 0.55 хувиар өсдөг бол 1 хувиар чангарахад 0.35 хувиар буурдаг байна (Зураг 2b).

Дээрх үр дүнгээс харахад төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн ХҮИ-д үзүүлэх нөлөө асимметр байгаа нь нэрлэсэн ханшийн өндөр хэлбэлзэл нь дотоодын инфляцийн түвшинг нэмэгдүүлж (Зураг 6a), улмаар бодит үйлчилж буй ханшийг чангаруулах сөрөг нөлөөтэйг


илтгэж байна (Зураг 6б). Дээрх сөрөг нөлөөг тайлбарлах үүднээс Зураг 3-т энгийн жишээ авч үзье. Хэрэв худалдааны түнш орнуудын инфляцийн түвшинг тогтвортой гэж таамаглан, төгрөгийн нэрлэсэн ханш 8 улирлын турш тогтмол 1 хувиар хэлбэлзэх¹³ тохиолдолд нэрлэсэн ханшийн дундаж түвшин өөрчлөгдөхгүй боловч хугацааны эцэст ХҮИ-ийг анхны түвшингээс 0.8 хувиар, бодит ханшийг 0.84 хувиар тус тус өсгөж байна. Өөрөөр хэлбэл, төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн инфляцид үзүүлэх нөлөө нь асимметр үед 1 хувийн хэлбэлзэл нь инфляцийг 0.8 нэгж хувиар нэмэгдүүлэхээр байна. Харин төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн 3 хувийн хэлбэлзэл нь ХҮИ болон бодит ханшийг харгалзан 2.4 хувь, 2.44 хувиар тус тус өсгөхөөр байгаа юм. Эндээс ажиглахад төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн хэлбэлзлийн далайц нэмэгдэх тусам инфляцийг өсгөх, бодит үйлчилж буй ханшийг чангаруулах дарамт нэмэгдэнэ.

Зураг 6а. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн хэлбэлзлийн ХҮИ-д үзүүлэх нөлөө (улирлаар)



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Зураг 6б. Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн ханшийн хэлбэлзлийн бодит ханшинд үзүүлэх нөлөө (улирлаар)



Эх сурвалж: Судлаачийн тооцоо

Эцэст нь дүгнээд хэлэхэд манай орны хувьд: (i) нэрлэсэн валютын ханшийн инфляцид үзүүлэх нөлөө нь өндөр тул үнийн түвшинг тогтвортой барихад хүндрэл учирдаг. (ii) богино хугацааны валютын ханшийн инфляцид үзүүлэх нөлөө асимметр шинжтэй тул нэрлэсэн ханшийн өндөр хэлбэлзэл нь бодит ханшийг чангаруулж, дотоод эдийн засгийн өрсөлдөх чадварыг бууруулахын зэрэгцээ инфляцийн түвшинг нэмэгдүүлдэг. (iii) валютын ханшийн огцом хэлбэлзэл нь ханшийн эрсдэлийг нэмэгдүүлж, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг. (iv) хөрөнгийн их хэмжээний дотогшлох урсгал гэнэт зогсох нь

¹³ Эхний улиралд сулрах, дараагийн улиралд чангарах гэх мэтээр хэлбэлзэнэ гэж үзсэн.

эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх өндөр магадлалтай. (v) санхүүгийн захын сул хөгжсөн тул валютын ханшийн шокийн нөлөөг шингээх дархлаа муутай зэрэг хүндрэл бэрхшээлүүд ажиглагдаж байна.

Иймд мөнгөний бодлого нь дунд хугацааны үнийн түвшинг тогтворжуулахад чиглэгддэг тул валютын ханшийн өндөр хэлбэлзлийг бууруулах зарчим баримтлах шаардлагатай. Мөн төгрөгийн бодит ханш илүү эсвэл дутуу үнэлэгдэж буй эсэхийг илүү нарийн тодорхойлж тэдгээрийн учир шалтгаан, ирээдүйн таамаглалыг тогтмол судалж үр дүнг мөнгөний бодлогод харгалзан үзэх шаардлагатай юм.


1.4 Гадаад худалдаа

2010 оны эхний 8 сарын байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 3758.8 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 59.8 хувиар өсчээ. Гадаад худалдааны алдагдал 171.6 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 7.9 хувиар буурсан бол валютын төлбөртэй барааны тэнцэл 18.0 сая ам.долларын алдагдалтай гарсан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 53.2 хувиар сайжирсан. Экспортын өсөлт импортын өсөлтөөс 10.8 нэгжээр илүү байсан нь гадаад худалдааны алдагдал буурахад голлон нөлөөлжээ. Нийт экспортын 84.4 хувь буюу 1513.7 сая ам.долларын бүтээгдэхүүнийг Хятад улс руу экспортолсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 188.4 хувиар өссөн дүн юм. Монгол улс зэсийн баяжмал, чулуун нүүрс болон цайрын баяжмалыг 100 хувь Хятад руу экспортолж байна. Нийт импортолсон бүтээгдэхүүний 684.8 сая ам.доллар буюу 34.8 хувийг ОХУ-аас, 574.6 сая ам.доллар буюу 29.2 хувийг Хятадаас тус тус оруулж ирсэн. 2010 оны 8 дугаар сарын хувьд гадаад худалдааны алдагдал 40.9 сая ам.долларын алдагдалтай гарсан бол энэ нь өмнөх сартай харьцуулахад 50.7 хувиар сайжирчээ.

Хүснэгт 1.4 Гадаад худалдааны эргэлт (сая ам.доллар)

Гол үзүүлэлтүүд	Эхний 8 сар		Δ%
	2009	2010	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	2 351,8	3 758,8	59,8%
• Валютын төлбөртэй бараа	2 191,5	3 575,0	63,1%
Экспорт	1 082,7	1 793,6	65,7%
• Валютын төлбөртэй бараа	1 076,5	1 778,5	65,2%
Импорт	1 269,1	1 965,2	54,9%
• Валютын төлбөртэй бараа	1 115,0	1 796,5	61,1%
Гадаад худалдааны тэнцэл	-186,3	-171,6	-7,9%
• Валютын төлбөртэй бараа	-38,5	-18,0	-53,2%


Зураг 1.12 Гадаад худалдааны эргэлт, сараар (сая ам.дол.)



Монгол Улсын гадаад худалдааны нөхцөл¹⁴ 2010 оны эхний 8 сарын байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 23.1 хувиар сайжирч 1.635-д хүрэв. Үүнд экспортын үнийн индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.3 хувиар сайжран 3.998-д хүрсэн нь голлон нөлөөлжээ.

Импортын үнийн индексийн хувьд өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 22.4 хувиар өсөн 2.446-д хүрсэн ч, экспортын үнийн индексийн өсөлт нь 26.9 нэгжээр илүү байсан нь худалдааны нөхцөлд эерэгээр нөлөөлжээ.

Зураг 1.13 Худалдааны нөхцөл, сараар



Экспортын гол нэрийн бараа, түүхий эд

Эхний 8 сарын байдлаар нийт экспортын 27.9 хувийг зэсийн баяжмал, 27.0 хувийг чулуу нүүрс, 7.6 хувийг мөнгөжөөгүй алт, 7.4 хувийн төмрийн хүдэр ба баяжмал тус тус бүрдүүлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чулуун нүүрсний экспортын биет хэмжээ 2.3 дахин, боловсруулаагүй нефтийн биет хэмжээ 1.7 дахин, төмрийн хүдэр, баяжмалын биет хэмжээ 1.9 дахин, ямааны угаасан ноолуурын биет хэмжээ 1.1 дахин өссөн байна. 2010 оны эхний 8 сард Монголбанк 0.9 тн, “Бороо Гоулд” ХХК 2.9 тн алт тус тус экспортолсон бол 2009 оны мөн үед Монголбанк 4.1 тн, “Бороо Гоулд” ХХК 2.7 тн алт тус тус экспортолж байжээ.

Хүснэгт 1.5 Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 8 сар				Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар/
	2009		2010		
	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	Хэмжээ /тн, баррель/	Мөнгөн дүн	
1 Зэсийн баяжмал	290 440	272,8	287 946	500,0	83% ↑
2 Чулуун нүүрс	2 741 882	178,2	6 309 707	484,1	172% ↑
3 Мөнгөжөөгүй алт	6 202	44,3	3 132	137,2	210% ↑
4 Төмрийн хүдэр ба баяжмал	613 421	186,1	1 205 291	132,9	-29% ↓
5 Ямааны угаасан ноолуур	2 205	87,5	2 449	100,1	14% ↑
6 Боловсруулаагүй нефть	618 415	52,2	1 040 282	98,2	88% ↑
7 Цайрын хүдэр ба баяжмал	59 015	67,9	59 254	85,5	26% ↑
8 Жонш, лейцит, нефелинг ба	119 687	27,2	179 492	40,7	50% ↑
9 Молибдений хүдэр ба баяжмал	3 073	25,8	2 386	35,4	37% ↑
10 Ямааны самнасан ноолуур	591	43,2	282	31,1	-28% ↓
Бусад		97,5		148,4	52% ↑
Нийт экспорт		1 082,7		1 793,6	66% ↑


¹⁴ Экспортод дунджаар 90 орчим хувийг эзэлдэг 10 бүтээгдэхүүн, импортод дунджаар 88 орчим хувийг эзэлдэг 7 бүлэг бүтээгдэхүүний хувьд худалдааны нөхцөлийн индексийг 2000 оныг суурь болгон тооцов.

2010 оны эхний 8 сарын байдлаар алт, ямааны угаасан, самнасан ноолуур, цайрын хүдэр, баяжмалын биет хэмжээ буурснаар нийт экспорт 139.6 сая ам.доллараар буурах байсан боловч, (i) чулуун нүүрс, (ii) боловсруулаагүй нефть, (iii) төмрийн хүдэр, (iv) жонш, лейцит, нефелинт сиенитийн экспортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан 341.1 сая ам.доллараар, эдгээр бүтээгдэхүүнүүд болон эрдэс бүтээгдэхүүний экспортын үнийн өсөлтөөс шалтгаалан 447.3 сая ам.доллараар тус тус нэмэгдэв. Ингэж экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс өслөө.


Зураг 1.15 Лондонгийн металлын бирж дээрх зэс, цайрын үнэ



Зураг 1.14 Экспортын үнийн болон тоо хэмжээний үнийн өөрчлөлт /сая ам.доллар/



Зураг 1.16 Чулуун нүүрсний зах зээлийн үнэ, сараар



2010 оны эхний 8 сарын байдлаар Монгол улсын экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ өмнөх оны мөн үеэс өссөн байна. Тухайлбал, Лондонгийн металлын бирж дээрх А зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон цайрын үнэ тус тус 1.5 дахин өсч, тонн тутамд харгалзан 7101.6, 2104.7 ам.доллар хүрчээ. Мөн оны эхний 8 сард Өвөрмонголын нүүрсний дундаж үнэ 15.5 хувиар, Монгол улсын экспортын нүүрсний дундаж үнэ 24.0 хувиар тус тус өсчээ.

Импортын гол нэрийн бараа, түүхий эд

2010 оны эхний 8 сарын байдлаар нийт 1965.2 сая ам.долларын бараа, бүтээгдэхүүн импортоор оруулж ирсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 54.9 хувиар буюу 696.1 сая ам.доллараар өсчээ. Нийт импортын 20.3 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 17.3 хувийг хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл, 11.2 хувийн тээврийн хэрэгслийн тус тус бүрдүүлж байна. Нефтийн бүтээгдэхүүний 96.8 хувийг ОХУ-аас авсан байна. Монгол улс 2010 онд нийт 840.0 гаруй сая ам.долларын нефтийн бүтээгдэхүүн импортлох төлөвтэй байна. Энэ нь өнгөрсөн оноос 60.0 хувиар өсөх үзүүлэлт юм.


2010 оны эхний 8 сард нийт импорт (i) нефтийн бүтээгдэхүүн, (ii) хүнд механизм, тоног төхөөрөмж, (iii) тээврийн хэрэгслийн импортын биет хэмжээний өсөлтөөс шалтгаалан 244.0 сая ам.доллараар, эдгээр болон бусад бүтээгдэхүүн хилийн үнийн дундаж өсөлтөөс шалтгаалан 161.9 сая ам.доллараар тус тус нэмэгдсэнээр өнгөрсөн оны мөн үеэс 696.1 сая ам.доллараар өссөн байна.

Монгол улсад хэрэгжих уул уурхайн төслүүдийн хүрээнд хөрөнгө оруулалтаар орж ирж буй хүнд механизм, тоног төхөөрөмжийн импортын тоо хэмжээ өсөх хандлагатай байна.


Хүснэгт 1.6 Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллар/

Нэр төрөл	Эхний 8 сар		Өөрчлөлт /хувиар/
	2009	2010	
1 Нефтийн бүтээгдэхүүн	285,4	398,0	39% ↑
2 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	165,7	340,9	106% ↑
3 Тээврийн хэрэгсэл	122,8	219,2	79% ↑
4 Хүнсний бүтээгдэхүүн	102,0	104,9	2,9% ↑
6 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	46,4	68,0	46% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	20,9	38,7	85% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	28,9	15,0	-48% ↓
8 Төрөл бүрийн даавуу	0,8	1,1	29% ↑
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	53,8	86,3	60% ↑
Бусад	442,2	693,1	57% ↑
Нийт импорт	1 269,1	1 965,2	55% ↑


Зураг 1.17 Импортын үнийн болон тоо хэмжээний үнийн өөрчлөлт /сая ам.доллар/



Зураг 1.16 Монгол улсын нефтийн импорт (сараар)



Зураг 1.17 Газрын тосны зах зээлийн үнэ¹⁵



Уралын газрын тосны дундаж үнэ 2010 оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 39.0 хувиар нэмэгдсэн бол мөн хугацаанд манай улсын импортын нефтийн бүтээгдэхүүний дундаж үнэ 30.5 хувиар өсчээ.

Монгол улсын гадаад худалдааны нийт бараа эргэлт 2010 оны эхний 8 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 59.8 хувиар өсөхөд экспортын гол нэрийн 10 бүтээгдэхүүний хилийн дундаж үнэ 6.5 хувиар, импортын гол нэрийн бараа, түүхий эдийн биет хэмжээ 36.5 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

2. ИНФЛЯЦИ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН 2011-2012 ОНЫ ТӨСӨӨЛӨЛ

2.1 Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөлөлд ашигласан таамаглал

Ирэх арван улирлын туршид инфляци, эдийн засгийн өсөлт ямар байхыг таамагласан тооцооны үндэслэлийг гадаад, дотоод хүчин зүйлсийг илтгэх үзүүлэлтүүдийг тайлбарлах байдлаар танилцуулъя.


БНХАУ-ын эдийн засгийн өсөлт, инфляци

Хятадын Засгийн газрын хэрэгжүүлсэн эдийн засгийг дэмжих бодлого, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой өсөлт, аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн сэргэлт, дэд бүтэц, үл хөдлөх хөрөнгийн захын идэвхижилт зэргээс шалтгаалан 2010 оны эхний улиралд эдийн засаг нь 11.9 хувь өсөв (Зураг 2.1). Үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт болон зарим үзүүлэлтийн өндөр өсөлтөөс шалтгаалан дунд хугацаанд эдийн засаг нь хэт халах эрсдэл байгаа бөгөөд үүний эсрэг хүүгээ өсгөх, юаны ханшийг чангаруулах зэрэг бодлогын арга хэмжээг бодлого боловсруулагчид авч магадгүй хэмээн судлаачид үзэж байна.

¹⁵ Эх сурвалж: АНУ-ын эрчим хүчний мэдээллийн агентлаг (www.eia.doc.gov), ОХУ-ын Уралын газрын тосны үнэ.

Хятадын Засгийн газраас хэрэгжүүлсэн тэлэх бодлогын нөлөө болон дэлхийн эдийн засгийн сэргэлтээс шалтгаалан 2010 онд тус улсын хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалт үргэлжлэн өсөхөөр байна. Гэвч европын зарим улсуудын хямралт байдлаас шалтгаалан 2011 онд энэ өсөлт саарна хэмээн судлаачид таамаглажээ.

Зураг 2.1 Эдийн засгийн өсөлт болон инфляци



Хятадын дотоод үнийн түвшин 2010 оны 2 улирлын байдлаар 2.9 хувиар өссөн нь өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар доогуур гарчээ. Хэдийгээр инфляци нь өмнө хүлээж байснаас доогуур ч Хятадын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засгийг дэмжих бодлого ойрын болон дунд хугацаанд инфляцид ихээхэн дарамт учруулахаар байгаа юм. Мөнгөний Бодлогын Зөвлөлийн сүүлийн хурлаар бодлогын хүүгээ өөрчлөхгүй байх шийдвэр гаргасан нь одоогийн хэрэгжүүлж буй бодлогоо цаашид хэвээр хадгалах сонирхол давамгайлж байгааг илтгэж байна.

АНУ-ын эдийн засгийн өсөлт болон инфляци.


Тус улсын эдийн засаг 2010 оны эхний хагаст өмнө хүлээж байснаас багаар өсч энэ байдал оны сүүлийн хагаст ч үргэлжлэн, оны эцэст 2.8 хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Мөн 2011 онд АНУ-ын хөрөнгө оруулалт буурах, европын зарим улс, орнуудын төсөв хямарч байгаагаас шалтгаалан эдийн засгийн өсөлт өмнө хүлээж байснаас буурч гарахаар байна. Холбооны Нөөцийн Банк(ХНБ)-ны мөнгөний бодлогын зөвлөл сүүлийн хурлаараа бодлогын хүүгээ хэвээр хадгалах шийдвэр гаргасан нь дотоод эдийн засаг, санхүүгийн орчныг үргэлжүүлэн сайжруулах, эдийн засгийн сэргэлт удаан байгааг илтгэж байна. Харин тус улсын үнийн түвшин 2010 оны хагаст өмнөх оноос 1.05 хувиар өссөн нь харьцангуй бага үзүүлэлт байв. Энэ

нь эдийн засаг өсч, орлого нэмэгдсэн ч иргэд хэрэглээгээ нэмэгдүүлэхээс илүүтэй хуримтлал хийх сонирхол нь давамгайлж байгаагийн илрэл юм. Дотоодын өрхийн хэрэглээ аажмаар нэмэгдэж байгаа ч ажилгүйдлийн түвшин, орлогын бага өсөлт, зээлийн хатуу нөхцөл зэрэг үзүүлэлтүүд анхаарал татсаар байна. Ойрын болон дунд хугацаанд үнэ хурдтай өсөх эрсдэл байгаагаас ХНБ 2011 оны эцэс хүртэл хүүгээ улирал бүр 0.25 нэгж хувиар өсгөн 1.5 хувьд хүргэх магадлалтай гэж судлаачид үзэж байна.

Түүхий нефтийн үнэ

АНУ-ын эдийн засаг 2010, 2011 онд дунджаар 2 хувийн өсөлттэй гарахаар байгаа нь нефтийн хэрэглээ буурах нөхцөл бий болгохоор байна. Дэлхийн зах зээл дээр түүхий нефтийн үнэ 2010-2011 онуудад дунджаар 80 ам.доллар байх таамаглалыг хийж байна. Ойрын болон дунд хугацаанд шатахууны үнэ дэлхийн эдийн засгийн сэргэлтээс шалтгаалан өсвөл дотоодын шатахууны үнэ нэмэгдэх дарамтыг бий болгох эрсдэлтэй юм. Тухайлбал, дэлхийн санхүүгийн зах зээлийн тодорхой бус байдал хэрхэн өөрчлөгдөх, түүхий нефтийн зах зээл дээрх үнийн хэлбэлзэл буурах эсэх, шатахуун экспортлогч орнууд нийлүүлэлтээ хязгаарлах бодлого баримтах эсэх зэрэг хүчин зүйлсээс голчлон хамаарч ирэх онуудад түүхий нефтийн үнэ өөрчлөгдөхөөр байна.

Зураг 2.2 Алт, зэс, түүхий нефтийн дэлхийн зах зээлийн үнэ



Эх үүсвэр: Bloomberg.com

Алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ

Америк доллар, евро суларч алтны эрэлт өмнө тооцож байснаас өслөө. Хөрөнгө оруулагчид, ялангуяа, Хятадын хөрөнгийн захын тоглогчид алтанд хөрөнгө илүүтэй байршуулах боллоо. Цаашид голлох валютын ханш өндөр хэлбэлзэх, тогтворгүй байх, дэлхийн эдийн засгийн сэргэлт удаашрах тохиолдолд алтны үнэ улам өсөх боломжтой юм. Дэлхийн эдийн засгийн хямрал зэсийн хэрэглээг нилээд бууруулсан ч эргээд аажим өсч байгаа билээ. Зэсийн үнэ өмнө тооцож байснаас багаар өсч байгаа нь гол хэрэглэгчдийн нэг Хятадын эдийн засаг өссөн ч бусад томоохон хэрэглэгч орнуудын өсөлт саарч, хэрэглээ нь үйлдвэрлэлээс бага байсантай холбоотой юм. Харин ирэх жилүүдэд Хятадын аж үйлдвэр ихээхэн өсөхөөр байгаа нь дэлхийн зэсийн хэрэглээг 5-аас дээш хувиар нэмэгдүүлнэ гэж олон улсын шинжээчид үзэж байна. Мөн нөгөө талаас зэс экспортлогч гол орнууд нийлүүлэлтээ хумих бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа нь ирэх 2011-2012 онуудад зэсийн үнийг нэмэгдүүлэхээр байна.

Төсвийн зардал

Энэ тооцоололд төсвийн нийт зардлын хэмжээг Хүснэгт 2.1-д үзүүлсэн байдлаар авсан. Үүнд: өнгөрсөн 7 дугаар сард УИХ-аас баталсан 2010 оны нэгдсэн төсвийн тодотголоор, 2011-2012 оны төсвийг зарцлуулалтын таамаглалыг УИХ-аас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасан төсвийн тооцооллоор авч ашиглав.

Хүснэгт 2.1 Төсвийн нийт зардал, урсгал шилжүүлэг, тэрбум төгрөгөөр

	Нийт зардал	Өөрчлөлт		Урсгал шилжүүлэг	Өөрчлөлт	
		Абсолют	хувиар		Абсолют	хувиар
2009 гүйц	2 336.6			752.6		
2010 (тод)	3 097.8	761.2	24.6	883.8	131.2	14.8
2011	3250.6	152.8	4.7	907.9	24.1	2.7
2012	3 597.7	347.1	9.6	988.4	80.5	8.1

Эх сурвалж: Сангийн яам

2010 онд төсвийн нийт зардал 761.2 тэрбум төгрөг буюу 25 орчим хувиар, урсгал шилжүүлэг 131.6 тэрбум төгрөг буюу 15 хувиар нэмэгдүүлэхээр УИХ-аас баталсан тодотголд тусгасан. Урсгал шилжүүлгийн өсөлтийн 64 хувь нь хүний хөгжил сангаас иргэн бүрт олгох мөнгөн тэтгэмжийн хэмжээгээр, үлдсэн 36 хувь нь өндөр настангуудын тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд зарцуулагдахаар тооцсон байна.

Малын зүй бусын хорогдол

Махны нийлүүлэлт тасалдаж үнэ нэмэгдвэл инфляцид нөлөө ихтэй хэвээр байна. Уг нөлөө улирлын шинж чанартай бөгөөд цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан шокийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Үүнийг загварт махны үнийн нийлүүлэлтийн шокийн нөлөөг том малын зүй бус хорогдолын нийт малд эзлэх хувь гэсэн үзүүлэлтээр хэмжиж, инфляцийн тэгшитгэлд оруулан энэ оноос тооцож байна. Малын зүй бус хорогдлыг 2010 оны эхний 2 улиралд зудын нөлөөнөөр сүүлийн 10-н жилийн хамгийн өндөр буюу хонин толгойд шилжүүлснээр 18 орчим сая мал хорогджээ. Харин 2010 оны 3-р улирлаас эхлэн том малын зүй бус хорогдол зудгүй үеийнхтэй адил байна гэж үзлээ.

2.2 Инфляцийн төсөөлөл


2010 оны эхний хагаст эрчимтэй нэмэгдэж байсан инфляци 3 дугаар улиралд буурч байна. Гэхдээ махнаас бусад бараа, үйлчилгээний үнэ өмнөх улирлаас нэмэгдэхээр байна. Харин оны сүүл рүү эрэлтийн гаралтай инфляци нэмэгдэх зарим дарамт үүсэх боломжтой байна. Үүнд:

Нэгдүгээрт: 10-р сараас төрийн албан хаагчдын цалин, өндөр настнуудын тэтгэвэр 30 хувиар нэмэгдэн үнэ өсөх хүлээлт бүрдүүлэх,

Хоёрдугаарт: 500 мянган төгрөгийн тэтгэмжийг их, дээд сургуулийн нийт 165 мянган оюутны сургалтын төлбөрт төлөхөөр Засгийн газраас шийдвэрлэсэн нь оюутнуудын одоогийн хэрэглээг нэмэгдүүлж, бараа, үйлчилгээний эрэлтийг нэмэгдүүлэх болно.

Зураг 2.3-д ирэх арван улирлын жилийн инфляцийн интервал таамаглалыг харуулав. Энэ таамаглалыг мөнгөний бодлогын өнөөгийн төлөвийг өөрчлөхгүй буюу бодлогын хүү өөрчлөгдөхгүй, төсвийн бодлого ирэх онуудад харьцангуйгаар хумигдана гэсэн нөхцөл дээр үндэслэн хийсэн юм.

Зураг 2.3 Жилийн инфляцийн интервал таамаглал



УИХ-аас баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгасны дагуу ирэх оны төсвийн зардлыг өмнөх оноос 5 орчим хувиар өснө гэж төсөөлж байна. Энэ төсөөлөл нь эрэлтийн гаралтай инфляцийн дарамтыг үүсгэхгүй бөгөөд 2011 онд жилийн инфляци 2010 оны түвшнээс буурч 1 оронтой тоонд хүрэх боломжтой.

Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгаснаар 2012 онд төсвийн зардлыг 2011 оны төсвийн өсөлтөөс 2 дахин буюу 10 орчим хувиар өсгөхөөр тооцоолсон нь өмнөх онуудтай харьцуулахад бага өсөлт юм. Хэрэв төсвийн зардлын өсөлт харьцангуй бага байх тохиолдолд инфляцийн түвшин бага хэмжээгээр нэмэгдэх ч тогтворжих хандлагатай байна. Мөн Оюу толгой, Таван толгой зэрэг томоохон уул уурхайн төслүүд ашиглалтанд орох бэлтгэл ажил эрчимжин хувийн хэвшлийн эрэлтийг нэмэгдүүлж, инфляцийг өмнөх оноос бага хэмжээгээр өсгөхөөр байна.


2.3 Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Өнгөрсөн оны эдийн засгийн уналт 2010 онд сэргэж, эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн өсөлт 5 хувьд хүрээд байна. Өнгөрсөн өвлийн зудын нөлөөгөөр хөдөө аж ахуйн салбарт огцом уналт бий болсон ч 2010 онд эдийн засгийн өсөлт хямралын өмнөх жилүүдийн түвшинд дөхөж очих тооцоо гарч байна. Үүнд дараах 2 хүчин зүйл голлох нөлөө үзүүлнэ. Нэгд, олон улсын зах дээр уул уурхайн бүтээгдэхүүний үнэ өсч буй, Оюу толгой төслийн бэлтгэл ажил эхэлсэн, шинээр ашиглалтанд орсон нүүрс олборлох уурхайнууд, түүнд үйлчилгээ үзүүлдэг бусад салбаруудын үйлдвэрлэлтийн хэмжээ огцом нэмэгдэж байгаа нь бодит эдийн засгийн потенциал хүчин чадлыг нэмэгдүүлэхээр байна. Хоёрдугаарт, 2010 онд

Засгийн газраас иргэн бүрт олгож буй 120 мянган төгрөгийн мөнгөн тэтгэмж, оюутны сургалтын төлбөрт олгох 500 мянган төгрөгийн тэтгэмжийн нөлөөгөөр иргэдийн худалдан авах бараа, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлж худалдаа, үйлчилгээний салбарыг өсгөхөөр байна.

Зураг 2.4-д эдийн засгийн өсөлтийн интервал таамаглалыг үзүүлэв. Энэхүү таамаглал нь мөнгөний бодлогын өнөөгийн төлөвийг өөрчлөхгүй буюу бодлогын хүү өөрчлөгдөхгүй, төсвийн бодлого ирэх онуудад харьцангуйгаар хумигдана гэсэн нөхцөл дээр үндэслэн хийгдсэн болно.

Зураг 2.4 ДНБ-ний өсөлтийн интервал таамаглал



2011 онд эдийн засгийн өсөлт өмнөх оны түвшинд байхаар байна. Учир нь 2011 онд уул уурхайн салбар түүнд үйлчилгээ үзүүлдэг бусад салбаруудад шинээр нэмэгдэх хүчин чадлын өсөлт 2010 онтой харьцуулахад харьцангуй бага, үйлдвэрлэлтийн хэмжээ тогтворжих тул эдийн засгийн өсөлтөд оруулах нөлөө өмнөх оноос буурахаар байна. Харин дахин зуд болохгүй тохиолдолд хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэлт сэргэж, эдийн засгийн өсөлтийн тодорхой хувийг бий болгох хэдий ч өсөлт нь зудын өмнөх жилүүдээс бага байна гэж тооцоолж байна. 2012 онд эдийн засгийн өсөлт өмнөх оноос бага зэрэг өснө гэж төсөөлж байна. Үүнд хөдөө аж ахуйн салбарын өсөлт зудгүй жилийн түвшинд хүрэх, Оюу толгой төслийн үйлдвэрлэлт эхлэхийн өмнөх жил тул хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оноос нэмэгдэн, бусад салбаруудын үйлдвэрлэлтийг нэмэгдүүлнэ гэж тооцов.

2.4 Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тодорхой бус байдал

Инфляци, эдийн засгийн өсөлтийн төсөөлөл нь түүнд ашигласан таамаглалууд зөрөх гэнэтийн өөрчлөлт, тооцоонд тусгах боломжгүй хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх эрсдэлтэй юм. Үүнд:

Гадаад эдийн засаг, санхүүгийн нөхцлүүдийн тодорхой бус байдал. 2010 оны эхний хагас жилийн байдлаар Европын холбооны зарим улсыг эс тооцвол ихэнх хөгжингүй болон үсрэнгүй хөгжиж буй орнуудын эдийн засгийн сэргэлт үргэлжилсээр байгаа билээ. Гэхдээ Европын холбооны зарим улсын төсвийн хүндрэл, өрийн асуудал нь аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийг, улмаар дэлхийн эдийн засгийн өсөлтийг сааруулахаар байгаа нь манай худалдааны гол түнш улсуудын экспортод сөргөөр нөлөөлж, улмаар манай гадаад эрэлтийг бууруулах дамжсан нөлөө үзүүлэх боломж бий.

Эдийн засгийн хүчин чадлын өсөлт, түүний салбарын бүтцэд үзүүлэх нөлөөний тодорхой бус байдал: 2010 оноос уул уурхайн томоохон төслүүд шинээр хэрэгжиж, тэдгээрийн зарим нь үйлдвэрлэлтээ эхэлснээр эдийн засгийн хүчин чадал шинээр нэмэгдэн эдийн засгийн өсөлтийг хурдасгаж эхлээд байна. Энэ өсөлт ирэх онуудад улам эрчимжхээс гадна бараа, үйлчилгээ худалдах авах эрэлтийг нэмэгдүүлэн уул уурхайн салбарт үйлчилгээ үзүүлдэг бусад салбаруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх болно. Гэхдээ эдийн засгийн хүчин чадал хэдий хэмжээгээр нэмэгдэх, салбарын бүтэц яаж өөрчлөгдөх нь эдийн засгийн ерөнхий нөхцлүүд тухайлбал дотоод, гадаад үнэ, макро эдийн засгийн бодлого, тэдгээрийн уялдаа, сонгуультай холбоотой улс төрийн шийдвэрүүдээс ихээхэн хамаарах бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийн төсөөллийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж байгаа юм.

Дэд бүтцийн хүчин чадлын тодорхой бус байдал. Уул уурхайн томоохон хөрөнгө оруулалтын нөлөөгөөр хувийн секторын худалдаж авах бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт эрэлт ихээхэн нэмэгдэх боломжтой юм. Эрэлтийн энэхүү өсөлтийг одоогийн дэд бүтэц хангаж чадахгүй тохиолдолд зарим бараа, үйлчилгээний нийлүүлэлтийг хязгаарлах замаар илүүдэл эрэлтийг бий болгох эрсдэл ирэх онуудад өндөр байна.

Төсвийн бодлогын тодорхой бус байдал. Хэдийгээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд ирэх 2 оны төсвийн зардал харьцангуй багаар өсөхөөр тусгагдсан хэдий ч ирэх оны төсвийн төслийг батлахдаа нэмэгдүүлэх эрсдэл өндөр байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн зардал талд тавигдах хязгаарлалтууд 2013 оноос хэрэгжиж эхлэхээс өмнө 2012 оны сонгуультай холбоотойгоор төсвийн тэлэх бодлогыг хэрэгжүүлэх боломжтой байгаа юм.


Банкны салбарын зээлийн эрсдэлийн болон үл хөдлөх хөрөнгийн үнийн огцом өсөлтийн тодорхой бус байдал. Уул уурхайн төслүүдийг даган хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэхтэй холбоотойгоор банкны салбарт зээл олгох эх үүсвэр нэмэгдэснээр банкууд зээлийн нөхцлөө хэт сулруулж, эрсдэл өндөртэй төслүүдийг санхүүжүүлж, улмаар зээлийн өндөр өсөлтийг бий болгон банкны салбарын системийн эрсдэлийг нэмэгдүүлэх нөхцөл үүсч болох юм. Мөн нөгөө талаас эдийн засгийн хүчин чадал нэмэгдэх нь хөдөлмөрийн бүтээмж, улмаар дундаж цалинг өсгөн өрхийн нэрлэсэн орлогыг ирэх онуудад нэмэгдүүлэхээр байна. Хэрэв банкны салбарын зээлийн нөхцөл хэт сулрах тохиолдолд өрхийн орлогын өсөлт дотоодын зах зээл дээр хөрөнгө худалдаж авах эрэлтийг нэмэгдүүлэн улмаар хөрөнгийн үнэ огцом өсгөх нөхцлийг бүрдүүлэх эрсдэлтэй.

3. МӨНГӨНИЙ БОДЛОГО


3.1. Мөнгөний нийлүүлэлт

M2 мөнгөний нийлүүлэлт 2010 оны 8 дугаар сарын байдлаар 3657.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 43 хувиар буюу 1093.4 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 27 хувиар буюу 776.0 тэрбум төгрөгөөр өссөн байна. Үүнийг эх үүсвэр талаас нь авч үзвэл 69 хувь нь бараг мөнгөний өсөлт, 31 хувь нь M1 мөнгөний өсөлт юм. Байршуулалт буюу системийн тэнцлийн актив талаас нь авч үзвэл 68 хувь нь гадаад цэвэр активыг, 32 хувь нь дотоод цэвэр активыг өсгөсөн байна.

Зураг 3.1 Мөнгөний нийлүүлэлт, түүний бүрэлдэхүүн хэсэг




Зураг 3.2. Мөнгөний нийлүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн жилийн өөрчлөлт



Системийн гадаад цэвэр актив Төв банк дахь гадаад валютын цэвэр албан нөөцийн өсөлтөөс хамаарчээ. Гадаад валютын цэвэр албан нөөц 2010 оны 8 дугаар сарын байдлаар 1413 сая ам.долларт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийн түвшнээс 585 сая ам.доллараар, хямралын үед хүрсэн хамгийн бага түвшнээс 909 сая ам.доллараар өндөр үзүүлэлт юм.

Зураг 3.3 Мөнгөний нийлүүлэлтийн актив талын бүтэц



Зээлийн өрийн үлдэгдэл. Дотоод цэвэр активын гол хэсэг болох банкуудын нийт зээлийн үлдэгдэл 2010 оны 8 дугаар сарын байдлаар 3020.6 тэрбум төгрөгт хүрч оны эхнээс 365.6 тэрбум төгрөг буюу 13.8 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 431.7 тэрбум төгрөг буюу 16.7 хувиар өссөн байна.


Гадаад валютын зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн оны мөн үеэс 63.5 сая ам.доллараар, төгрөгийн зээл 383.1 тэрбум төгрөгөөр нэмэгдээд байгаа нь бодит эдийн засаг сэргэж, зээлийн тасалдал арилсаныг харуулж байна. Энэ оны 2 дугаар улирлын байдлаар зээлийн өсөлтийг салбараар авч үзвэл өнгөрсөн мөн үетэй харьцуулахад уул уурхайн салбарт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 85 хувиар, үл хөдлөх хөрөнгө болон түрээсийн бизнесийн салбарт олгосон зээлийн өрийн үлдэгдэл тус бүр 13 хувиар, боловсруулах салбарт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 12 хувиар өссөн байна.

Хүснэгт 3.1 Зээлийн өрийн үлдэгдэл салбараар

	<i>оны эхнээс өөрчлөлт</i>		<i>өмнөх оны мөн үеэс өөрчлөлт</i>	
	хэмжээ	хувь	хэмжээ	хувь
<i>ХАА</i>	-13.7	-8.8	-3.9	-2.7
<i>Барилга</i>	57.1	14.9	49.7	12.7
<i>Уул уурхай</i>	30.6	8.7	174.5	84.7
<i>Боловсруулах</i>	56.5	13.7	49.2	11.7
<i>Худалдаа</i>	49.2	10.3	7.5	1.4
<i>Тээвэр</i>	4.9	7.9	6.1	9.8
<i>Үл хөдлөх хөрөнгө</i>	23.7	12.6	24.8	13.3
<i>Бусад</i>	-14.3	-2.3	-16.5	-2.6
<i>Нийт</i>	194.1	7.3	291.3	11.4


Бараг мөнгө. Хөрөнгийн гадагшлах урсгал, банкны системээс харилцах, хадгаламжаа татсан болон үндэсний мөнгөн тэмдэгтийн хямралтай холбоотойгоор 2008-2009 оны хямралын үед бараг мөнгө 2008 оны сүүлийн хагаст 348.9 тэрбум төгрөгөөр буурч байв. Гэвч эдийн засаг сэргэж, гадаад валютын дотогшлох урсгал ихээхэн нэмэгдсэн нь банкны салбарын харилцах, хадгаламжийг ихээхэн нэмэгдүүлж байна. Бараг мөнгө 2010 оны 8 дугаар сарын байдлаар оны эхнээс 495 тэрбум төгрөг буюу 22 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 757 тэрбум төгрөг буюу 39 хувиар өслөө. Энэхүү жилийн өсөлтийн 69 хувь нь төгрөгийн хадгаламж, 27 хувь нь гадаад валютын харилцахийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Өөрөөр хэлбэл төгрөгийн хадгаламж 525 тэрбум төгрөгөөр буюу 51 хувиар, гадаад валютын харилцах 312 сая ам.доллараар буюу 35 хувиар нэмэгдсэн байна.

Зураг 3.4 Бараг мөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэг



M1 мөнгө. Бодит эдийн засаг сэргэж, мөнгөний эрэлт өсч байгаатай холбоотойгоор M1 мөнгө буюу хөрвөх чадвар өндөртэй төгрөгийн харилцах болон банкнаас гадуур эргэлдэж буй бэлэн мөнгөний хэмжээ нэмэгдэж байна. Тухайлбал, M1 мөнгө 2010 оны 8 дугаар сарын байдлаар өнгөрсөн оны мөн үеэс 56 хувиар өсчээ. Тус өсөлтийн дийлэнх буюу 84 хувь нь төгрөгийн харилцахын өсөлт юм. Харин банкнаас гадуурх мөнгө өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 18 хувиар нэмэгджээ.


Зураг 3.5 M1 мөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэг



Нөөц мөнгө. Нөөц мөнгөний хэмжээ 2010 оны 8 дугаар сарын байдлаар 738.6 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 6.3 хувиар өслөө. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ 2010 оны эхнээс зээлийн болон мөнгөний эрэлт, бодит эдийн засгийн идэвхжил зэрэгтэй холбоотойгоор тогтвортой өсч байна. Тайлант сарын

байдлаар гүйлгээнд байгаа мөнгө өнгөрсөн оны мөн үеэс 22 хувиар өсч 467.5 тэрбум төгрөгт хүрлээ. Төв банк дахь банкуудын төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж банкуудын татан төвлөрүүлсэн эх үүсвэр нэмэгдэж байгаатай холбоотойгоор тасралтгүй нэмэгдсээр байна. Банкны салбарын харилцах, хадгаламж нэмэгдэж байгаатай холбоотойгоор банкуудын төгрөгийн болон валютын заавал байлгах нөөцийн хэмжээ тасралтгүй нэмэгдэж байна. Тухайлбал, 2010 оны 8 дугаар сарын байдлаар төгрөгийн заавал байлгах нөөцийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 32.6 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 22.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэв. Мөн валютын заавал байлгах нөөцийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 3.2 тэрбум төгрөгөөр, оны эхнээс 7.0 тэрбум төгрөгөөр өслөө. Валютын заавал байлгах нөөцөөс төгрөгийн заавал байлгах нөөц илүү хурдтай өсч байгаа нь банкны салбар дахь эх үүсвэрийн өсөлтийн дийлэнх нь төгрөгийн эх үүсвэр байгаатай холбоотой юм.

Зураг 3.6 Нөөц мөнгө, түүний бүрэлдэхүүн хэсэг




Шигтгээ 4. Банкны системийн илүүдэл нөөцийн өнөөгийн байдал

Эдийн засгийн өсөн тэлж буй процессийг дагаад манай орны банкны систем сүүлийн 10 жилийн турш ерөнхийдөө илүүдэл нөөц өндөртэй явж ирсэн бөгөөд энэ байдал 2008-2009 оны хямралын жилүүдэд эрс өөрчлөгдөж банкны системийн бэлэн нөөц огцом буурсан хэдий ч 2009 оны сүүлийн хагасаас эхлэн эрс өссөөр 2010 оны 8 дугаар сарын байдлаар нэлээд өндөр түвшинд хүрээд байна /Зураг 1/.


Энэхүү танилцуулгаар банкны системийн энэхүү бэлэн нөөц хэрхэн яагаад өсөн нэмэгдэх болсон, түүнд ямар хүчин зүйлс нөлөөлж буй хийгээд цаашид ямар төлөв байдал хүлээгдэж байгаад хариулт өгөхийг зорьсон болно. Үүний тулд эхлээд мөнгө банкны системээр дамжин хэрхэн яаж үрждэгийг авч үзэх нь зүйтэй юм.

Зураг 1. Илүүдэл нөөц болон ЗБН



Мөнгө үржих процесс. Онолын хувьд эдийн засагт мөнгө дараах 2 сувгаар үүсдэг гэж үздэг. Нэгдүгээрт, Төв банк эдийн засгийн агентуудаас санхүүгийн хөрөнгө худалдан авч эдийн засагт шууд, шинээр мөнгө нийлүүлэх. Хоёрдугаарт, Төв банкнаас нөөц мөнгийг нэмэгдүүлэх замаар арилжааны банкуудын нөөцийг нэмэгдүүлж, мөнгө үржих процессоор буюу зээл, хадгаламжийн үйл ажиллагаагаар мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх.

Зураг 2. Мөнгө үржих процесс



Мөнгө үржих процессийг дээрх схемд үзүүлсэн энгийн жишээгээр тайлбарлая (Заавал байлгах нөөцийн хувийг 10 хувь гэж үзье). Эхний банк буюу “Банк-1” Төв банкнаас зээл авч, хугацааны t агшинд “Компани-1”-д 100 төгрөгийн зээл олгосон гэж үзэв. “Компани-1” нь банкнаас авсан зээлээ эдийн засгийн эргэлтэнд оруулж, “Компани-2”-т авсан бараа, үйлчилгээ худалдан авсний төлбөр хийв. “Компани-2” үйлчилгээний орлого болох 100 төгрөгийн 20 төгрөг нь эдийн засагт бэлэн мөнгө хэлбэрээр байршсан гэж үзье. Тэгвэл үлдэх 80 төгрөг нь “Компани-2”-ийн харилцагч банк болох “Банк-2”-т харилцах, хадгаламж

хэлбэрээр байршина. “Банк-2” нь шинээр нэмэгдсэн 80 төгрөгийн эх үүсвэрийн 10 хувь буюу 8 төгрөгийг заавал байлгах нөөцөд байршуулж, үлдсэн 72 төгрөгийг зээл хэлбэрээр гаргах боломжтой юм. Иймээс “Банк-2” илүүдэл нөөц болох 72 төгрөгөө “Компани 3”-т зээл болгон олгож, “Компани-3” нь авсан зээлээ “Компани-4”-өөс бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулжээ. Үүний 12 төгрөг нь эдийн засагт бэлэн мөнгө хэлбэрээр байршиж, үлдэх 60 төгрөг нь “Банк-3”-т “Компани-4”-ийн харилцах, хадгаламж хэлбэрээр байршина. “Банк-3” нь 60 төгрөгийн нэмэгдсэн эх үүсвэрийн 10 хувийг ЗБН-д байршуулж, үлдэх 54 төгрөгийг зээлд гаргах боломжтой юм. Энэ процесс цаашид системийн илүүдэл нөөц шавхагдах хүртэл үргэлжилнэ. Доорх зурагт мөнгө үржих процессийг тоон утгаар үзүүлээ.


Хүснэгт 1. Мөнгө үржих процесс, тоон үзүүлэлтээр

Банк	Хадгаламжийн хэмжээ	Зээл олгох боломжтой хэмжээ	ЗБН
1	100.0	90.0	10.0
2	90.0	81.0	9.0
3	81.0	72.9	8.1
4	72.9		
	Мөнгө үржих процессоор үүссэн нийт хадгаламжийн хэмжээ	Мөнгө үржих процессоор үүссэн нийт зээлийн хэмжээ	ЗБН-ийн өсөлт
	271.0	243.9	27.1

Хямралын үеийн мөнгөний нийлүүлэлтийн өөрчлөлт, түүний шалтгаан

2008 оны 7, 8 дугаар сараас манай улсын гадаад валютын дотогшлох урсгал буурч, Төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэн нь улсын гадаад валютын нөөц, Төв банкны гадаад валютын цэвэр албан нөөцийн бууралтаас тод харагдана.


Зураг 3. Мөнгөний үзүүлэлтүүдийн динамик



Эх сурвалж: Монголбанкны сарын статистик мэдээлэл

Энэ нь манай улсын банкны системийн эх үүсвэрийн дийлэнх хувийг эзэлдэг төгрөгийн хадгаламж (2008 оны 10 дугаар сараас), гадаад валютын харилцах, хадгаламж (2008 оны 8 дугаар сараас)-ийг бууруулж, банкны систем бүхэлдээ эх үүсвэрийн хомсдол, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд ороход хүргэсэн. Банкуудын эх үүсвэрийн хомсдол нь зээл олгох боломжийг хязгаарлаж, зээлийн өрийн үлдэгдэл 2008 оны 10 дугаар сараас эхлэн буурч, улмаар M2 мөнгө буурахад нөлөөлсөн. Өөрөөр хэлбэл, 2008 оны 7, 8 дугаар сараас **мөнгө үржих процесс зогсч**, эх үүсвэргүй бол зээл олгохгүй, зээл олгохгүй бол эх үүсвэр /харилцах, хадгаламж/ нэмэгдэхгүй гэсэн спиральд орсон. Энэ үед гүйлгээнд байгаа мөнгө болон M1 мөнгө төдийлөн хүчтэй буураагүй нь иргэдийн банкинд итгэх итгэл суларсан, валютын ханшны хэлбэлзлээс богино хэлцэл /short sell/ хийх замаар ашиг олох боломж нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгж банкин дахь хөрөнгөө бэлэн мөнгө хэлбэрээр байршуулж, банкны системийн эх үүсвэр буурахад нөлөөлснийг илтгэнэ. Дээрх үйл явцыг схемчилэн харуулвал:

Зураг 4. Мөнгөний нийлүүлэлтийн бууралт



Мөнгөний нийлүүлэлт өсөлтийнхөө хамгийн дээд цэгт 2008 оны 7 дугаар сард хүрч, 2009 оны 1 дүгээр сард бууралтынхаа хамгийн бага түвшин буюу 2.2 их наяд төгрөгт хүрэв.

Хүснэгт 2. Мөнгөний нийлүүлэлтийн актив талын бүтэц, түүний өөрчлөлт

БАНКНЫ СИСТЕМИЙН АКТИВ					
	2008-7 сар	2009-1 сар	2010-8 сар	Өөрчлөлт	Өөрчлөлт
	(1)	(2)	(3)	(2-1)	(3-2)
Гадаад цэвэр актив	1,275	611	1,921	-664	1,310
Дотоод цэвэр актив	1,321	1,590	1,736	269	146
ЗГЦЗ	-841	-569	-765	272	-196
Зээлийн өрийн үлдэгдэл	2,594	2,672	3,022	78	350
Бусад цэвэр актив	-431	-513	-521	-82	-8
M2 мөнгө	2,596	2,201	3,657	-394	1,456

2009 оны 1 дүгээр сарын байдлаар банкны системийн гадаад цэвэр активын хэмжээ 2008 оны 7 дугаар сартай харьцуулахад 664.0 тэрбум төгрөгөөр буурсан (Хүснэгт 2). Үүнтэй холбоотойгоор банкуудын төгрөгийн харилцах, хадгаламж 287 тэрбум төгрөгөөр, валютын харилцах, хадгаламж 98 тэрбум төгрөгөөр буурч, банкуудын хөрвөх чадвар өндөртэй бэлэн нөөцийг илэрхийлэх үзүүлэлт¹⁶ 215.7 тэрбум төгрөг (2008 оны 7 дугаар сарын байдлаар)-өөс -96.0 (2008 оны 12 дугаар сарын байдлаар) тэрбум төгрөг болж буурсан нь банкны систем төлбөр түргэн гүйцэтгэх чадварын хүндрэлд орсныг гэрчилнэ (Хүснэгт 3, Зураг 4).

Хүснэгт 3. Мөнгөний нийлүүлэлтийн пассив талын бүтэц, түүний өөрчлөлт

БАНКНЫ СИСТЕМИЙН ПАССИВ					
	2008-7 сар	2009-1 сар	2010-8 сар	Өөрчлөлт	Өөрчлөлт
	(4)	(5)	(6)	(5-4)	(6-5)
Банкнаас гадуурх мөнгө	301	278	355	-23	76
Төгрөгийн харилцах	323	257	577	-66	321
Төгрөгийн хадгаламж	1,096	888	1,554	-208	666
Валютын харилцах, хадгаламж	876	778	1,172	-98	393
M2 мөнгө	2,596	2,201	3,657	-394	1,456

Хямралын дараах үеийн мөнгөний нийлүүлэлт, түүний шалтгаан. Мөнгөний нийлүүлэлт 2010 оны 8 дугаар сарын байдлаар 2009 оны 1 дүгээр сартай харьцуулахад 1456 тэрбум төгрөгөөр буюу 56 хувиар өсөөд байна. Энэхүү өсөлт нь дараах хүчин зүйлсээр тайлбарлагдана.

- Хямралаас хойш гадаадын хөрөнгө оруулагчдын манай эдийн засагт итгэх итгэл нэмэгдсэн, иргэд, аж ахуйн нэгжийн банкны системд итгэх итгэл нэмэгдсэн, манай улсын экспортын голлох барааны үнэ дэлхийн зах зээл дээр өссөн, хямралыг даван туулахад чиглэсэн бодлогыг ОУВС-тай хамтран амжилттай хэрэгжүүлсэн зэрэг нь хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэхэд нөлөөлж, улмаар банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгө, хөрвөх чадвар өндөртэй актив болон мөнгөний нийлүүлэлтийн агрегатуудыг нэмэгдүүллээ. Тухайлбал, 2010 оны 8 дугаар сарын байдлаар банкны системийн гадаад цэвэр актив 2009 оны 1 дүгээр сартай харьцуулахад 1310 тэрбум төгрөгөөр буюу 2 дахин өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийн дийлэнх хувийг тайлбарлаж байна.
- Монголбанк эдийн засгийн хямралын хүнд үед бодит секторыг дэмжих, зээлийн тасалдлыг арилгах, банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах, хүндрэлд орсон

¹⁶ Банкуудын Төв банкин дахь төгрөгийн болон валютын харилцах, хадгаламж + ТБҮЦ-Төв банкнаас авсан банкуудын зээл.

банкуудын харилцах, хадгаламжийг тавьж олгох¹⁷ зорилгоор банкуудад 2861 тэрбум төгрөгийн зээл олгосон байна. Хэдийгээр энэхүү зээлийн 2715 тэрбум төгрөг нь эргэн төлөгдсөн ч мөнгөний үржих процессоор мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөнд нөлөөлсөн.


- Монголбанк 2008 оны 12 дугаар сараас хойш Засгийн газраас гаргасан 233 тэрбум төгрөгийн бондыг худалдан авсан бөгөөд үүний 55 тэрбум төгрөгийн бонд Монголбанкинд эргэн төлөгдөж, 115 төгрөгийн бондыг дотоодын банкуудад дамжуулан арилжаалсан. Одоогийн байдлаар Монголбанк 4000 айлын орон сууцны хөтөлбөрийн 30 тэрбум төгрөгийн, Зоос банкны харилцагчдын мөнгөн хадгаламжийг тавьж олгох зорилгоор гаргасан 33 тэрбум төгрөгийн Засгийн газрын бондыг эзэмшиж байна.
- Дээрх хүчин зүйлүүдийн нөлөөгөөр банкны системийн эх үүсвэр болох иргэд аж ахуйн нэгжийн харилцах, хадгаламж ихээхэн нэмэгдээд байна. Тухайлбал, төгрөгийн харилцах, хадгаламж 987 тэрбум төгрөгөөр, валютын харилцах, хадгаламж 393 тэрбум төгрөгөөр, банкуудын хөрвөх чадвар өндөртэй актив 2009 оны 1 дүгээр сараас хойш 810.6 тэрбум төгрөгөөр өслөө (Хүснэгт 2, Зураг 5).
- 2010 оны 8 дугаар сарын байдлаар банкны системийн зээлийн өрийн үлдэгдэл 2009 оны 1 дүгээр сартай харьцуулахад 350 тэрбум төгрөгөөр нэмэгдээд байна. (Хүснэгт 2).

Хүснэгт 4. Банкны системийн тэнцлийн өөрчлөлт	
Банкны системийн тэнцэл /2008.8 сар-2009.1 сар/	
Актив	Пассив
↓ Гадаад валютын цэвэр нөөц	↓ Төгрөгийн хадгаламж
↓ Зээлийн өрийн үлдэгдэл	↓ Гадаад валютын харилцах, хадгаламж
↓ Хөрвөх чадвар өндөртэй актив	
↓ Мөнгөний нийлүүлэлт	
Банкны системийн тэнцэл /2009.2 сар-2010.8 сар/	
Актив	Пассив
↑ Гадаад валютын цэвэр нөөц	↑ Төгрөгийн хадгаламж
↑ Зээлийн өрийн үлдэгдэл	↑ Гадаад валютын харилцах, хадгаламж
↓ Хөрвөх чадвар өндөртэй актив	
↑ Мөнгөний нийлүүлэлт	

¹⁷ Зоос банкинд олгосон зээл нь Засгийн газрын бондоор солигдсон тул хасч тооцов.

БАНКНЫ СИСТЕМИЙН НӨӨЦИЙН ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНИЙ ШАЛТГААН

Банкны системийн эх үүсвэр ийнхүү нэмэгдсэн нь банкуудын зээл олгох чадавхи болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлсэн. Банкуудын хөрвөх чадвар өндөртэй актив 2010 оны 9 дүгээр сарын 23-ны байдлаар 857.7 тэрбум төгрөгт хүрээд байна.



2009 оны 1 дүгээр сараас 2010 оны 8 дугаар сарын хооронд банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар хэрхэн сайжирч, банкуудын хөрвөх чадвар өндөртэй активын хэмжээ хэрхэн нэмэгдсэнийг доорх хүснэгтээс харж болно. Монгол улсын Засгийн газар болон Монголбанкнаас ОУВС-тай хамтран хямралын эсрэг бодлогыг боловсруулан амжилттай хэрэгжүүлснээр хөрөнгийн дотогшлох урсгал нэмэгдэж, Монгол улсын гадаад валютын цэвэр албан нөөц буюу Төв банкны гадаад цэвэр активын хэмжээ 1136.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар сайжирч, ТБҮЦ нэмэгдэхэд гол нөлөө үзүүлээ. Уг хугацаанд банкны системээс 265.4 тэрбум төгрөг цэвэр дүнгээрээ Засгийн газрын харилцах дансанд төвлөрсөн буюу ЗГЦЗ 265.4 тэрбум төгрөгөөр буурсан, эдийн засгийн идэвхжилтэй холбоотойгоор гүйлгээнд байгаа мөнгөний эрэлт нэмэгдэж, гүйлгээнд байгаа мөнгөний хэмжээ 120.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь ГЦА-ын өсөлтийн улмаас бий болсон хөрвөх чадвар өндөртэй активын өсөлтийг саармагжуулсан байна. Үүний үр дүнд 766.7 тэрбум төгрөгийн нөөц Төв банкны бодлогын хэрэгслээс бусад хүчин зүйлсээр банкны системд нийлүүлэгдсэн. Энэхүү нөөцийн өсөлтийн үр дүнд Төв банкин дахь банкуудын төгрөг болон гадаад валютын харилцах дансны үлдэгдэл 92.5 тэрбум төгрөгөөр, банкуудын эзэмшиж буй ТБҮЦ 589.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, Төв банкнаас хямралын үед банкуудад олгосон байнгын болон байнгын бус санхүүжилтийн үлдэгдэл 84.4 тэрбум төгрөгөөр буураад байна.

Хүснэгт 5. Банкны системийн нөөцийн өөрчлөлт /хүчин зүйлээр/

2009.1.31-2010.8.31			
	Нийлүүлсэн (Н)	Татсан (Т)	Цэвэр дүн (Н-Т)

Төв банкны бодлогын хэрэгсэл

Байнгын санхүүжилт	1,387.7	1,393.1	-5.4
Байнгын бус санхүүжилт	92.4	171.4	-79.0
ТБҮЦ		589.8	-589.8
Дүн (а)	1,331.0	2,005.2	-674.2


Төв банкнаас үл хамаарах хүчин зүйлс

Гадаад цэвэр активын өөрчлөлтөөр	1,136.7	1,136.7
ЗГЦЗ-ийн өөрчлөлтөөр	265.4	-265.4
Бусад дотоод цэвэр активын өөрчлөлтөөр	16.3	16.3
Гүйлгээнд байгаа мөнгөний өөрчлөлтөөр	120.9	-120.9
Дүн (b)	1,153.0	386.3
		766.7

Банкуудын нөөц

ЗБН (с)	41.5
Төгрөгийн	37.0
Гадаад валютын	4.6
Илүүдэл нөөц (d)	51.0
Төгрөгийн	-8.9
Гадаад валютын	59.8
Дүн (а)+(б) буюу (с)+(d)	92.5

Зураг 6. Төв банкны тэнцэл




Банкны системийн нөөцөд нөлөөлөх хүчин зүйл

Энэ хэсэгт банкны системийн илүүдэл нөөц түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар тоймлон авч үзэв. Банкны системийн илүүдэл нөөц дараах 4 сувгийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтой юм. Үүнд:

1. Суваг-1: Төлбөрийн тэнцлийн алдагдлын банкны системийн бэлэн нөөцөд үзүүлэх нөлөө.
2. Суваг-2: Төсвийн хумих бодлогын нөлөө.
3. Суваг-3: Хүүгийн түвшний бууралтын нөлөө.
4. Суваг-4: Заавал байлгах нөөцийн хувь хэмжээний нөлөө.

Суваг-1: Төлбөрийн тэнцлийн алдагдлын нөлөө

Зураг 7. Төлбөрийн тэнцлийн алдагдлын банкны системийн хөрвөх чадвартай активт үзүүлэх нөлөө




- a) Эдийн засаг, дотоод эрэлтийн идэвхжил, мөчлөг дагасан макро эдийн засгийн бодлоготой холбоотойгоор урсгал тэнцлийн алдагдал удаан үргэжлэх нь хөрөнгийн тэнцлийн алдагдлыг дагуулдаг. Учир нь валютын ханшийн дэглэм хөвөгч биш үед урсгал тэнцлийн алдагдал удаан үргэлжлэн, түүний хэмжээ хөрөнгийн дотогшлох урсгалаас давснаар төлбөрийн тэнцлийн ашгийг бууруулах эсвэл алдагдалтай гарахад хүргэнэ.

- b) Төлбөрийн тэнцэл алдагдалтай гарах нь банкны гадаад валютын нөөцийг бууруулна. Учир нь урсгал тэнцлийн алдагдал нь хөрөнгийн орох урсгалаас их үед өмнө хуримтлагдсан гадаад валютын нөөцөөр төлбөрийн тэнцлийн алдагдал хаагдана.
- c) Төлбөрийн тэнцлийн алдагдлыг санхүүжүүлж буй гадаад нөөцийн бууралт нь банкны системийн тэнцлийн актив талд гадаад цэвэр актив (ГЦА)-ын бууралт, эх үүсвэр талд гадаад валютын харилцах, хадгаламжийн бууралт хэлбэрээр харагдана. Төлбөрийн тэнцлийн алдагдал үргэлжлэх нь банкуудын гадаад нөөцийг бууруулаад зогсохгүй Төв банкинд гадаад валютын харилцах, хадгаламж хэлбэрээр байршуулсан нөөцийг бууруулна.
- d) Төв банкин дахь энэхүү нөөцийн бууралт нь Төв банкнаас тогтоосон ЗБН-ийн түвшин хүртэл үргэлжлэх бөгөөд энэ хязгаарт хүрсэн үед банк хоорондын зах дээрх гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлнэ.
- e) Хэрэв Төв банк өнгөрсөн хугацаанд ханшийг тогтвортой түвшинд барих бодлого баримталж байсан бол ханшийн багахан хэмжээний хэлбэлзэлд эдийн засгийн агентууд хэт мэтрэмтгий хандах тул Төв банк ханш сулрахаас болгоомжилж /Fear of free floating-ийн хавх/, валютын захад интервенц хийнэ.
- f) Эцэст нь Төв банкны валютын захад хийж буй интервенц нь гадаад валютын нийлүүлэлт, үндэсний мөнгөн тэмдэгт /төгрөг/-ийн нөөцийг бууруулна.

Суваг-2: Төсвийн хумих бодлогын нөлөө.

Зураг 8. Төсвийн хумих бодлогын банкны системийн хөрвөх чадвартай активт үзүүлэх нөлөө



- a) Төсвийн хумих бодлого гэдэгт төсвийн алдагдал буурах буюу төсвийн зардлын өсөлт нь орлогын өсөлтөөсөө бага байх хэлбэрээр хэрэгжихийг ойлгоно. Төсвийн орлогын өөрчлөлт нь зардлын өөрчлөлтөөсөө их байх нь банкны системийн ЗГЦЗ-ийг бууруулна. Энэ нь Төв банк болон банкуудын тэнцэлд дараах байдлаар өөрчлөлт оруулна.

Хүснэгт 6. Төвбанкны болон банкны системийн тэнцлийн өөрчлөлт


Банкны тэнцэл		Төв банкны тэнцэл	
Актив	Пассив	Актив	Пассив
Гадаад валютын цэвэр актив	↓ Харилцах, хадгаламж	Гадаад цэвэр актив	↓ Банкуудын харилцах, хадгаламж
↓ Дотоод цэвэр актив		↓ Дотоод цэвэр актив	
↻		↑ Засгийн газрын харилцах	
↓ Төв банкин дахь нөөц			
↓ Мөнгөний нийлүүлэлт		↓ Мөнгөний нийлүүлэлт	

Банкуудын эх үүсвэр талд харилцах хадгаламж буурч, актив талд Төв банкин дахь нөөц буурна. Төв банкны тэнцлийн хувьд банкуудын харилцах, хадгаламж буурч, Засгийн газрын харилцах данс зузаарна.

- б) Банкуудын төв банкин дахь харилцахын хэмжээ буурах нь системийн илүүдэл нөөцийг богино хугацаанд бууруулна (дараагийн ТБҮЦ-ны арилжаа хүртэл). Банкууд ЗБН-өө хангах, харилцагчийн гүйлгээнд шаардагдах илүүдэл нөөцийн эрэлтээ хангахын тулд ТБҮЦ-ны дараагийн арилжаагаар эзэмшиж буй ТБҮЦ-ны хэмжээгээ бууруулна.

Суваг-3: Хүүгийн түвшний бууралтын нөлөө.

Зураг 9. Хүүгийн түвшний бууралтын банкны системийн бэлэн нөөцөд үзүүлэх нөлөө



- а) Төв банкны бодлогын хүүний бууралт дотоодын санхүүгийн активын өгөөжийг бууруулна. Дотоодын санхүүгийн активын эрсдэлгүй хүүний түвшин (r_{free}^d – *country risk premium*) буурч гадаад захын эрсдэлгүй хүүний түвшинтэй ойролцоо


буюу бага түвшинд хүрсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгө оруулалтын орох урсгал буурах эсвэл гарах урсгал нэмэгдэнэ.

- б) Хөрөнгийн дотогшлох урсгал буурах эсвэл гадагшлах урсгал нэмэгдэх нь банкны системийн гадаад нөөцийг бууруулна. Энэ сувгийн (с)-(f) нөлөөлөх механизм нь Суваг-1-ийн (с)-(f)-тэй адил байх болно.

Суваг-4: Заавал байлгах хувийг нэмэгдүүлэх.

Олон улсын туршлагаас харахад хүүгийн түвшинг бууруулах болон заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг өсгөх гэсэн арга хэмжээг хэргэжүүлснээр банкны системийн хөрвөх чадвар өндөртэй актив (илүүдэл нөөц)-ийг бууруулдаг байна. Заавал байлгах нөөцийн хувь хэмжээг өсгөх нь банкны илүүдэл нөөцийг шууд бууруулж, зээл олгох боломжийг багасгаж, улмаар мөнгө үржих процессийг удаашруулснаар банкны системийн хөрвөх чадвар өндөртэй активийг бууруулна (Зураг 10). Банкны алдагдсан боломжийн зардал буюу ЗБН-ийн хувь нэмэгдэх нь зээлийн хүү өсөхөд нөлөөлж, мөнгө үржих процессийг сааруулснаар хөрвөх чадвартай активийг бууруулдаг.

Зураг 10. Ялгаатай ЗБН-ийн хувьд мөнгө үржих процесс



Дүгнэлт

Гадаадын хөрөнгө оруулагчид болон иргэд аж, ахуй нэгжийн эдийн засаг, банкны системд итгэх итгэл нэмэгдсэн, экспортын голлох барааны дэлхийн зах зээл дээрх үнэ өссөн, хямралын эсрэг Засгийн газар, Монголбанкнаас ОУВС-тай хамтран хэрэгжүүлсэн хөтөлбөр

амжилттай хэрэгжсэн, уул уурхайн олборлох салбарын үйлдвэрлэл эрчимжиж байгаа зэрэг хүчин зүйлсийн нөлөөгөөр дотоодын эдийн засаг руу орох хөрөнгийн урсгал тасралтгүй нэмэгдэж байгаа нь банкны системийн илүүдэл нөөц ихээхэн өсөж байгаагийн үндсэн шалтгаан болж байна. Банкуудын илүүдэл нөөцийг бууруулах дээр дурьдсан 4 сувгийн хувьд:

- Ирэх онуудад уул уурхайн томоохон ордуудын ашиглалттай холбоотойгоор хөрөнгийн орох урсгал их хэмжээгээр нэмэгдэж, урсгал тэнцэл ашигтай байх нөхцлийг бүрдүүлэхээр байгаа нь урсгал тэнцлийн сувгаар дамжин илүүдэл нөөц буурах боломж бүрдэхгүй гэдэг нь харагдаж байна.
- Засгийн газраас иргэдэд бэлэн мөнгө үргэлжлүүлэн олгох, сонгуулийн амлалтаа хэрэгжүүлж байгаа зэргээс харахад ойрын жилүүдэд төсвийн тэлэх бодлого үргэлжлэн хэрэгжихээр байгаа тул төсвийн бодлогын суваг илүүдэл нөөцийг бууруулахааргүй байна.
- Харин хүүний түвшингийн бууралт нь үр дүнгээ өгч болохуйц суваг хэдий ч ирэх онуудад иргэдэд бэлэн мөнгө үргэлжлүүлэн тараах, мах болон хүнсний гол бараа, төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээ, бусад импортын бүтээгдэхүүний үнэ өсөх, сонгуультай холбоотойгоор төсвийн үрэлгэн зардал нэмэгдэх зэргээс шатлгаалан инфляци өсөх эрсдэлтэй байгаа нь хүүгийн түвшиний бууралтыг хязгаарлахаар байна.
- Төвбанкнаас заавал байлгах нөөцийн хувь, хэмжээг өсгөн инфляцийг хязгаарлахын зэрэгцээ банкны системийн илүүдэл нөөцийг бууруулах боломжтой ч энэ нь банкуудын зээл олгох боломжийг багасгаж, улмаар мөнгө үржих процессийг удаашруулах эдийн засгийн өсөлтийг бууруулах сөрөг нөлөөтэй юм.

3.2. Зээлийн хүү


Энэ оны 8 сарын байдлаар банкуудын төгрөгийн зээлийн жилийн дундаж хүү 20.5 хувь, валютын зээлийн жилийн дундаж жилийн 14.7 хувь байлаа.

Хүснэгт 3.2 Зээлийн жилийн дундаж нэрлэсэн хүү

	2007	2008	2009	2010.VIII
Төгрөгийн зээлийн хүү	21.83	20.58	21.67	20.49
Валютын зээлийн хүү	14.22	15.40	17.06	14.70


Төгрөгийн зээлийн хүү 2005 оноос 2007 оны эцэс хүртэл ерөнхийдөө буурах төлөвтэй байсан ч инфляцийг даган өсч 21 орчим хувь болсон байв. Валютын зээлийн нэрлэсэн хүү нэлээд тогтвортой 14-16 орчим хувьд багагүй хугацаанд байсан ч 2008 оноос эхлэн өсөх хандлагатай болсон. 2008 оны 9 дүгээр сараас эхлэн инфляци буурч, 2009 оны 9 дүгээр сарын байдлаар жилийн -1.9 хувьд хүрсэн хэдий ч төгрөг, валютын зээлийн хүү буураагүй нь банкны системийн алдагдалтай холбоотой юм. Жилийн инфляцийн өөрчлөлтийг төгрөг болон валютын зээлийн хүүтэй харьцуулан Зураг 3.7-д харуулав.

Зураг 3.7 Зээлийн хүү болон инфляци



Нэрлэсэн хүүний түвшингээс инфляцийг хасч тооцдог бодит хүү төгрөгийн зээлийн хүүний хувьд нэлээд хугацааны турш сөрөг утгатай байв. Ялангуяа, 2008 оны 2 дугаар хагасаас эхлэн 2009 оны эхний улирал хүртэл инфляци хэт хурдацтай өсч байснаас шалтгаалан зээлийн бодит хүүний түвшин сөрөг утгатай байв.

Зураг 3.8 Төгрөгийн зээлийн хүү




Харин 2009 он гарсаар инфляци хурдацтай буурч, сөрөг утгатай болсноор энэхүү байдал өөрчлөгдөж, төгрөгийн зээлийн бодит хүү өсч 2009 оны 8 сарын байдлаар 24.6 хувьд хүрч байснаа 2009 оны 9 дүгээр сараас бодит хүү буурсаар 2010 оны 8 дугаар сарын байдлаар 9.2 хувь болсон байна. Монголбанкнаас хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах зорилгоор дунд хугацаанд зээлийн хүүг бууруулах ажлыг шат дараатай авч хэрэгжүүлж эхлэх гэж байна. Үүний дүнд зээлийн нэрлэсэн хүү буурч инфляци тогтвортой түвшиндээ хадгалагдах тохиолдолд бодит хүү буурч, зээлдэгчдийн хувьд таатай нөхцөл байдал үүсэх боломжтой.

3.3. Мөнгөний зах

Мөнгөний бодлогын арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлсний дүнд банк хоорондын мөнгөний захын үйл ажиллагаа сэргэж, илүүдэл нөөцийн хэмжээ ихэссэнээр зээлийн тасалдал арилсан. Тухайлбал, 2009 оны 6 дугаар сараас эхлэн илүүдэл нөөц эргэн өсч 2010 оны 4 дүгээр сард 118.3 тэрбум төгрөг болж, сүүлийн 3 жилийн хамгийн өндөр түвшинд хүрсэн. Харин, 2010 оны 5 дугаар сард Монголбанк бодлогын хүүг нэмэгдүүлсний дүнд илүүдэл нөөц буурч 8 дугаар сарын байдлаар 48.2 тэрбум төгрөг болсон байна.


Зураг 3.9 Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ /сарын дундаж, тэрбум төгрөгөөр /



Банкуудын илүүдэл нөөцөөс төв банкны санхүүжилтийг хасч, банкуудын худалдан авсан Төв банкны үнэт цаасны хэмжээг нэмж мөнгөний зах дээрх бэлэн нөөцийн хэмжээг тооцдог. Зураг 3.10-аас үзвэл банкуудын бэлэн нөөцийн хэмжээ 2009 оны 3 дугаар сараас эхлэн нэмэгдсээр 2010 оны 8 дугаар сарын байдлаар 644.2 тэрбум төгрөгт хүрсэн нь сүүлийн үед банкуудын илүүдэл нөөц буурсан мэт харагдаж байгаа боловч энэ нь банкуудын худалдаж авсан Төв банкны үнэт цаасны хэмжээ өссөнтэй холбоотой юм. Манай санхүүгийн зах зээл


хөгжөөгүй учир банк өөрийн илүүдэл хөрөнгийг зээл болгон гаргах, валют болгож хадгалах, ТБҮЦ-нд байршуулахаас өөр аргагүй байна.

Зураг 3.10 Банкуудын илүүдэл нөөцийн хэмжээ /сарын дундаж, тэрбум төгрөгөөр/




Банк хоорондын захын арилжааны хэмжээ. Банкуудын илүүдэл нөөцийн буурах тусам банк хоорондын захын арилжааны тоо өсдөг. 2009 оны сүүлийн саруудад банкууд хоорондоо хадгаламж байршуулах сонирхол өндөр байсан бол 2010 онд илүүдэл нөөц нэмэгдэж, банк хоорондын захын идэвх суларсан бөгөөд банкууд ТБҮЦ-ны арилжаа хийх сонирхол өссөн. Тухайлбал, 2010 оны 8 дугаар сарын байдлаар нийт арилжааны 62.3 хувийг ТБҮЦ-ны хоёрдогч захын арилжаа эзэлж байна. Харин нийт арилжааны хэмжээ оны эхнээс 23.3 хувиар буурч 61.8 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 21.5 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд банк хоорондын захын арилжааны хэмжээ болон бүтэц ийнхүү өөрчлөгдсөн нь сүүлийн саруудад мөнгөний зах дээр байгаа их хэмжээний илүүдэл нөөцийг банкууд ТБҮЦ-нд байршуулсантай холбоотой юм.

Зураг 3.11 Банк хоорондын захын арилжааны хэмжээ /тэрбум төгрөгөөр/



Банк хоорондын захын арилжааны хүү. Монголбанк бодлогын хүүгээр дамжуулан банк хоорондын захын хүүг удирдах замаар банкуудын зээл, хадгаламжийн хүүнд нөлөөлөх зорилт тавьдаг. 2009 оны 3 дугаар улиралд Монголбанк 11.5 хувь байсан бодлогын хүүг гадаад валютын дотоодын захын тогтворжилттой уялдуулан 1.50 нэгж хувиар бууруулан 10.0 хувь болгосон бөгөөд үүнийг даган банк хоорондын захын хүү буурав. 2010 оны 5 дугаар сард Монголбанк бодлогын хүүгээ 1.0 нэгж хувиар нэмэгдүүлж 11.0 хувьд хүргэсний дүнд банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2010 оны 6, 7, 8 дугаар саруудад 10.42, 10.71, 8.82 хувьд хүрлээ.


Зураг 3.12 Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү /хувиар/




Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2010 оны 8 дугаар сард 8.82 хувь болж оны эхнээс 2.38 нэгж хувиар буурсан байна. Төв банкны санхүүжилтийн хэрэгслүүдийн хүү бодлогын хүүний өсөлт, бууралтыг даган өөрчлөгддөг тул 2010 оны эхний хагас жилийн эцэст репо санхүүжилтийн хүү 15.0 хувь, барьцаат зээлийн хүү 19.0 хувь, овернайт зээлийн хүү 20.0 хувь болж буурлаа. Харин банк хоорондын захын хүүнүүд 2010 оны 8 дугаар сарын байдлаар зээл болон хадгаламжийн хүү харгалзан 11.00 болон 12.00 хувь, репо санхүүжилтийн хүү 6.00 хувь, банк хоорондын овернайт зээлийн хүү 9.47 хувь болж мөн адил буураад байна.

Банк хоорондын захын хүүний зөрүү. Банк хоорондын захын арилжааны хамгийн өндөр болон нам хүүний зөрүү эрсдэлийн түвшинг илэрхийлнэ. Банкуудын илүүдэл нөөцийн хомсдолтой үе буюу 2008 оны эцсээр банк хоорондын зах дээр хийгдсэн арилжааны хамгийн өндөр хүү 23.0 хувьд, хүүний зөрүү 12.0 нэгж хувьд хүрээд байсан. Энэ байдал үргэлжилсээр 2009 оны 4 дүгээр сард хамгийн өндөр хүү 30.0 хувьд хүрч, хүүний зөрүү 20.75 нэгж хувь болсон байна. Хүүний зөрүү 2009 оны 8 дугаар сараас эхлэн буурсаар 2010 оны 8 дугаар сарын байдлаар 6.0 нэгж хувь болсон нь банк хоорондын мөнгөний зах дээрх сегментчлэл багасч, итгэлцэл нэмэгдэж байгааг илтгэж байна.

Зураг 3.13 Банк хоорондын захын хүүний зөрүү /сараар/



Зураг 3.14 Банк хоорондын захын хамгийн бага, хамгийн өндөр хүү /сараар/



3.4. Монгол Улсын төлбөрийн тэнцлийн тойм /2010 оны эхний хагас жилээр/

Монгол Улсын төлбөрийн тэнцэл 2010 оны эхний хагас жилд **126.1** сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс **17.6** хувиар сайжирлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант хугацаанд урсгал тэнцлийн алдагдал 2.9 хувиар өсч, 156.9 сая ам.долларт хүрэв. Үүнд: (i) гадаад худалдааны алдагдал 86.9 хувиар буурч, (ii) орлогын дансны алдагдал 113.4 хувиар, (iii) урсгал шилжүүлэг 11.4 хувиар тус тус өссөн өөрчлөлтүүд орж байна. Хөрөнгө, санхүүгийн тэнцэл 490.4 сая ам.долларын ашигтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 269.6 хувиар өссөний дотор гадаадын шууд хөрөнгө оруулалт 5.3 дахин нэмэгдэн 598.3 сая ам.долларт хүрсэн байна.


Урсгал данс

Төлбөрийн тэнцлийн урсгал данс 2010 оны эхний хагас жилийн байдлаар 156.9 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буюу 4.4 сая ам.доллараар өсчээ. Урсгал дансны алдагдал 2009 оны эхний хагас жилийн байдлаар ДНБ-ий 8.6 хувьтай тэнцэж байсан бол 2010 оны 2 дугаар улирлын байдлаар 6.7 хувь байна. Бараа


үйлчилгээний дансны алдагдал 2010 оны эхний хагас жилийн байдлаар өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27.3 хувиар буурч 129.2 сая ам.долларт, цэвэр орлогын дансны алдагдал 113.4 хувиар өсч 116.9 сая ам.долларт, урсгал шилжүүлгийн дансны ашиг 32.1 хувиар өсч 88.8 сая ам.долларт тус тус хүрчээ.

Үзүүлэлт	Эхний хагас жил		Өөрчлөлт	
	2009	2010	Мөнгөн дүн	Хувь
I. Урсгал Тэнцэл	-152,6	-156,9	-4,4	3%
А. Бараа ба үйлчилгээний худалдаа	-177,7	-129,2	48,4	-27%
а. Бараа (1-2)	-94,1	-12,3	81,8	-87%
1. Экспорт Ф.О.Б.	762,9	1308,7	545,8	72%
2. Импорт Ф.О.Б.	-857,1	-1321,0	-464,0	54%
б. Үйлчилгээ	-83,5	-116,9	-33,4	40%
1. орлого	168,0	190,2	22,2	13%
2. зарлага	-251,5	-307,1	-55,6	22%
Б. Цэвэр орлого	-54,6	-116,5	-61,9	113%
В. Урсгал шилжүүлэг	79,7	88,8	25,6	32%
а. Ажилчдын гуйвуулга	45,2	48,2	3,0	7%
1. Хүлээн авсан	71,7	103,5	31,8	44%
2. Шилжүүлсэн	-26,5	-55,3	-28,8	109%
б. Бусад шилжүүлэг	34,5	40,6	6,1	18%

Зураг 3.15 Урсгал дансны бүтэц



Зураг 3.16 Үйлчилгээний худалдаа (улирлаар)



Тайлант хугацаанд гадаад худалдааны нийт бараа эргэлт 2664.9 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 61.0 хувь буюу 1009.2 сая ам.доллараар өссөн. 2010 оны эхний хагас жилийн байдлаар экспорт 1308.7 сая ам.долларт, импорт 1356.2 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 71.5, 51.9 хувиар тус тус өссөн үзүүлэлт юм. Тайлант хугацаанд гадаад худалдааны алдагдал буурахад экспортын өсөлт импортын өсөлтөөс 20 нэгж хувиар илүү байсан нь голлон нөлөөлжээ.

2010 оны эхний хагас жилийн байдлаар үйлчилгээний худалдааны дансны орлого 190.2 сая, зарлага 307.1 сая, цэвэр дүнгээр 116.9 сая ам.долларын алдагдалтай гарав. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40.0 хувиар буюу 33.4 сая ам.доллараар өссөн дүн

юм. Үйлчилгээний дансны орлогын 37.9 хувийг тээврийн салбар, 48.8 хувийг аялал жуулчлалын салбар тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 3.4 Аялал жуулчлалын салбар

Үзүүлэлт	Эхний хагас жил		Өөрчлөлт	
	2009	2010	дүн	Хувь
Жуулчлалын салбарын нийт орлого (сая ам.доллараар)	64,0	77,1	13,1	20%
Гадаадын жуулчдын тоо	96 290	115 581	19 291,0	20%
Жуулчлалын салбарын нийт зардал (сая ам.доллараар)	62,7	79,7	17,0	27%
Гадаадад жуулчилсан Монгол иргэдийн тоо	113 708	144 351	30 642,6	27%
Жуулчлалын цэвэр орлого (сая ам.доллараар)	1,21	(2,64)	(3,86)	-317%


мөн үетэй харьцуулахад 44.4 хувиар нэмэгджээ.

Цэвэр урсгал шилжүүлгийн хэмжээ 2010 оны эхний хагас жилийн байдлаар 88.8 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 11.4 хувь буюу 9.1 сая ам.доллараар өсчээ.

Хөрөнгө, санхүүгийн данс

Шууд хөрөнгө оруулалтын данс нь 2010 оны эхний хагас жилийн байдлаар 598.3 сая ам.долларын ашигтай гарсан нь олборлох үйлдвэрлэлт оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалт 2010 оны 2 дугаар улиралд 388.9 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 дахин буюу 281.2 сая ам.доллараар өссөнтэй холбоотой байна. Санхүүгийн хөрөнгө оруулалтын данс нь 157.2 сая ам.долларын алдагдалтай гарсан нь Засгийн газрын бондыг Стандарт банкнаас эргүүлэн худалдан авсан, ХХБ-аас 2007 онд гаргасан бондын эцсийн үлдэгдлийг эргүүлэн худалдан авснаас шалтгаалжээ.

Зураг 3.17 Санхүүгийн тэнцэл




Монгол улсын Засгийн газрын шугамаар болон түүний баталгаатайгаар хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагаас тайлант улиралд шинээр 14.7 сая ам.доллартай тэнцэх гадаад зээлийг авч, үндсэн өрийн төлбөрт 19.5 сая ам.доллар төллөө. Худалдааны зээл цэвэр дүнгээр 15.9 сая ам.долларын эерэг урсгалтай гарсан нь аж

ахуйн нэгж, байгууллагууд нь тайлант хугацаанд эдийн засгийн харъят бус (импортлогч)-аас экспортын бараа бүтээгдэхүүний урьдчилгаа төлбөр авч, улмаар өглөгийн дүн нэмэгдсэнтэй холбоотой.


Монгол улсын эдийн засгийн харьяат аж ахуйн нэгж байгууллага, банкууд нь харьяат бусаас 100.2 сая ам.долларын урт, богино хугацааны зээл авч ашиглан, 39.7 сая ам.долларын эргэн төлөлтийг гүйцэтгэснээр цэвэр дүнгээр 60.5 сая ам.долларын орох урсгал давлаа.

Зураг 3.19 ГШХО, улс орнуудаар



Эх сурвалжууд: Монголбанк

Зураг 3.18 ГШХО, салбараар



Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг улсаар ангилавал: Хонг Конг нийт хөрөнгө оруулалтын 23 хувь, Канад 20 хувь, Их Британи 16 хувь, ОХУ 12 хувь, БНХАУ 8 хувийг тус тус эзэлж байна. Харин салбарын ангилалаар авч үзвэл геологи хайгуул, уул уурхай, газрын тосны салбарт хамгийн их буюу нийт хөрөнгө оруулалтын 64 хувь, барилгын салбарт 8 хувь, банк санхүүгийн салбарт 5 хувь, үл хөдлөх хөрөнгөд 3 хувь, үлдэх 20 хувь нь бусад салбарт ногдож байна.

Хүснэгт 3.5 Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл

Үзүүлэлт	Эхний хагас байдлаар				Өмнөх улирлын гүйцэтгэл				
	Дүн		Өөрчлөлт		Q1 09	Q2 09	Q3 09	Q4 09	Q1 10
	2009	2010	Дүн	Хувь					
I. Урсгал Тэнцэл	-152,6	-156,9	-4,4	3%	-91,6	-60,9	-65,4	-123,8	-128,8
A. Бараа ба үйлчилгээний худалдаа	-177,7	-129,2	48,4	-27%	-96,6	-81,1	-71,7	-82,7	-126,6
1. Бараа	-94,1	-12,3	81,8	-87%	-49,8	-44,4	-81,1	-13,5	-65,7
1.1 Ерөнхий эд бараа	-258,7	-103,2	155,5	-60%	-175,9	-82,7	-123,8	-89,3	-83,4
Экспорт Ф.О.Б. (Кредит)	591,7	1 200,5	608,8	103%	194,7	397,0	444,3	536,4	470,0
Үүнээс: Зэсийн баяжмал	190,0	383,7	193,7	102%	81,5	108,5	132,2	179,6	182,7
Импорт Ф.О.Б. (Дебит)	-850,4	-1 303,7	-453,3	53%	-370,7	-479,7	-568,1	-625,7	-553,4
Үүнээс: Нефтийн бүтээгдэхүүн	-184,5	-278,5	-94,0	51%	-74,6	-109,9	-150,3	-188,9	-136,6
Хүнсний бүтээгдэхүүн	-82,0	-151,5	-69,5	85%	-59,7	-22,3	-19,4	-91,9	-64,6
1.2 Мөнгөжөөгүй алт	169,1	107,7	-61,4	-36%	126,4	42,7	57,7	81,7	28,6
Кредит	169,1	107,7	-61,4	-36%	126,4	42,7	57,7	81,7	28,6
Дебит	0,0	0,0	0,0	0%	0,0	0,0	0,0	0,0	0,0
1.3 Бусад	-4,6	-16,9	-12,3	270%	-0,2	-4,3	-15,1	-5,8	-10,9
Кредит	2,1	0,5	-1,7	-78%	1,2	1,0	1,4	0,9	0,4
Дебит	-6,7	-17,3	-10,6	159%	-1,4	-5,3	-16,5	-6,8	-11,3
2. Үйлчилгээ	-83,5	-116,9	-33,4	40%	-46,8	-36,7	9,5	-69,2	-61,0
2.1 Тээвэр	-36,8	-41,8	-5,0	14%	-16,7	-20,2	-8,4	-22,4	-15,6
Кредит	66,2	72,1	5,9	9%	25,9	40,3	38,3	31,1	32,7
Дебит	-103,0	-114,0	-10,9	11%	-42,6	-60,5	-46,7	-53,6	-48,3
2.2 Аялал	-1,8	-7,9	-6,1	342%	-9,7	7,9	40,5	-13,8	-13,7
Кредит	79,5	92,0	12,4	16%	24,7	54,9	108,5	47,2	29,8
Дебит	-81,3	-99,8	-18,5	23%	-34,4	-46,9	-68,1	-61,0	-43,4
2.3 Бусад үйлчилгээ	-44,9	-67,2	-22,3	50%	-20,4	-24,5	-22,6	-32,9	-31,7
Кредит	22,3	26,1	3,8	17%	8,2	14,1	11,5	9,8	8,4
Дебит	-67,2	-93,3	-26,1	39%	-28,7	-38,5	-34,1	-42,8	-40,1
B. Орлого	-54,6	-116,5	-61,9	113%	-30,6	-24,0	-50,3	-90,5	-36,4
C. Урсгал шилжүүлэг (цэвэр)	79,7	88,8	9,1	11,4%	35,6	44,1	56,5	49,4	34,2
				0%					
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл	132,7	490,4	357,7	270%	9,6	123,1	325,2	310,9	186,2
A. Хөрөнгийн данс	82,8	69,6	-13,2	-16%	38,3	44,5	42,7	35,0	28,7
Кредит	82,8	69,7	-13,1	-16%	38,3	44,5	42,7	35,0	28,8
Дебит	0,0	-0,1	-0,1	0%	0,0	0,0	0,0	0,0	-0,1
B. Санхүүгийн данс	49,9	420,9	371,0	743%	-28,7	78,6	282,5	275,9	157,5
1. Шууд хөрөнгө оруулалт	112,4	598,3	485,9	432%	102,0	10,4	171,0	286,4	182,1
1.1 Гадагш хийсэн	-66,2	-13,5	52,7	-80%	-19,6	-46,6	15,1	-2,8	-10,8
1.2 Монголд орсон	178,6	611,8	433,2	243%	121,6	57,0	155,8	289,2	192,9
2. Санхүүгийн хөрөнгө оруулалт	82,6	-157,2	-239,8	-290%	-41,8	124,4	-71,2	-93,5	-80,4
2.1 Актив	2,9	-39,0	-41,8	-1465%	-49,4	52,2	-45,9	-95,7	-33,5
2.2 Пассив	79,7	-118,2	-198,0	-248%	7,6	72,1	-25,3	2,2	-46,9
3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл (цэвэр)	0,0	0,0	0,0	0%	0,0	0,0	0,0	0,0	0,0
3.1 Актив	0,0	0,0	0,0	0%	0,0	0,0	0,0	0,0	0,0
3.2 Пассив	0,0	0,0	0,0	0%	0,0	0,0	0,0	0,0	0,0
4. Бусад хөрөнгө оруулалт	-145,1	-20,2	124,9	-86%	-88,9	-56,1	182,7	83,0	55,8
4.1 Актив	-111,0	-73,9	37,1	-33%	-30,9	-80,1	-23,3	-10,6	61,3
4.2 Пассив	-34,1	53,8	87,8	-258%	-58,0	24,0	206,0	93,5	-5,6
				0%					
III. Алдаа болон орхигдуулга	127,1	-207,4	-334,5	-263%	56,4	70,7	-39,2	40,6	-93,7
Төлбөрийн тэнцлийн нийт дүн	107,2	126,1	18,9	18%	-25,6	132,8	220,6	227,7	-36,3
				0%					
IV. Гадаад валютын цэвэр нөөцийн өөрчлөлт	-107,2	-126,1	-18,9	18%	25,6	-132,8	-220,6	-227,7	36,3
1. Актив	-217,9	-146,7	71,2	-33%	27,7	-245,6	-243,9	-251,1	15,1
1.1 Мөнгөжсөн алт	0,0	0,0	0,0	0%	0,0	0,0	27,0	0,0	0,0
1.2 Зээлжих тусгай эрх	-0,1	5,4	5,6	-3991%	-0,7	0,6	-77,4	1,1	3,0
1.3 ОУВС-д байршуулсан хөрөнгө	0,0	0,0	0,0	-654%	0,0	0,0	0,0	0,0	0,0
1.4 Бэлэн валют ба харилцах	-207,3	-132,4	74,9	-36%	40,8	-248,1	-199,2	-250,1	20,1
1.5 Бусад нөөц актив	-10,4	-19,7	-9,3	89%	-12,4	2,0	5,8	-2,1	-7,9
2. Пассив	110,6	20,6	-90,1	-81%	-2,1	112,7	23,3	23,3	21,2
2.1 ОУВС-ийн зээл	110,6	20,6	-90,1	-81%	-2,1	112,7	23,3	23,3	21,2
2.2 Онцгой санхүүжилт	0,0	0,0	0,0	0%	0,0	0,0	0,0	0,0	0,0

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ТӨСӨӨЛӨЛ, 2010-2011 он /сая ам.доллараар/

Үзүүлэлтүүд	2007	2008	2009	2010				2011	
	Жилийн	Жилийн	Жилийн	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал	Жилийн	Жилийн
I. Урсгал Тэнцэл (А+Б+В)	171.8	-707.7	-341.8	-128.8	-28.1	-347.8	-389.8	-894.5	-734.1
А. Бараа ба үйлчилгээний худалдаа(а+b)	57	-738.0	-332.0	-126.6	-2.6	-278.4	-344.2	-751.8	-544.6
а. Бараа (1-2)	-52.4	-627.2	-188.8	-65.7	53.3	-235.7	-279.4	-527.5	-434.0
1. Экспорт Ф.О.Б.	1950.7	2529.1	1885.4	499.0	809.7	707.6	632.4	2648.7	3338.6
1.1. Зэсийн баяжмал	811.5	835.7	501.8	182.7	201.0	192.5	174.5	750.7	801.5
1.2. Мөнгөжөөгүй алт	234.9	599.9	308.5	28.6	79.1	28.8	60.4	196.9	207.8
1.3. Бусад	904.3	1093.6	1075.1	287.7	529.6	486.3	397.5	1701.1	2329.3
2. Импорт Ф.О.Б	2003.1	3156.3	2074.2	564.7	756.3	943.3	911.8	3176.1	3772.6
б. Үйлчилгээ (1+2+3+4+5+6)	109.4	-110.8	-143.2	-61.0	-55.9	-42.6	-64.8	-224.4	-110.6
1. Тээвэр /цэвэр/	66.8	-93.5	-67.7	-15.6	-26.2	-39.4	-30.4	-111.7	14.7
2. Аялал /цэвэр/	110.7	29.6	24.9	-13.7	5.8	24.7	-6.7	10.1	-16.6
3. Харилцаа холбооны үйлчилгээ /цэвэр/	4.1	-5.4	-12.2	-6.7	-6.4	1.1	-2.2	-14.2	-7.1
4. Барилгын ажил /цэвэр/	-19.9	1.8	0.9	-0.5	0.4	-1.9	-2.4	-4.4	-12.2
5. Даатгалын үйлчилгээ /цэвэр/	-10.3	-11.6	-10.2	-2.2	-3.1	-5.5	-4.7	-15.4	-7.9
6. Бусад үйлчилгээ /цэвэр/	-42	-31.7	-78.9	-22.2	-26.4	-21.7	-18.5	-88.8	-81.5
Б. Цэвэр орлого (а+б)	-97.5	-156.9	-195.4	-36.4	-80.1	-88.6	-69.6	-274.8	-291.9
а. Ажиллагсдын цалин хөлс /цэвэр/	3.8	-13.9	-3.9	2.4	-3.0	2.4	2.4	4.1	-1.5
б. Хөрөнгө оруулалтын орлого /цэвэр	-101.3	-143.0	-191.5	-38.7	-77.1	-91.0	-72.0	-278.8	-290.4
В. Урсгал шилжүүлэг (а+б+в)	212.3	187.3	185.7	34.2	54.6	19.2	24.0	132.1	102.4
а. Засгийн газрын шилжүүлэг /цэвэр/	108.2	-0.9	59.5	9.7	10.2	-1.0	-1.0	17.8	-4.2
б. Ажилчдын гуйвуулга	83.9	68.9	120.1	22.3	26.0	12.7	17.0	77.9	68.0
1. Хүлээн авсан	174.3	218.2	191.5	48.5	55.1	48.0	48.2	199.8	194.9
2. Шилжүүлсэн	90.3	149.4	71.4	26.2	29.1	35.3	31.2	121.8	126.9
в. Бусад шилжүүлэг /цэвэр/	20.1	119.3	6.0	2.2	18.5	7.6	8.1	36.3	38.6
II. Хөрөнгө ба Санхүүгийн Тэнцэл (А+Б)	328.7	1342.7	768.8	186.2	304.3	574.3	394.7	1459.4	797.9
А. Хөрөнгийн данс	0	116.6	160.5	28.7	40.9	40.9	40.9	151.3	163.5
Б. Санхүүгийн данс (а+б+в)	328.7	1226.0	608.3	157.5	263.4	533.4	353.8	1308.1	634.4
а. Шууд хөрөнгө оруулалт /цэвэр/	360	831.5	569.8	182.1	416.2	443.6	343.0	1384.8	1460.2
б. Санхүүгийн хөрөнгө оруулалт	74.9	46.9	-82.1	-80.4	-76.9	0	-6.2	-163.4	2.5
в. Бусад хөрөнгө оруулалт	-106.2	347.6	120.6	55.8	-75.9	89.8	17.0	86.7	-828.3
1. Худалдааны зээл /цэвэр/	-13.2	0	14.4	-8.9	24.8	0	0	15.9	0.0
2. Зээл /цэвэр/	44.9	231.3	235.9	12.2	42.9	33.6	25.8	114.4	0.0
2.1 Урт хугацааны зээл	75.5	225.8	202.0	8.7	51.2	30.1	22.3	112.2	0.0
2.1.1 Актив	0.9	7.6	5.2	0.1	0.1	0	0	0.1	0.0
2.1.1.1 Засгийн газар	0	0.0	0	0	0	0	0	0.0	0.0
2.1.1.2 Бусад сектор	0.9	7.6	5.2	0.1	0.1	0	0	0.1	0.0
2.1.2 Пассив	74.6	218.2	196.8	8.6	51.2	30.1	22.3	112.1	0.0
2.1.2.1 Ашиглалт	160.9	332.4	365.3	41.5	76.2	83.5	80.9	282.0	0.0
2.1.2.1.1 Засгийн газар	81.9	78.0	211.1	7.9	6.7	31.3	28.6	74.6	0.0
2.1.2.1.2 Бусад сектор	79.1	254.4	154.2	33.5	69.5	52.2	52.2	207.4	0.0
2.1.2.2 Үндсэн өрийн төлбөр	86.3	114.2	168.5	32.8	25.0	53.4	58.6	169.9	0.0
2.1.2.2.1 Засгийн газар	29.4	39.4	61.4	7.2	12.3	11.7	16.8	47.9	0.0
2.1.2.2.2 Бусад сектор	56.9	74.8	107.1	25.6	12.8	41.8	41.8	121.9	0.0
2.2 Богино хугацааны зээл	-30.6	5.5	33.9	3.5	-8.3	3.5	3.5	2.2	0.0
3. Бэлэн мөнгө ба харилцах /цэвэр/	-109.5	114.6	-205.8	52.5	-143.6	56.2	-8.7	-43.7	-828.3
4. Бусад цэвэр актив	-28.4	1.7	76	0	0	0	0	0	0.0
III. Алдаа болон орхигдуулга	-212.4	-867.6	128.5	-93.7	-113.7	0	0	-207.4	0
IV. Нийт Төлбөрийн Тэнцэл (I+II+III)	288.0	-232.6	555.5	-36.3	162.4	226.5	4.9	357.4	63.9
V. Цэвэр нөөцийн өөрчлөлт -(А+Б-В)	-288.0	232.6	-555.5	36.3	-162.4	-226.5	-4.9	-357.4	-63.9
Цэвэр нөөц				1107.4	1138.4	1364.9	1369.8		
Зэсийн үнэ	7132	6963	5164	7245	7011	6611	6000	6717	7203
Түүхий нефтийн үнэ	71	97	61	79	78	86	92	84	97
Алтын үнэ	697	881	973	1111	1195	1123	1006	1109	1003

3.5. Гадаад валютын улсын албан нөөцийн эрсдэлийн удирдлага

Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийг түүний найдвартай байдлыг хангах, хөрвөх чадварыг алдагдуулахгүй байх, үр өгөөжийг нэмэгдүүлэх зарчмаар удирдаж байна. Дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн уналт саарч, санхүүгийн системийн байдал харьцангуй тогтворжиж байна. Гадаад зах зээлд валютын ханшийн хэлбэлзэл өндөр байсан, дотоодын зах зээлд ам.долларын хэрэгцээ өндөр байсан зэргээс хамаарч гадаад валютын улсын нөөцийн голлох хэсгийг богино хугацааны өндөр хөрвөх чадвар бүхий ам.доллараар илэрхийлэгдсэн хөрөнгө оруулалтуудад байршуулах чиглэлийг барьж ажиллалаа. Хэдийгээр гадаад валютын улсын нөөцийн хэмжээ нэмэгдсэн, богино хугацаат хөрвөх чадвар бүхий нөөцийн шаардлага харьцангуй багассан зэрэг нь нөөцийг илүү урт хугацаат хөрөнгө оруулалтад оруулах боломжийг бүрдүүлж байгаа ч Төв банкуудын хүү бага түвшинд хэвээр байгаа нь урт хугацаат хөрөнгө оруулалтын хүүний эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Гадаад валютын улсын нөөцийг зээлийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор “Гадаад валютын улсын нөөцийн удирдлагын журам”-д заасны дагуу нөөцийг байршуулах гадаад орны банк, санхүүгийн байгууллагуудын жагсаалт, тэдгээрт олгох лимитийг улирал бүр тогтоон ажиллаж байна. Нөөцийг хөрөнгө оруулалтын эрсдэлээс сэргийлэх үүднээс голчлон АНУ-ын засгийн газрын үнэт цаас, АНУ, Герман, Япон, Их Британи, Франц зэрэг орнуудын төв банкуудын харилцах, хадгаламж, Олон улсын төлбөр тооцооны банкны үнэт цаас, хадгаламжид байршуулав.

Мөн харилцагчийн эрсдэлээс сэргийлэх зорилгоор засгийн газар, төв банк, Олон улсын төлбөр тооцооны банк, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зэрэглэл тогтоогч байгууллагаас тогтоосон зөвхөн АА зэрэглэлээс дээш зэрэглэл бүхий дэлхийн банк, санхүүгийн байгууллагуудтай гадаад валютын нөөцийн удирдлагын хүрээнд хамтран ажиллаж байна. Санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдалтай холбоотой системийн эрсдэл өндөр байгаа тул гадаад орны арилжааны болон хөрөнгө оруулалтын банк, санхүүгийн байгууллагуудад хөрөнгө байршуулахаас татгалзаж ажиллаа. Гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг сайжруулах зорилгоор Дэлхийн банк, Олон Улсын Төлбөр Тооцооны Банкнаас гишүүн орнуудын төв банкуудад үзүүлдэг хөрөнгийн удирдлагын үйлчилгээний хүрээнд тэдгээр байгууллагуудтай хамтран ажиллах талаар санал солилцож байна.

4. САНХҮҮГИЙН САЛБАР, БАНКНЫ ЗУУЧЛАЛЫН ТОЙМ

4.1. Банкны салбарын үндсэн үзүүлэлтүүд

Монгол улсын банкны салбар 14 банк, хоёр эрх хүлээн авагч томилогдсон банкны нийт 1045 салбар нэгж, 9800 ажилтантайгаар ажиллаж байна. Банкуудын нийт харилцагчдын тоо 2010 оны 08 дугаар сарын байдлаар 2.9 сая болж өмнөх оны мөн үеэс 9.2 хувиар өссөн байна. Нийт хадгаламж эзэмшигчид, зээлдэгчдийн тоо 16.1, 1.5 хувиар тус тус өссөн байна.


Харилцагч, хадгаламж эзэмшигчдийн тоо түргэн нэмэгдсэн нь банк, санхүүгийн салбар дахь санхүүгийн зуучлал, үйл ажиллагааг өргөтгөх таатай нөхцлийг бүрдүүлж байгаа бөгөөд 2010 оны 8 дугаар сарын байдлаар нийт банкны салбарын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 4.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1 их наяд төгрөгөөр өссөн нь үүний илрэл юм. Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлтөөс үүдэлтэйгээр банкууд эх үүсвэрийг оновчтой активт байршуулж санхүүгийн голлох эрсдэлүүд болох зээл, хөрвөх чадвар болон зах зээлийн эрсдэлээс урьдчилан хамгаалах нь чухал асуудал байдаг ба банкны салбарын нийт актив 2010 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 4.9 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 21.1 хувиар буюу 1 их наяд төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Банкууд татан төвлөрүүлсэн хөрөнгөө хөрвөх чадвар өндөртэй активт байршуулах нь олон улсын санхүүгийн зах зээлийн хямралын нөлөөлөлтэй байгаа нөхцөлд гэнэтийн гарах урсгалд төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа болж байна. Банкны тухай хууль тогтоомж, холбогдох заавар журмын хязгаарлалтыг ханган биелүүлэх чадваргүй болсон Зоос банкинд Монголбанкнаас 2009 оны 11 дүгээр сард эрх хүлээн авагч томилсон бөгөөд сайн активуудыг шилжүүлэн шинээр төрийн эзэмшлийн банк үүсгэн байгуулсан. Тухайн үед банкны салбарын хэмжээнд харилцах, хадгаламжийн хэмжээ өсч байсан нь Монгол Улсын Их хурлаас “Банк дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-ийг 2008 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр батлан гаргасантай холбоотой байсан ба нөгөө талаас харилцагч, хадгаламж эзэмшигч нарын банкинд итгэх итгэл тогтвортой байсныг харуулсан.


Өнөөгийн байдлаар банкны салбарын нийт активын хэмжээ 4.9 их наяд төгрөгт хүрч өмнөх оны 8 дугаар сараас 1 их наяд төгрөгөөр өсчээ. Активын хэмжээ нэмэгдэхийн хирээр банкуудын цар хүрээ, үйл ажиллагаа өргөжиж байгаа нь өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх юм. Банкуудын зээл олголт эрчимжээгүй хэдий ч нийт хүүгийн орлого өмнөх оны 8 дугаар сартай харьцуулахад 33.1 тэрбум төгрөгөөр өссөн ба нийт салбарын хэмжээнд ашигт ажиллагаа сайжирсан байна.

Монгол Улсын Их хурлаас 2010 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр “Банкны тухай хууль” шинэчлэн найруулагдаж батлагдсан бөгөөд хуулийн шинэчлэлтэй холбогдуулан бусад заавар журмыг шинэчлэн баталж, холбогдох хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг авч хэрэгжүүлээд байна. Мөн олон улсад нэр хүнд бүхий аудитын байгууллагуудаар зарим банкуудад тусгайлсан үнэлгээ хийлгэж банкуудад газар дээрх шалгалт хийн үйл ажиллагааг үнэлэн, дүгнэлт өгсөн.

Зураг 4.1 Банкны салбарын нийт зээл ба чанаргүй зээлийн үзүүлэлтүүд



Зураг 4.2 Банкны салбарын зээлийн багцын эдийн засгийн ангилал



** Нийт олгосон зээлд эзлэх хувь хэмжээгээрээ бага дүнтэй үлдсэн салбарууд болон бусад зээлийн дүнг оруулаагүй болно.

I. Худалдаа, Засвар	18.5%
II. Боловсруулах Үйлдвэрлэл	16.5%
III. Барилга	15.4%
IV. Уул Уурхай	13.4%
V. Үл Хөдлөх Хөрөнгийн	7.4%
VI. Хөдөө Аж Ахуй	5.0%

I. Байр, Сууц	2.8%
II. Тээвэр Ба Агуулах	2.4%
III. Захиргааны Болон Дэмжлэг	1.2%
IV. Санхүүгийн Болон Даатгал	0.9%
V. Боловсрол	0.9%
VI. Хүний Эрүүл Мэнд Ба Нийгэм	0.9%

Зураг 4.3 Харилцах, хадгаламж болон ДНБ-д эзлэх хэмжээ



Нийт олгосон зээлийг эдийн засгийн салбараар задалж үзвэл голлох 4 салбар нийт зээлийн 63.8 хувийг авсан байна. 2010 оны 2 дугаар улирлыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад Худалдаа, засвар үйлчилгээ (-1.8%), Хөдөө аж ахуй (-0.7%) салбаруудын зээл буурч, Боловсруулах үйлдвэрлэл (0.1%), Барилга (0.1%), Үл хөдлөх хөрөнгө (0.1%) салбарууд тогтвортой, Уул, уурхайн (5.3%) салбарт зээл олголтийн хэмжээ өссөн байна. Манай орны голлох салбар болох уул уурхайн салбарт олгосон зээл нэмэгдсэн нь банкууд эрсдэлийг харьцангуй бага хэмээн үзэж байгаатай холбоотой бөгөөд цаашид тус салбарт хөрөнгө оруулалт нэмэгдэх магадлалтай байна.

4.2. Хөрөнгө, эх үүсвэрийн бүтэц

Банкны салбарын нийт мөнгөн хөрөнгө 2010 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 121.5 тэрбум төгрөгөөр, төв банкны үнэт цаас 417.5 тэрбум төгрөгөөр өссөн нь нийт активын өсөлтийн 51.3 хувийг эзэлж, активын өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл боллоо. Өнгөрсөн хугацаанд банкуудын ашигт ажиллагаанд нөлөөлсөн, хүүний орлогыг нэмэгдүүлсэн орлого нь төв банкны үнэт цаасны хүүний орлого (23.3 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн) байлаа. Эдийн засгийн байдал бүрэн тогтворжоогүй байгаа учраас бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчдэд хүндрэл үүссэн хэвээр байна. Үүний улмаас зээлийн чанар төдий сайжирахгүй, эрсдэл өндөр хэвээр байна. Гэхдээ 2010 оны 05 дугаар сараас эхлэн банкуудын зээл олголт нэмэгдэж, ба чанаргүй зээлийн хэмжээ буурч эхэллээ. 2009 оны 8 дугаар сараас 2010 оны 4 дүгээр сар хүртэл нийт зээл 130 тэрбум төгрөгөөр өссөн бол 2010 оны 5 дугаар сараас хойш 252 тэрбум төгрөгөөр өсчээ. Зээл төлөхөд учирч болзошгүй эрсдэлийн сангийн нийт хэмжээ өссөн хэдий ч чанаргүй зээлийн хэмжээ энэ оны 2 дугаар сараас эхлэн буурсаар байна. 2010 оны 8 дугаар

сарын байдлаар чанаргүй зээл нийт зээлийн 14 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны эцсээс 6 хувь, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар буурчээ.

Банкуудын татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж хувийн секторын харилцах данс өндөр өсөлттэй байлаа. Нийт харилцах татан төвлөрүүлсэн хөрөнгийн 28.6 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны 08 сартай харьцуулахад 6.6 хувиар өсчээ. Иргэдийн хугацаагүй, хугацаатай хадгаламжийн хэмжээ 2010 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 509.6 тэрбум төгрөгөөр нэмэгдэн 1.9 их наяд төгрөгт хүрчээ. 2009 оны 11 дүгээр сараас эхлэн банк хоорондын захын идэвх сайжирсан ба дотоодын банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 63.9 тэрбум төгрөгөөр өсч нийт арилжааны хэмжээ 200 гаран тэрбумд хүрэв.

Зохистой харьцааны үзүүлэлт


Өөрийн хөрөнгийн зохистой харьцаа

Банкуудын дүрмийн сангийн хэмжээ 2010 оны 8 дугаар сарын байдлаар өмнөх онтой харьцуулахад 49.6 тэрбум төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь Хадгаламж, Монгол шуудан банкныг нэгтгэн авсан, төрийн эзэмшлийн Төрийн банкыг үүсгэн байгуулсан, жижиг банкууд дүрмийн сангаа нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор өссөн юм. Банкуудын тухайн жилийн ашигт ажиллагаа сайжирсан нь өөрийн хөрөнгийн хэмжээнд эергээр нөлөөлсөн ба оны эхний 8 сарын байдлаар банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 285.1 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 13 хувиар буюу 32.9 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцаа оны эхний 8 сарын байдлаар 7.7 хувь байгаа ба Монголбанкнаас эрх хүлээн авагч томилогдсон банкуудын үзүүлэлтийг хасч тооцвол 15 хувьтай байна.


Хөрвөх чадварын үзүүлэлт

Банкны салбарын төлбөрийн чадварын харьцаа 2010 оны 8 сарын байдлаар 37.3 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 4.1 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Төлбөрийн чадвар сайжирч байгаа нь банкууд хөрвөх чадвартай активд эх үүсвэрийг илүүтэй байршуулж байгаагаар холбоотой байна. Салбарын хэмжээнд актив болон пассивыг эргэн төлөгдөх хугацаагаар нь авч үзвэл нийт активын 28.5 хувь нь 1 жилээс дээш хугацаатай хөрөнгөд байршсан байгаа бол нийт пассивын 91.5 хувь нь 1 жил хүртэлх хугацаатай байна. Нийт активын эргэн төлөгдөх дундаж хугацаа 271 хоног, нийт пассивын эргэн төлөгдөх дундаж хугацаа 113 хоногтой байна.


Зураг 4.4 Активын бүтэц



Зураг 4.5 Эх үүсвэрийн бүтэц



Зураг 4.6 Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, тэрбум төгрөг



4.3 Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаа

Монголбанк санхүүгийн тогтвортой байдлыг хангах, банк, санхүүгийн байгууллагын зээлийн эрсдэлийг бууруулах зорилгоор Зээлийн мэдээллийн сан /цаашид ЗМС гэх/-г банк, санхүүгийн байгууллагаас зээлдэгчид болон тэдгээр зээлдэгчдийн зээлийн талаарх мэдээллийг авч, эргээд тус сангийн мэдээллээр банк, санхүүгийн байгууллагуудыг хангах байдлаар ажиллуулж байна. Одоогийн байдлаар ЗМС-тай бүх банкууд, зээл, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа идэвхтэй эрхлэдэг томоохон 12 банк бус санхүүгийн байгууллага /цаашид ББСБ/ болон Орон сууцны санхүүжилтийн корпораци хамтран ажиллаж, мэдээллийг тогтмол солилцож байна. Монголбанкны зүгээс цаашид хамтран ажиллах байгууллагын тоог өсгөн, ЗМС-гийн хамрах хүрээг өргөтгөх чиглэлээр тогтмол анхаарч ажиллана.

Монголбанкны ЗМС-д 2010 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 29 зээлдүүлэгч байгууллагаас ирүүлсэн 462,804 ширхэг зээлдэгчид хамаарах 3,276.2 тэрбум төгрөгийн идэвхтэй зээлийн мэдээлэл бүртгэгдсэн байгаагаас нэг тэрбум төгрөг хүртэл үлдэгдэлтэй 462,290 ширхэг зээл байна. Энэхүү нэг тэрбум төгрөг хүртэлх зээлийн мэдээллийн үлдэгдэл дүнгээр нь 6 ангилж хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 4.1 ЗМС дахь 1 тэрбум төгрөг хүртэлх зээлийн судалгаа(сая.төгрөгөөр)

Д/д	Зээлийн үлдэгдэл	Зээлийн дүн	Нийт зээлд эзлэх хувь	Зээлийн тоо	Нийт зээлд эзлэх хувь
1	0-10 сая	560,520.9	33.6	436,242	94.4
2	10-50 сая	487,230.5	29.2	22,723	4.9
3	50-100 сая	113,420.5	6.8	1,641	0.4
4	100-200 сая	105,458.9	6.3	765	0.2
5	200-500 сая	203,889.6	12.2	633	0.1
6	500 сая-1 тэрбум	198,774.7	11.9	286	0.1
	Нийт	1,669,295.1		462,290	

Зээлдэгчдийн хувьд 50 сая төгрөг хүртэлх зээлтэй зээлдэгчид нийт зээлдэгчдийн 99.2 хувийг эзэлж байгаа бөгөөд эдгээр зээлдэгчдийн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн 32 хувьтай тэнцүү байна. Банк, санхүүгийн байгууллагуудын хувьд ЗМС-гаас авч буй мэдээлэл нь ихээхэн ач холбогдолтой, зээл олгох шийдвэр гаргахдаа тогтмол ашигладаг мэдээлэл болоод байгаа юм. Тухайлбал 2010 оны 3 дугаар улиралд ЗМС-гаас хэрэглэгч байгууллагууд өдөрт дунджаар 4500 орчим иргэд, байгууллагын зээлийн мэдээллийн лавлагааг авчээ. Энэ тоо өдөр ирэх тусам өсөн нэмэгдэж байна. Иймд Монголбанкны зүгээс мэдээллийн чанарыг

сайжруулах, ЗМС-гийн үйл ажиллагааг боловсронгуй, шуурхай болгох, мэдээллийн чанарыг сайжруулахад анхаарч ажиллаж байна. ЗМС-гийн програм хангамжийг 2009 онд шинэчлэн боловсруулж ашиглалтад орууллаа. Үүний дүнд ЗМС-гаас банк, санхүүгийн байгууллагууд мэдээлэл авах, ЗМС-д мэдээлэл илгээх үйл ажиллагаа 24 цагийн туршид онлайн горимд шилжлээ. Мөн хэрэглэгч нь мэдээллийг тусгай програм хангамжийн тусламжтайгаар бус интернэтийн холболт бүхий газраас авах боломжтой болсноор өсөн нэмэгдэж буй хэрэглэгч байгууллагуудын хэрэгцээг чанартай мэдээллээр хангах нөхцлийг бүрдүүлсэн алхам болсон юм. Цаашид Монголбанкны зүгээс ЗМС-гийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгох чиглэлээр 2010-2011 онуудад дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна. Үүнд:

1. ЗМС-гийн програмын шинэчлэлт хийсэн, зарим зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор ЗМС-гийн журмыг шинэчлэх;
2. СЗХ-тай хамтран эхлүүлсэн бүх ББСБ болон хадгаламж зээлийн хоршоодыг ЗМС-д хамруулах ажлыг үргэлжлүүлж, ЗМС-д хамрагдсан бичил санхүүгийн байгууллагуудын тоог 2 дахин нэмэгдүүлэх;
3. Засгийн газраас санаачилсан Бүртгэлийн нэгдсэн тогтолцооны үндэсний хөтөлбөрийн хүрээнд ЗМС-г бусад төрлийн мэдээллийн сангуудтай холбох ажлыг эрх бүхий төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

4.4 Төлбөр тооцооны систем

Монгол улсад банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог бодит цагийн горимд гүйцэтгэх “Банксүлжээ систем”-ийг нэвтрүүлэх ажлыг Дэлхийн банкны төслөөр хэрэгжүүлж, тус системийг 2009.06.02-ны өдөр албан ёсоор нээсэн. “Банксүлжээ” систем нь банкуудаас илгээсэн гүйлгээ бүрийг тухайн цаг мөчид хүлээн авагч банк руу дамжуулан, үр дүнг бодит цагаар тооцсноор банкууд, Монголбанк төдийгүй нийт харилцагчдын хувьд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал,

- Системийн оролцогчид болох банкууд, Сангийн Яамны Төрийн сангийн газарт өдрийн турш Монголбанк дахь өөрийн харилцах дансны үлдэгдэл, төлбөр тооцооны эрсдэлээ хянах, заавал байлгах нөөцийн шаардлагыг ханган ажиллах, өөрийн активыг зохистой удирдах боломжийг олгосон;
- Банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулж, хяналт тавих байгууллага нь Монголбанк юм. Бид энэ системийн ашиглан төлбөрийн системийг аль нэг оролцогчийн төлбөрийн чадварын доройтлоос хамгаалах, өдрийн гүйлгээний эцэст үр дүнгийн тооцоо хийгдэхэд учирч болзошгүй системийн эрсдэлийг бууруулах, төлбөрийн системийн

нууцлал, аюулгүй байдал, боловсруулалтын чадамжийг нэмэх, төлбөрийн бүх төрлийн систем (үнэт цаас, валютын арилжаа, бага дүнтэй төлбөр тооцоо гэх мэт)-ийг холбох үндсэн системийг бий болгох ажлыг хийж байна;

- Нийт харилцагчдын хувьд, тэдгээрийн мөнгөн хөрөнгийн шилжүүлэг бодит цагаар буюу төлбөр гүйцэтгэгч банкнаас төлбөр хүлээн авагч банкинд хэдхэн хормын дотор хийгдэх боломж бүрдсэн.

Энэхүү системийг нэвтрүүлснээс хойш нэг жилийн (2009.6.01-2010.6.01) хугацаанд 465.5 мянган ширхэг 38.3 их наяд төгрөгийн гүйлгээг хүлээн авч дамжуулсан байна. Банк хоорондын гүйлгээний 2009 оны жилийн эцсийн судалгаанаас харахад их дүнтэй гүйлгээ нь нийт гүйлгээний тоо ширхэгийн 15.9 хувийг эзэлж байгаа ч гүйлгээний дүнгийн дийлэнх буюу 97.5 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4.2 Банк хоорондын гүйлгээний тоо, дүн, мянган ширхэг, тэрбум төгрөг

	2007				2008				2009*			
	тоо	%	дүн	%	тоо	%	дүн	%	тоо	%	дүн	%
Бүгд	1827	100	8145	100	2258	100	10648	100	2662	100	11368	100
Бага дүнтэй	1517	83.0	201	2.5	1851	82.0	261	2.5	2238	84.1	285	2.5
Их дүнтэй	310	17.0	7944	97.5	407	18.0	10387	97.5	424	15.9	11083	97.5

**Монголбанкнаас банк хоорондын сүлжээгээр банкууд руу дамжуулсан гүйлгээний тоо болон дүнг оруулан тооцсон.*

Банк хоорондын их дүнтэй төлбөр тооцооны “Банксүлжээ” систем

“Банксүлжээ” системийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах зорилгоор Монголбанкны төв байруудад “Үндсэн”, “Дэд”, “Туршилт”-ийн орчинг бүрдүүлсэн бөгөөд “Үндсэн” орчинд ямар нэгэн саатал учирсан тохиолдолд “Дэд” орчин нь төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангахаар зохион байгуулсан. Түүнчлэн гэнэтийн осол, давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр Монголбанкны төв байрууд дахь систем ажиллах боломжгүй болсон нөхцөлд төлбөрийн системийн ажиллагааны тасралтгүй байдлыг хангах “Зайн нөөц төв”-ийг газар зүйн алслагдмал байршилд байгууллаа. Хэдийгээр онцгой байдлын үед “Зайн нөөц төв”-д “Банксүлжээ” системийн Монголбанкнаас хамаарах ажиллагааг шилжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн ч, системийн нийт оролцогчдын “Зайн нөөц төв”-д холбогдох холболтын орчныг бүрдүүлэхийн тулд банкуудтай хамтран ажиллахаар төлөвлөөд байна.

Банк хоорондын бага дүнтэй төлбөр тооцооны систем

Монголбанкны бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны сүлжээгээр 2010 оны эхний хагас жилийн байдлаар нийт 160.2 тэрбум төгрөгийн 1.4 сая ширхэг гүйлгээ дамжив. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гүйлгээний дүн 32.4 тэрбум төгрөг буюу 25.3 хувиар, тоо ширхэг 342.9 мянга буюу 33 хувиар тус тус өсчээ.

Төлбөрийн картын хэрэглээ

Төлбөрийн картын ашиглалтыг нэмэгдүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах, зардлыг багасгах, хямд, хурдан шуурхай үйлчилгээг хүргэх, картын нэгдсэн сүлжээ, зохицуулалтыг бий болгох зорилгоор Монголбанкнаас төлбөрийн картын гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулдаг “Банк хоорондын картын төлбөр тооцооны нэгдсэн сүлжээ (клиринг)”-г нэвтрүүлэх ажлын хүрээнд ХААН банк, Худалдаа хөгжлийн банкттай хамтран “Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ” бий болгох тухай “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2010 оны 5 дугаар сарын 15-ны өдөр байгуулан, нэг сарын хугацаанд туршилтын ажлыг амжилттай хийж гүйцэтгэлээ.

“Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээ”-г 2010 оны 6 дугаар сарын 16-ны өдөр албан ёсоор нээж, төлбөрийн картаар хийсэн гүйлгээг банк хооронд 24 цагаар тасралтгүй дамжуулах клирингийн үйлчилгээг нэвтрүүлээд байна. Нэгдсэн сүлжээг нэвтрүүлснээс хойш 2010.5.15-2010.9.01 хүртэлх хугацаанд нийт 5.4 тэрбум төгрөгийн 102.9 мянган ширхэг төлбөрийн картын гүйлгээг дамжуулсан байна. Сүлжээгээр АТМ, ПОС, ПОБ төхөөрөмжөөр бэлэн мөнгө авалт, бэлэн мөнгө авалтын буцаалт, бэлэн мөнгө авалтын хэсэгчилсэн буцаалт, худалдан авалт, худалдан авалтын буцаалт, үлдэгдэл шалгах гэсэн 6 төрлийн гүйлгээ хийж байна.

Хүснэгт 4.3 Банк хоорондын төлбөрийн картын нэгдсэн сүлжээгээр хийгдсэн гүйлгээний дүн, тоо, сая төгрөг

д/д	Гүйлгээний төрөл	АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээ		ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээ		ПОС терминалаар хийгдсэн гүйлгээ	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Үлдэгдэл шалгах	30,642	-	1,875	-	94	-
2	Бэлэн мөнгө авалт	42,532	3,479.1	3,93	884.3	-	-
3	Бэлэн мөнгө авалтын буцаалт	214	32.4	22	2.1	-	-
4	Бэлэн мөнгө авалтын хэсэгчилсэн буцаалт	2	0.4	-	-	-	-
5	Худалдан авалт	-	-	-	-	23,473	1,034.3
6	Худалдан авалтын буцаалт	-	-	-	-	211	8.0
Нийт		73,390	3,447.1	5,827	882.2	23,778	1,026.3

Төлбөрийн картын хэрэглээний 2009 оны жилийн эцсийн судалгаанаас харахад карт эзэмшигчийн тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 702.6 мянга буюу 59.4 хувиар, карт идэвхтэй ашиглагчдын тоо 5.5 мянга буюу 1.2 хувиар тус тус өсчээ.

Хүснэгт 4.4 Карт эзэмшигчид, карт ашиглагчдын тоо (өссөн дүнгээр)

Д/Д	Карт эзэмшигч/ идэвхтэй ашиглагч	2008 он	2009 он	2009 он
				2008 он
1	Карт эзэмшигчдийн тоо	1,182,526	1,885,103	59.4%
2	Карт идэвхтэй ашиглагчдын тоо*	470,773	476,230	1.2%

* Карт идэвхтэй ашиглагчид гэж сард 5-аас доошгүй удаа гүйлгээ хийдэг карт эзэмшигчид.

Төхөөрөмжийн хувьд 2009 онд ПОС терминалын тоо өмнөх оны мөн үеийнхээс 694 ширхэг буюу 22.7 хувиар, АТМ төхөөрөмж 103 ширхэг буюу 54.5 хувиар тус тус өссөн боловч ПОБ терминал 113 ширхэг буюу 8.7 хувиар, импринтер төхөөрөмж 93 ширхэг буюу 19.8 хувиар тус тус цөөрсөн үзүүлэлттэй байна. ПОС терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 2009 онд 100.3 тэрбум төгрөгт хүрч өмнө оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар өсч, гүйлгээний тоо 0.1 сая буюу 1.6 хувиар буурсан, ПОБ терминалаар хийгдсэн гүйлгээний дүн 453.8 тэрбум төгрөгт хүрч 4.3 хувиар, гүйлгээний тоо 0.9 сая буюу 21.8 хувиар тус тус буурсан, АТМ төхөөрөмжөөр хийгдсэн гүйлгээний дүн 874.6 тэрбум төгрөгт хүрч 36.4 хувиар, гүйлгээний тоо 6.1 саяар буюу 67 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь карт эзэмшигчид картаар төлбөр хийхээс илүүтэй картын данснаасаа бэлэн мөнгө авч, бараа үйлчилгээний төлбөрт хэрэглэх сонирхол нэмэгдэж байгааг харуулж байна.

Хүснэгт 4.5 ПОС, ПОБ, АТМ төхөөрөмжийн тоо, хийгдсэн гүйлгээний дүн, тоо, тэрбум төг. сая ширхэг

Төхөөрөмж	Төхөөрөмжийн тоо			Гүйлгээний мэдээ	Хийгдсэн гүйлгээ		
	2008 он	2009 он	2009 он		2008 он	2009 он	2009 он
			2008 он				2008 он
ПОС терминал	3 060	3 754	22.7%	дүн	94	100.3	6.6%
				тоо	1.8	1.7	-1.6%
ПОБ терминал	1 299	1 186	-8.7%	дүн	473.8	453.5	-4.3%
				тоо	4.1	3.2	-21.8%
АТМ төхөөрөмж	189	292	54.5%	дүн	641.1	874.6	36.4%
				тоо	9.1	15.2	67.0%
Импринтер төхөөрөмж	470	377	-19.8%				
Нийт	5 018	5 609	11.8%	дүн	1208,9	1428.4	18.2%
				тоо	15	20.1	34%

4.5 Банкны эрх зүйн шинэчлэл

